

An aerial photograph of a lush green valley with a winding river. The river flows from the top left towards the bottom right, curving through the landscape. The surrounding hills are covered in vibrant green grass. In the top left corner, a small beach and turquoise ocean are visible. A solid yellow vertical bar is positioned on the left side of the image.

МОНГОЛ УЛСЫН  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ОРЧНЫ СУДАЛГАА-  
УРЬДЧИЛСАН ТАЙЛАН

<b>2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛБАР СҮҮЛИЙН ХЭДЭН АРВАН ЖИЛД .....</b>	<b>2</b>
<b>3. ФРЕЙЗЕРИЙН СУДАЛГАА БОЛОН УУСОТС-Н ДАХЬ МОНГОЛ УЛСЫН ГҮЙЦЭТГЭЛ.....</b>	<b>6</b>
<b>4. ФРЕЙЗЕРИЙН СУДАЛГАА БОЛОН УУСОТС-НЫ ҮНДСЭН ДЭЭР ХАРЬЦУУЛАХ БОЛОМЖТОЙ УЛС ОРНУУДАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ.....</b>	<b>17</b>
<b>5. ЗӨРҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ .....</b>	<b>26</b>
<b>6. МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН СВОТ-ЫН ШИНЖИЛГЭЭ.....</b>	<b>31</b>
<b>7. КЕЙСИЙН СУДАЛГАА .....</b>	<b>39</b>
<b>8. ГШХО-ЫН ХАРЬЦУУЛАЛТ .....</b>	<b>53</b>
<b>9. АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>	<b>57</b>
<b>10. ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТАЙЛАН .....</b>	<b>78</b>
<b>ХАВСРАЛТ1: ФРЕЙЗЕРИЙН СУДАЛГАА БОЛОН УУСОТС-НЫ АСУУЛТУУД .....</b>	<b>81</b>
<b>ХАВСРАЛТ 2: ФРЕЙЗЕРИЙН СУДАЛГАА (2011-2017) БОЛОН УУСОТС (2021)-НЫ ХҮСНЭГТ ДЭХ ӨГӨГДЛҮҮД .....</b>	<b>83</b>
<b>ХАВСРАЛТ 3: ХАРЬЦУУЛАХ БОЛОМЖТОЙ УЛС ОРНУУДЫН СУДАЛГААНЫ ХАРИУЛТУУД.....</b>	<b>86</b>
<b>ХАВСРАЛТ 4: УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН (УУСОТС).....</b>	<b>89</b>

# 1. ОРШИЛ

Монгол улсын уул уурхайн салбар, ханган нийлүүлэлтийн сүлжээний хөрөнгө оруулалтын орчны жишиг судалгааг хийх энэхүү төсөл нь Монгол улсын уул уурхайн салбартай холбоотой хөрөнгө оруулалтын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох зорилготойгоор хэрэгжсэн. Энэхүү судалгаа нь Монгол улсын уул уурхайн салбарт орж ирэх Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж болохыг тодорхойлоход чиглэгдсэн.

Уг судалгааг Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ) санхүүжүүлж Адам Смит Интернэшнл (ASI) компани явуулсан болно.

Энэхүү төслийн хүрээнд өмнө нь гаргасан тайланд (Онцлох үе шатуудын тайлан) сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд Монгол улсад өрнөсөн гол үйл явдлуудыг тодорхойлсон.

Төслийн багийн зүгээс салбарын оролцогч талуудын дунд судалгаа явуулж, нэмэлт ярилцлага хийсэн бөгөөд үр дүнг нь өмнө нь ирүүлсэн Уул уурхайн салбарын оролцогч талуудын судалгаа (УУСОТС)-ны тайланд тусгасан болно. Мөн Канадын Фрейзер институтээс жил бүр явуулдаг “Фрейзерийн судалгаа”-ны талаар тайланд дурдсан болно. Тус судалгаанд оролцогчдоос Монгол улстай холбоотой

хариу ирээгүйн улмаас Монгол улс сүүлийн хэдэн жилийн Фрейзерийн судалгаанд хамрагдаагүй тул УУСОТС-г Фрейзерийн судалгаатай төстэй байхаар загварчилсан.

Өөр нэг тайланд Монгол улсыг харьцуулах боломжтой орнуудтай нь харьцуулсан Зөрүүгийн шинжилгээний үр дүнг тусгасан. Харьцуулах боломжтой улс орнуудыг өмнө нь сонгож баталсан бөгөөд үүнд Баруун Австрали, Чили, Замби зэрэг улсууд орсон.

Фрейзерийн судалгаанд Баруун Австрали болон Чили улс өндөр оноо авсан ба эдгээр нь Монгол улсын хувьд жишиг үзүүлэлт байх боломжтой. Ашигт малтмал, ялангуяа зэсийн томоохон үйлдвэрлэгч Замби улсын туршлагаас ГШХО-д нөлөөлөл алдааны жишээг авч болох юм.

Харьцуулсан шинжилгээг хийхэд 2011-2017 онуудад хийсэн Фрейзер судалгааны үр дүн (Монгол улсын хувьд үр дүн гарсан сүүлийн жил) болон 2021 оны УУСОТС-ны үр дүнг ашигласан. Түүнчлэн, Зөрүүгийн шинжилгээний харьцуулалт хийхэд УУСОТС болон Фрейзерийн судалгаагаар тодорхойлоогүй зөрүү болон сул талуудыг илрүүлэх зорилгоор СВОТ-ын шинжилгээний арга зүйг ашигласан.

Энэхүү энэхүү тайлан нь ГШХО-ын мэдээллийг харьцуулсан өмнөх бүх судалгаан дээр үндэслэсэн, ижил орлоготой орнуудын кейсийн судалгааны хэсгийг багтаасан бөгөөд Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах Үйл ажиллагааны төлөвлөгөөг санал болгож байна.

Түүнчлэн, 2022 оны 5-р сарын 17-нд Улаанбаатар хотод (болон онлайнаар) болсон семинар, хэлэлцүүлгийн хэсгийг багтаасан болно.

## 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛБАР СҮҮЛИЙН ХЭДЭН АРВАН ЖИЛД

“Монголын уул уурхайн салбарын гол үе шатууд ба хөрөнгө оруулалтын орчин сүүлийн 30 жилийн хугацаанд” гэсэн бидний өмнөх тайланд тусгасанчлан, хөрөнгө оруулалтын нөхцөл байдал нэлээд их өөрчлөлтүүдийг туулсан.

### 1991-2000

1991-2000 онуудад Монгол улсын хөрөнгө оруулалтын орчин үе шаттайгаар сайжирсан. Засгийн газраас хэрэгжүүлсэн “Алт” хөтөлбөрийн хүрээнд голдуу шороон ордуудын 200 гаруй хайгуулын, 180 гаруй ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгосон. Хувийн эзэмшлийн компаниудын тоо хурдацтай өссөн. Үүний үр дүнд жилд 500 кг хүрэхгүй байсан алтны олборлолт 2000 онд 11,4 тонн болж өссөн.

1994 оноос өмнө гадаадын хөрөнгө оруулагч аливаа бизнесийн санхүүжилтийг 100 хувь бүрдүүлсэн атлаа тухайн бизнесийн зөвхөн 49 хувийг эзэмшихийг зөвшөөрдөг байв. Эдгээр хөрөнгө оруулалтын гэрээний үүрэг амлалт биелэлгүйгээр цуцлагдсан байдаг.

Монгол улс Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлсэн Эдийн засгийг сэргээх төслийн (1991-1997) хүрээнд геологи, уул уурхайн үйл ажиллагаа, салбарын удирдлагын чиглэлээр 4 тайлан гарч, Ашигт малтмалын тухай хуулийн төслийг боловсруулсан. Монгол Улсын Ашигт малтмалын тухай энэхүү анхны хууль 1994 онд УИХ-аар батлагдсан. Энэ хууль нь хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг зөвшөөрсөн хэдий ч төрийн оролцоо, хяналтыг өндөр түвшинд байлгах, стратегийн ач холбогдолтой ашигт малтмал, төсөлд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг хязгаарлах зохицуулалтуудыг агуулж байсан. Тусгай зөвшөөрөл олгох дүрэм журам нь хараахан ил тод болоогүй байлаа.

Хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах, өмч хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг баталгаажуулах, татварын хөнгөлөлт чөлөөлөлт олгох зохицуулалт бүхий 1993 онд батлагдсан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль нь Канад, Австралийн зарим жижгэвтэр хайгуулын компаниудын хөрөнгө оруулалтыг татсан боловч олон улсын томоохон компаниудын сонирхлыг татахад хангалтгүй байв.

1997 оны долдугаар сараас хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн хоёр дахь шинэчилсэн найруулгыг олон улсын шинжээчид тивийн хэмжээнд хамгийн сайн, дэлхийн хэмжээнд өрсөлдөх чадвар өндөртэй ашигт малтмалын тухай хууль болсон хэмээн үнэлж байв. Уг шинэчилсэн найруулга нь дараахь дэвшилтэт талуудыг агуулж байв. Үүнд:

- Тусгай зөвшөөрлийн төлбөрөөр хэсэгчлэн баталгаажсан, зөвхөн 3 үндэслэлээр хүчингүй болгох нөхцөлтэй тусгай зөвшөөрөл эзэмших хугацаа;
- Хамгийн бага төрийн оролцоо;
- Гадаадын, дотоодын, хувийн хэвшлийн болон төрийн өмчит компаниудад үйлчлэх ижил журам;
- Зөвхөн “Түрүүлж ирсэнд түрүүлж үйлчлэх” зарчмын дагуу тусгай зөвшөөрөл олгох ил тод зохицуулалт.

Мөн Засгийн газар нь шинэ хуулийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Ашигт малтмалын газрыг үүсгэн байгуулсан. Түүнчлэн, геологи, уул уурхайн кадастрын бүртгэлийн нэгдсэн системийг нэвтрүүлсэн.

## **2001-2010**

Ашигт малтмалын тухай шинэ хууль батлагдсанаар хайгуулын үйл ажиллагаа ид өрнөж, хайгуулын тусгай зөвшөөрөл олноор олгогдсон. Монгол Улс 2004 онд дэлхийн нийт хайгуулын үйл ажиллагааны зардлын 4%-ийг татаж, улсын нийт нутаг дэвсгэрийн 44%-д хайгуул хийх тусгай зөвшөөрөл олгогдсон. 2000 оны сүүлээр Оюутолгойн (ОТ) зэс-алтны ордыг илрүүлсэн явдал нь ч энэ өсөлтөд нөлөөлсөн.

Уул уурхайн салбар нь энэ арван жилийн хугацаанд улс орны эдийн засагт маш чухал байр суурь эзэлж, ДНБ-ий 8% (2001 онд) -ийг эзэлж байсан бол 2010 онд 25% хүртэл өссөн.

Хятадын зах зээлд нүүрс гаргаж эхэлсэн бөгөөд гадаадын томоохон хөрөнгө оруулалтаар хэд хэдэн металлын ордын ашиглалтыг эхлүүлсэн.

Ийнхүү гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд олширсонтой зэрэгцээд металлын зах зээлийн үнэ нэмэгдсэн нь баялгийг өмчирхөх үндсэрхэг үзэл бий болоход хүргэв. Байгаль орчныг хамгаалах, уул уурхайн төслүүдийг эсэргүүцэх, гадаадын хөрөнгө оруулагчдын эсрэг үзэл суртал дэлгэрүүлэх олон

тооны ТББ-ууд үүсгэн байгуулагдсан. Эдгээр ухуулгад дөрөөлсөн улс төрийн популизм нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн дэмжлэгтэйгээр өргөн газар авч улмаар Гэнэтийн ашгийн албан татварын тухай хууль батлагдаж 2006 онд 1997 онд батлагдсан Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэн найруулахад хүргэсэн. 2006 онд шинэчлэн найруулсан Ашигт малтмалын тухай хуульд хэд хэдэн шинэ концепцүүд тусгагдсан:

- “стратегийн ач холбогдол бүхий” ашигт малтмалын ордууд дахь төрийн оролцоог (>34%; >50%) тодорхойлох;
- “Түрүүлж ирсэнд түрүүлж үйлчлэх” процесст тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын үйл явцыг нэмж журамлах;
- Ашигт малтмалын ангилал;
- 5 үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох зохицуулалт оруулж тусгай зөвшөөрөл эзэмших хугацааны баталгааг сулруулсан;
- Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барьцаалахтай холбоотой санхүүгийн зарим хязгаарлалтыг бий болгосон.

Энэ арван жилийн сүүлийн хагаст дотоодын хэд хэдэн уул уурхайн компани бий болсон.

2009 онд хоёр хууль нэмж батлагдсанаар энэхүү баялгийг өмчирхөн хамгаалах хандлага үргэлжилсэн. Үүний нэг нь гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон “Урт нэртэй хууль” юм. Тус хууль нь Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 30 орчим хувийг хамарсан 1200 орчим хайгуулын, 800 гаруй ашиглалтын тусгай зөвшөөрөлд нөлөөлжээ. Үүний нөлөөгөөр олон тооны маргаан үүсэж, алтны олборлолт буурч, ашигт малтмалыг хууль бусаар хил давуулах явдал нэмэгдсэн. Цөмийн энергийн тухай хууль нь хувийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон цацраг идэвхт ашигт малтмалын ордын 34-өөс доошгүй хувийг, улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон ордын 50-иас доошгүй хувийг төр үнэ төлбөргүй, шууд эзэмших тухай заалт оруулсан тул ураны ордын хайгуульд сөргөөр нөлөөлсөн.

УИХ 2006 оны 10-р сард Рио Тинто болон Туркойз Хилл Ресурс компанитай 4.6 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж, ОТ-н бүтээн байгуулалтын эхний үе шатыг баталсан. Монгол улсын засгийн газар Туркойз Хилл компанийн зээлийн санхүүжилтээр Оюу Толгой төслийн 34%-ийг эзэмших болсон. Ил уурхайн аргаар олборлолт хийх уурхайн ашиглалтын эхний үе шат 2013 онд эхэлсэн.

## **2011-2020**

Хайгуулын үйл ажиллагаа 2011 онд оргилдоо хүрсэн ч дараагийн 5 жилд буурч эхэлсэн. Монгол Улсын Ерөнхийлөгч тусгай зөвшөөрлийн наймааг хязгаарлах зорилгоор шинээр тусгай зөвшөөрөл олгохыг нэг жилийн хугацаагаар түдгэлзүүлэх тухай хууль санаачилсаныг УИХ-аас тэр даруй баталсан. Уг хуулийн үйлчлэх хугацааг хоёр удаа сунгасан бөгөөд хамгийн сүүлд хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг тодорхой хугацаагүйгээр буюу Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хүртэл хориглосон. Түүнчлэн, хайгуулын тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглосон.

Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль (СААНГХОТХ) нь хэд хэдэн салбарт (уул уурхайн салбарыг оролцуулаад) гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалтыг нэвтрүүлсэн. Уг хууль нь 2012 онд хүчин төгөлдөр мөрдөгдөөд, жилийн дараа хүчингүй болсон хэдий ч хайгуулын тусгай зөвшөөрлийн хоригтой нийлээд гадаадын хөрөнгө оруулагчдад сөрөг дохио өгч, ГШХО-ыг улам

бууруулсан. Уул уурхайн салбарын ГШХО 2019 онд 2011 онтой харьцуулахад хоёр дахинаас илүү буурсан.

Буурах хандлагатай болсон ГШХО-ыг нэмэгдүүлэх зорилгоор 2013 онд Монгол Улсын Засгийн газраас Хөрөнгө оруулалтын тухай хуулийг баталж, гадаадын хөрөнгө оруулагчдыг хамгаалах, баталгаа гаргах, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдад ялгавартай хандах байдлыг арилгах, хөрөнгө, орлогыг (хилийн чандад мөн адил) шилжүүлэх, татварын орчны тогтвортой байдлыг хангах баталгааг бий болгосон. Төрөөс ашигт малтмалын талаар баримтлах бодлого (2014 онд батлагдсан) хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг хориглосныг хүчингүй болгосон. Энэ нь тусгай зөвшөөрлийн тоог нэмэгдүүлэхэд нөлөөлсөн ч гадаадын хөрөнгө оруулагчдын эзэмшиж буй тусгай зөвшөөрлийг тоонд нөлөөлсөнгүй.

Хууль эрх зүйн орчны тогтворгүй байдал, хууль тогтоомжийн ойр ойрхон өөрчлөлтийн улмаас ГШХО буурч, хөрөнгө оруулалтын орчин улам дордох байсан ч ОТ-н далд уурхайн бүтээн байгуулалт болон санхүүжилтийн төлөвлөгөөнд гарын үсэг зурсанаар далд уурхайн үйл ажиллагаа нь түдгэлзүүлсэний дараа гурван жилийн хугацаанд үргэлжлэх боломжтой болсон.

Нийт 4,4 тэрбум ам.долларын санхүүжилттэй уурхайн бүтээн байгуулалтын энэ үе шат нь төслийн нийт орлогын 80 хувийг бүрдүүлэхээр байгаа. Гэсэн хэдий ч энэхүү томоохон гэрээ хэлэлцээр хүртэл төслийн санхүүжилтийн эхний үе шат шиг Монголд томоохон хэмжээний ГШХО-ыг татсангүй. Энэ нь Засгийн газар болон компани хэд хэдэн асуудлаар удаан хугацаанд санал зөрөлдсөнтэй холбоотой бололтой. 2019 оны арваннэгдүгээр сард УИХ-аас МУЗГ-т ОТ төслөөс Монголын талын хүртэх үр ашгийг дахин хэлэлцэхийг даалгасан. Засгийн газрын ашиг өгөөж хүртэх хугацаа хойшлогдож буй явдал болон зардлын хэтрэлийг нягтлах бие даасан зөвлөхүүдийг авч ажиллуулсан бөгөөд, талуудын хэлэлцээр өнөөг хүртэл үргэлжилж байна.

## **Ирээдүйн төлөв байдал**

Монгол улсын алсын хараа 2030 баримт бичигт Монгол улсын уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилтыг дэвшүүлсэн бөгөөд Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хүсэлтэй байгаагаа удаа дараа илэрхийлсэн. Эдгээр нь эерэг шинж тэмдэг мөн хэдий ч гадаадын уул уурхайн салбарынхан болон хөрөнгө оруулагчид Монгол Улсад ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалтыг хийж эхлэхийн тулд тодорхой хугацаанд тогтвортой арга хэмжээ авч ажиллах зайлшгүй шаардлагатай.

2021 оны 12 дугаар сард Рио Тинтогийн зүгээс ОТ-н далд уурхайн бүтээн байгуулалтыг дуусгавар болгохтой холбоотой таван зүйл бүхий саналыг МУЗГ-т өргөн дэвшүүлсэн. Үүнд МУЗГ-аас төлөх 2.6 тэрбум ам.долларын өрийг тэглэх, Дубайн гэрээ гэгддэг далд уурхайн санхүүжилтийн төлөвлөгөөг хүчингүй болгох, уурхайн ашиглалт эхлэх хүртэл шаардагдах нэмэлт хөрөнгө оруулалтыг гаргах асуудлууд тус тус багтсан. Рио Тинтогийн өргөн барьсан саналыг 2022 оны 1-р сарын эхээр УИХ соёрхон баталсан. Үүний үр дүнд Оюу Толгой нь 2022 оны 1-р сарын 25 гэхэд хүдрийн биетийг улаар огтлох ажлыг эхлүүлсэн.

УУХҮЯ-ны зүгээс УИХ-ын түвшинд хэлэлцүүлэх УИХ-ын дэргэдэх Ашигт малтмалын биржийн тухай хууль, Засгийн газрын түвшинд хэлэлцүүлэх Баялгийн сангийн тухай хуулийн төслийг тус тус боловсруулсан. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад орсон хэдий ч УИХ-ын намрын чуулган хүртэл хойшлогдох төлөвтэй байна.

### 3. ФРЕЙЗЕРИЙН СУДАЛГАА БОЛОН УУСОТС-Н ДАХЬ МОНГОЛ УЛСЫН ГҮЙЦЭТГЭЛ

Энэхүү төслийн хүрээнд хийгдсэн Уул уурхайн салбарын оролцогч талуудын 2021 оны судалгааны (УУСОТС) Монгол улсын үр дүнг Фрейзер институтийн уул уурхайн компаниудын 2011-2017 оны жил бүрийн судалгааны тайланд (Фрейзерийн судалгаа) тусгасан Монгол Улсын үр дүнтэй харьцуулсан болно. Энэ нь Монгол улсын хөрөнгө оруулалтын орчны талаарх төсөөлөл цаг хугацааны явцад хэрхэн өөрчлөгдсөнийг харах зорилготой юм.

*Фрейзерийн судалгааны үр дүн, 2011-2017*


Монгол Улс 2004 оноос 2017 он хүртэл Фрейзерийн судалгаанд хамрагдаж байсан боловч 2017 онд нэг буюу хэд хэдэн асуултад ердөө 5-9 хариулт авсан тул зөвхөн 2016 оны Фрейзерийн судалгаанд Монгол Улс жинхэнэ утгаар хамрагдсан гэж үзэж болно.

Фрейзерийн судалгаа нь Хөрөнгө оруулалтын орчны индекс (ХОСИ), Бодлогын ойлгоцын индекс (БОИ), Эрдэсийн потенциалын шилдэг туршлагын индекс (ЭПШТИ) гэсэн гурван үндсэн индексийг тооцдог<sup>1</sup>. Энэхүү сүүлийн индекс нь шилдэг туршлагын туршлагын бодлого боловсруулж, хэрэгжүүлсэн тохиолдолд улс орнуудын ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулах боломжийг үнэлдэг. ХОСИ нь ЭПШТИ болон БОИ-ээс гаргаж авсан нийлмэл индекс юм. Эдгээр гурван индексээр үнэлсэн Монгол Улсын үзүүлэлтийг Зураг 3.1-д харуулав.

**Зураг 3.1: Монгол улсын Фрейзер судалгааны индекс, 2011-2017**

---

<sup>1</sup> <https://www.fraserinstitute.org/categories/mining>



2011-2017 оны хооронд Монгол Улс БОИ-ийн хувьд тааруу үзүүлэлттэй байсан нь тодорхой байна. БОИ хувийн эрэмбээр авч үзэхэд (Хүснэгт 3.1-ийг харна уу) Монгол улс энд тайлагнасан бүх хугацаанд (2017 оныг эс тооцвол) бүх улс орнуудын хамгийн доогуур үзүүлэлт бүхий 20 хувьд багтсан байна. ЭПШТИ-ийн хувьд 2012/2013 онд 84.29 байсан бол 2013 онд 59.46 болтлоо огцом буурч, дараагийн дөрвөн жилд ижил түвшний доод үзүүлэлтийг хадгалсан. Энэхүү огцом уналт нь 2011 оны 12 дугаар сард гаргасан шинээр хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг зогсоох шийдвэр, 2012 онд уул уурхайн болон бусад салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах талаарх Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль (СААНГХОТХ)-ийг баталсантай давхцаж байна. Эдгээр арга хэмжээ нь үндсэндээ ЭПШТИ -ээр илэрхийлэгдэх хайгуул хийх боломжтой талбайг олгох, гэрээ хэлцэл хийх, хөрөнгө оруулалт хийх боломжийг хязгаарласан.

Хүснэгт 3.1-ээс харуулсанчлан, судалгаанд хамрагдсан хугацаанд Монгол Улсын БОИ 2012-2013 онд хамгийн өндөр түвшинд хүрч, хамгийн өндөр үзүүлэлттэй 31 хувьд багтсан. Гэсэн хэдий ч үүний дараах жилд ЭПШТИ-ийн уналтын гол нөлөөллөөр Монгол Улс доод 30%-д орсон.

**Хүснэгт 3.1: Фрейзерийн судалгааны индекс (Эрэмбэ), 2011-2017**

Он	Нийт улсын тоо	БОИ Эрэмбэ	ШТХОБ Эрэмбэ	ХОС Эрэмбэ	БТИ Хувийн Эрэмбэ	ШТХОБ Хувийн Эрэмбэ	ХО Хувийн Эрэмбэ
2011-2012	93	78	16	41	82%	17%	43%
2012-2013	96	78	1	31	80%	1%	31%
2013	112	95	51	80	84%	45%	70%
2014	122	116	51	93	94%	41%	75%
2015	109	94	59	85	85%	53%	77%
2016	104	101	50	81	96%	47%	77%
2017	91	70	36	53	76%	39%	57%



Судалгааны арга зүйн зөрүүгээс шалтгаалан Фрейзерийн индексийг УУСОТС-нд шууд тооцох боломжгүй боловч эдгээр хоёр судалгааны үр дүнг (Монголын хувьд) харьцуулахдаа судалгаа тус бүрийн асуултад өгсөн хариултын хувийн задаргааг харгалзсан. Уул уурхайтай холбоотой ханган нийлүүлэлт, бодлого, институцын асуудалд хамаарах 13 давхардсан асуулт бий (Хавсралт 1-ээс бүрэн тайлбарыг үзнэ үү). Өмнө нь ирүүлсэн Оролцогч талуудын санал асуулгын дүн шинжилгээний тайланд дурдсанчлан Фрейзерийн судалгаанд оролцогчид ихэвчлэн уул уурхайн хайгуул, ашиглалтын компаниуд болон уул уурхайн зөвлөх компаниудаас бүрддэг. Энэхүү харьцуулалтыг хийхэд УУСОТС-ын судалгаанд оролцогчдоос ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын үйл ажиллагаа компаниуд, санхүүгийн хөрөнгө оруулагчыг сонгон оролцуулсан.

УУСОТС-ны оролцсон янз бүрийн бүлгүүдээс дээр дурьдсан (“тэргүүлэх ач холбогдолтой оролцогч талууд” гэж нэрлэх) оролцогч талуудыг Фрейзерийн судалгаанд оролцогчидтой харьцуулах хамгийн боломжтой. Эдгээрээс гадна судалгаанд хөрөнгө оруулалтын зөвлөхүүд, салбарын холбоод эсвэл “танхимууд”, уул уурхайн салбарын үйлчилгээ үзүүлдэг компаниуд, төрийн байгууллагууд, олон улсын санхүүгийн байгууллагууд зэрэг талууд хамрагдсан.

2011-2017 оны Фрейзерийн судалгаа болон (2021) УУСОТС-ын мэдээллийг Хавсралт 2-т хүснэгт хэлбэрээр харуулав.


Дараах хэсгүүдэд Нийлүүлэлтийн хүчин зүйлс, Бодлого, Институцын хүчин зүйлстэй холбоотой судалгааны асуултын хариултуудыг графикаар харьцуулж, тайлбарлав.

*Нийлүүлэлтийн хүчин зүйлстэй холбоотой хариултууд*

УУСОТС-ны Монгол улсын ханган нийлүүлэлтийн хүчин зүйлстэй холбоотой асуултуудын хариуг 2011-2017 оны Фрейзерийн судалгааны үр дүнтэй харьцуулж үзвэл Монгол улсын эдгээр хүчин зүйлсийн үзүүлэлт ерөнхийдөө сайжирч байгааг харуулж байна (Зураг 2-5-ыг үзнэ үү). *Ашигт малтмалын боломжийн индексийн хувьд (шилдэг туршлагын туршлагын бодлого хэрэгжүүлсэн тохиолдолд)* Монгол Улс 2021 онд хамгийн өндөр оноо авсан байна. 2017 онд *Геологийн мэдээллийн санд* мэдэгдэхүйц үсрэлт гарсан бөгөөд нийт судалгаанд оролцогчдын 74% нь энэ хүчин зүйл нь хөрөнгө оруулалтыг дэмжихүйц эсвэл хөрөнгө оруулалтад саад учруулахааргүй гэж үзсэн байна.


Дүн шинжилгээнд авч үзсэн жилүүдээс Монгол улсын ханган нийлүүлэлтийн бүх хүчин зүйлийн хувьд ирүүлсэн хариултыг ("*Энэ хүчин зүйлээс шалтгаалан хайгуулын хөрөнгө оруулалт хийхгүй*") 5 шатлалаар авч үзэхэд 2016 он Монгол Улсын хувьд хамгийн муу үзүүлэлттэй гарсан. Гэсэн хэдий ч ерөнхий төсөөлөл эерэг хэвээр байсан бөгөөд 2017, 2021 онуудад сэргэсэн.

**Зураг 3.2: Ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулах боломж, шилдэг туршлагын бодлого хэрэгжүүлсэн тохиолдолд (5a)**




Монголын ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулах боломж нь хүчтэй эерэг хүчин зүйл хэвээр байгаа нь тодорхой бөгөөд энэ нь тус тайлангийн сүүлд тусгасан СВОТ-ын шинжилгээгээр ч мөн батлагдсан.


**Зураг 3.3: Геологийн мэдээллийн сан (5b)**



**Зураг 3.4: Дэд бүтцийн чанар (5c)**



Зураг 3.5: Ажиллах хүч/ ур чадварын боломж (5d)




Бодлого ба институцийн хүчин зүйлийн талаарх хариултууд

2017 онтой харьцуулахад Монгол улс ихэнхи бодлого, институцийн бодлогын үзүүлэлтээр дордсон (Зураг 6-14). 3, 4, 5-р шатлалд өгөгдсөн нийт хариултын хамгийн өндөр хувийг авч үзвэл Монгол Улс


2013, 2014, 2015 онуудад хамгийн муу үзүүлэлттэй байсан байна. Гэсэн хэдийч нийлүүлэлтийн хүчин зүйлийн хариулттай нэгэн адил 2016 онд 5-р шатлалд өгөгдсөн хариулт хамгийн өндөр хувьтай байсан. 2011, 2017, 2021 онуудад 3, 4, 5-р шатлалд хамгийн бага хариулт өгсөн бол 2021 онд 5 дугаар шатлалд хамгийн бага хувийн санал өгөгдсөн байна.

Ерөнхийдөө 2013-2016 онуудад хөрөнгө оруулагчдын Монгол улсын талаархи хандлага төсөөлөл сул байсан бөгөөд 2017, 2021 онд бага зэрэг сайжирсан. Графикаар авч үзвэл Зураг 6-аас 14 (доорх)-өөс харахад 2011-2021 онуудад хөх өнгө (1, 2 дугаар шатлал) буурсан, саарал, хар өнгө (3, 4, 5 дугаар шатлал) нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Энэ нь “хөрөнгө оруулалтыг дэмжихүйц”, “хөрөнгө оруулалтад саад учруулах хүчин зүйл биш” гэсэн хариултаас “бага зэргийн саад учруулна”, “хүчтэй саад бэрхшээл”, “хөрөнгө оруулалт хийхгүй” гэсэн хариултауд руу шилжсэн гэсэн үг юм.


**Figure 3.6: Татварын горим (7а)**




**Зураг 3.7: Хүчин төгөлдөр үйлчилж буй дүрэм журмын хэрэгжүүлэлт, тайлбар, даган мөрдүүлэлттэй холбоотой тодорхойгүй байдал (7е)**




Зураг 3.8: Байгаль орчны зохицуулалтын тодорхой бус байдал (7f)




Зураг 3.9: Хууль эрх зүйн тогтолцоо (7g)



Зураг 3.10: Маргаантай газрын заргын тодорхойгүй байдал (7h)




Зураг 3.11: Нийгэм, эдийн засгийн хэлэлцээрүүд / Орон нутгийн иргэдийг хөгжүүлэх нөхцөл (7i)




:


Зураг 3.12: Худалдааны саад бэрхшээл (7j)



**Зураг 3.13: Хөдөлмөрийн зохицуулалт (7 к)**



**Зураг 3.14: Улс төрийн тогтвортой байдал (7 л)**





2017 оны бүх хариултын хураангуй, 2021 онтой харьцуулсан байдал

Энд Фрейзерийн судалгааны (2017) бүх үр дүнг УУСОТС (2021)-ийн үр дүнтэй нэгтгэн харьцуулсан болно. Гурван (нийт дөрвөөс) нийлүүлэлттэй холбоотой хүчин зүйлийн талаархи төсөөлөл, түүнчлэн бодлогын болон институцийн хоёр (нийт есөөс) хүчин зүйлийн талаархи төсөөлөл сайжирсан байна. Бусад бүх хүчин зүйлүүд цаг хугацааны явцад дордсон байна. Хүснэгт 3.2 (доорхи) дээр уг харьцуулалтын үр дүнгийн хураангуйг харуулав. Ногоон өнгөөр тэмдэглэсэн нүднүүд нь сайжирч байгаа үзүүлэлтүүдийг харуулсан бол улаан өнгөөр тэмдэглэсэн нүднүүд нь нөхцөл байдал дордсон үзүүлэлтүүдийг харуулсан болно.

**Хүснэгт 3.2: Судалгааны асуултын хариултуудыг харьцуулсан байдал – Фрейзерийн судалгаа (2017) ба УУСОТС (2021)**

	Онооны нийлбэр хувь 3, 4, 5		2017 ба 2021 оны онооны зөрүү
	2017	2021	
Ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулах боломж, шилдэг туршлагын бодлого хэрэгжүүлсэн тохиолдолд (5a)	20	0	20
Геологийн мэдээллийн сан (5b)	26	48	-22
Дэд бүтцийн чанар (5c)	73	67	6
Ажиллах хүч, ур чадварын боломж (5d)	50	24	26
Татварын горим (7a)	63	83	-20
Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй дүрэм журмын зохицуулалт, тайлбар, хэрэгжүүлэлттэй холбоотой тодорхой бус байдал (7e)	90	94	-4
Байгаль орчны зохицуулалтын тодохой бус байдал (7f)	50	72	-22
Хууль эрх зүйн тогтолцоо (7g)	90	94	-4
Маргаантай газрын заргын тодорхойгүй байдал (7h)	54	87	-33
Нийгэм, эдийн засгийн хэлэлцээрүүд / Орон нутгийн иргэдийг хөгжүүлэх нөхцөл (7i)	60	76	-16
Худалдааны саад бэрхшээл (7j)	60	54	6
Хөдөлмөрийн зохицуулалт (7k)	27	60	-33
Улс төрийн тогтвортой байдал (7l)	90	77	13

# 4. ФРЕЙЗЕРИЙН СУДАЛГАА БОЛОН УУСОТС-НЫ ҮНДСЭН ДЭЭР ХАРЬЦУУЛАХ БОЛОМЖТОЙ УЛС ОРНУУДТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

## *Оршил*

Энэ хэсэгт 2021 онд хийгдсэн Уул уурхайн салбарын оролцогч талуудын судалгаа (УУСОТС)-ны Монгол улсын үр дүнг Фрейзер институтээс хийсэн Уул уурхайн компаниудын 2020 оны жилийн судалгааны тайланд тусгасан харьцуулах боломжтой улс орнуудын (Баруун Австрали, Чили, Замби) үр дүнтэй харьцуулсан болно. Энэхүү харьцуулалт нь Монгол улс эрэлхийлж буй хөрөнгө оруулалтынхаа төлөө өрсөлдөж буй бусад улс орнуудтай харьцуулахад хэрхэн ажиллаж байгааг харуулах зорилготой юм.

Эдгээр улс орнуудыг дараахь зүйлсийг харгалзсаны үндсэн дээр сонгосон: Эдгээр нь бүгд ашигт малтмалын томоохон олборлогч улс орнууд бөгөөд, Монгол Улсын хүсч буй ижил төрлийн ашигт малтмалын салбарын хөрөнгө оруулалтын төлөө өрсөлдөж байгаа улс юм. Баруун Австрали, Чили улс хоёулаа Фрейзерийн судалгаанд сайн оноо авсан бөгөөд хүрэх түвшний сайн жишээ болж чадна. Зэс болон бусад ашигт малтмалын томоохон олборлогч болох Замби улсын туршлагаас бодлогын таагүй шийдвэрүүд хөрөнгө оруулалтын орчинд хэрхэн нөлөөлж болдгийг харах боломжтой юм.


Эдгээр дөрвөн улсын хувьд хоёр судалгааны үр дүнг харьцуулахдаа судалгаа тус бүрийн асуултад өгсөн хариултын нийт хариултад эзлэх хувийг ашигласан (асуултуудын задаргааг Хавсралт 1-ээс үзнэ үү). Оролцогч талуудын санал асуулгын дүн шинжилгээний тайланд дурдсанчлан, Фрейзерийн судалгаанд оролцогчид ихэвчлэн уул уурхайн хайгуул, ашиглалтын компаниуд болон уул уурхайн зөвлөх компаниудаас бүрддэг бол УУСОТС-ын судалгаанд оролцогчид хайгуул, уул уурхайн компаниуд болон санхүүгийн хөрөнгө оруулагчдаас бүрдсэн. Эдгээр хоёр бүлэг судалгаанд хамрагдагсад нь үндсэндээ ижил эсвэл маш төстэй зорилго, төсөөлөлтэй байдаг гэдэг нь мэдрэгдлээ. Эдгээр дөрвөн улсын мэдээллийг Хавсралт 3-г хүснэгтээр харуулав.

## *2016, 2017 оны Фрейзерийн судалгааны үр дүн*

Эдгээр дөрвөн улсын хувьд хоёр судалгааны үр дүнг харьцуулахаас өмнө энэ хэсэгт харьцуулах боломжтой орнуудын Фрейзерийн судалгааны үр дүнд товч дүн шинжилгээг хийлээ. Хамгийн сүүлд 2016, 2017 онд Монгол улсыг оруулаад эдгээр дөрвөн улс дөрвүүлээ Фрейзерийн судалгаанд хамрагдсан.


Зураг 4.1-г харуулсанаар 2016 онд Баруун Австрали нь бүх гурван индексээр харьцуулах боломжтой орнуудын дунд хамгийн өндөр оноо авсан. Замби улс нь ХОС-ын индексээр харьцуулах боломжтой орнуудын дунд хоёрдугаарт, 104 орны нийт эрэмбээр эхний 30%-д багтжээ. Монгол улс бүх индексийн хувьд хамгийн муу үзүүлэлттэй гарсан бөгөөд БОИ индексийн хувьд мэдэгдэхүйц муу оноо авч судалгаанд оролцсон бүх орнуудын сүүлийн 5%-д багтжээ. (Өндөр хувьтай байгаа нь эрэмбэ доогуур байгааг илтгэж байгааг анхаарна уу.)

## **Зураг 4.1: Фрейзерийн судалгааны индексүүд – 2016 оны хувь хэмжээний эрэмбэ**



2017 онд хувийн эрэмбэлэл өөрчлөгдсөн. Баруун Австрали хамгийн өндөр эрэмбэтэй хэвээр байгаа ч Чили улсын үзүүлэлт мэдэгдэхүйц сайжирсан, харин Замби бүх гурван индексээр харьцуулах боломжтой орнуудын дунд хамгийн сүүлийн байр руу ухарсныг тэмдэглэх нь зүйтэй. Монгол Улсын үзүүлэлт сайжирсан ч энэ жилийн үзүүлэлтийн хувьд Монгол Улсын талаарх мэдээлэл нь олон асуултын 9 ба түүнээс бага хариулт дээр үндэслэсэн болохыг тэмдэглэх нь зүйтэй. Зураг 4.2 нь 2017 оны үр дүнг харуулсан болно.

**Зураг 4.2: Фрейзерийн судалгааны индексүүд– 2016 оны хувь хэмжээний эрэмбэ**




Дээрх график, тайлбарууд нь уул уурхай, хайгуулын болон хөрөнгө оруулагч компаниудын төсөөллөөр Монгол улс бусад харьцуулах боломжтой орнуудаас хэр зэрэг хоцорч байгааг, мөн Замби улсын үзүүлэлт 2016-2017 онд хэрхэн мөн адил дордсоныг харуулсан. Үүний шалтгааныг дараах хэсэгт авч үзнэ.

### Нийлүүлэлттэй холбоотой асуултуудын хариулт

УУСОТС-нд оролцсон оролцогч талууд Монгол Улсын ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулах боломжид бусад хүчин зүйлүүдтэй харьцуулахад хамгийн өндөр оноо өгсөн бөгөөд үүнийг хөрөнгө оруулалтыг дэмжихүйц, эсвэл ашигт малтмалын салбарын хөрөнгө оруулалтыг саатуулах хүчин зүйл биш (1 эсвэл 2 оноо) гэж үзсэнийг Зураг 4.3-т харуулав. Бусад харьцуулах боломжтой орнуудын хувьд ч мөн адил эдгээр оноог сонгосон судалгаанд оролцогчдын эзлэх хувь өндөр байгаа нь эдгээр дөрвөн улс бүгд ашигт малтмалын нөөц ихтэй, ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулалт хийх боломжтой гэдгийг баталж байна.


Харьцуулах боломжтой улс орнуудыг сонгохдоо Монгол Улстай ижил төрлийн уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтад өрсөлдөх боломжтой байдлыг харгалзсан учраас энэ нь гайхах зүйл биш юм. Монгол улс харьцуулах боломжтой улсуудаас илүү өндөр оноо авсан явдал нь цэвэр техникийн болон геологийн үндэслэлээр судалгаанд оролцогчид Монгол улсад ашигт малтмалын шинэ орд илрүүлэх хамгийн боломжит буюу ядаж Баруун Австралийн дайтай болох боломжтой гэж үзэж байгаагийн илрэл юм.

**Зураг 4.3: Ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулах боломж, шилдэг туршлагын бодлого хэрэгжүүлсэн тохиолдолд (5a)**




Геологийн мэдээллийн сангийн чанар (эсвэл 5б Геологийн мэдээллийн бэлэн, хүртээмжтэй байдал)-ын талаарх асуултад өгсөн хариултуудыг харьцуулахад бараг бүх судалгаанд оролцогчид 1 эсвэл 2 оноо өгсөн Баруун Австрали тэргүүлж байна. Хариултуудыг 5 оноонд задалж үзэхэд Монгол, Замби улсын хувьд судалгаанд оролцогчдын тал орчим хувь нь энэ хүчин зүйл нь хөрөнгө оруулалтыг бага зэрэг эсвэл хүчтэй саатуулах хүчин зүйл гэж үзсэнээр эдгээр хоёр улс ижил үзүүлэлттэй гарчээ. Үүнийг Зураг 4.4-т үзүүлэв.

**Зураг 4.4: Геологийн мэдээллийн чанар, хүртээмж (5b)**




Монгол улстай харьцуулах боломжтой гурван орны бүгдийнх нь хувьд *дэд бүтцийн чанар, хүртээмж* нь асуудал биш бололтой. Харин Монгол улсын хувьд хариултауд таван онооны түвшинд жигд тархсан байдалтай байна. Энэ нь уг хүчин зүйл нь хөрөнгө оруулалтыг дэмжихүйц гэж харуулсан хүмүүсийн тоо нь энэ хүчин зүйл нь хөрөнгө оруулалтад саад учруулна гэж үзсэн хүмүүсийн тоотой ижил харьцаатай байгааг харуулж байна. Хайгуулын компаниуд ашигт малтмалын шинэ орд ихэвчлэн дэд бүтэц хөгжөөгүй газарт илрэх хандлагатай байдгийг мэддэг тул хүлээлт багатай байдаг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

**Зураг 4.5: Дэд бүтцийн чанар (5c)**



*Ажиллах хүч, ур чадварын боломжийн* үзүүлэлтээр бүх улс оронд өндөр үнэлгээ авсан. Энэ индексээр Монгол Улс Замби улсаас илүү сайн үзүүлэлттэй байна. Монгол улсын хувьд судалгаанд оролцогчдын 76% нь 1 эсвэл 2 оноог сонгосон бол Замби улсын хувьд нэг ч оролцогч 1 оноог сонгоогүй байна (мөн 50% нь 2 оноог сонгосон).


**Зураг 4.6: Ажиллах хүч, ур чадварын боломж (5d)**



**Бодлого, институцын хүчин зүйлд хамаарах асуултуудын хариулт**

Монгол улс бодлого, институцийн хүчин зүйлийн үзүүлэлтээр таамаглаж байсанчлан харьцуулах боломжтой орнуудтай харьцуулахад муу оноо авчээ. *Татварын горим, шилдэг туршлагын* хүчин зүйлээр 3, 4, 5 оноо (хөрөнгө оруулалтыг саад учруулах түвшинг заасан) авсан хариултуудыг нэгтгэн авч үзэхэд Монгол Улс Баруун Австралиас 70 хувиар, Замбиас 17 хувиар илүү оноо авсан байна.


**Зураг 4.7: Татварын горим (7a)**



*Ашигт малтмалын татварын зохицуулалтын горим (удирдлага, тайлбар, хэрэгжилт)*-ын хүчин зүйл нь судалгаанд оролцогчдын ихээхэн асуудалтай гэж үзсэн хүчин зүйлсийн нэг бөгөөд Монгол улс энэ асуудлаар Баруун Австрали, Чили төдийгүй Замби улсаас хол хоцорч байна.


Энэ үзүүлэлтээр Монгол улс харьцуулах боломжтой орнууд, тэр байтугай Замби улсаас доогуур байгаа нь мэдээжийн хэрэг маш их анхаарал татах асуудал болж байна. Ялангуяа Африкийн орнууд зохицуулалтын горим дутмаг, хэрэгжилт муу гэсэн төсөөлөлтэй байдаг билээ.

**Зураг 4.8: Зохицуулалтын горимтой холбоотой тодорхой бус байдал (7e)**




Байгаль орчны зохицуулалтын горимын талаарх судалгааны асуултуудаас харахад судалгаанд оролцогчдын дийлэнх нь Баруун Австрали, Чили, Замби улсад 1 эсвэл 2 оноог сонгосон эдгээр улсуудын хувьд энэ үзүүлэлт нь ерөнхийдөө нэг их санаа зовоосон асуудал биш гэдэг нь харагдаж байна. Харин Монголын хувьд оролцогч талуудын 44 хувь нь энэ хүчин зүйл хөрөнгө оруулалт татахад бага зэрэг саад учруулдаг гэж үзсэн бөгөөд 28 хувь нь 4 ба 5 гэсэн оноо өгчээ. Тиймээс судалгаанд оролцогчид бусад улс орнуудаас илүү Монгол улсад байгаль орчны зохицуулалтын учир дутагдалтай гэж үзэж байна.

**Зураг 4.9: Байгаль орчны зохицуулалттай холбоотой тодорхой бус байдал**




Хууль эрх зүйн тогтолцооны хүчин зүйлийн хувьд Монгол улс, Замби улсын эрэмбэ доогуур бол судалгаанд оролцогчдын дийлэнх нь Баруун Австрали, Чили улсын хувьд энэ хүчин зүйл хөрөнгө оруулалтыг саатуулдаг гэж үзэхгүй байна.

**Зураг 4.10: Хууль эрх зүйн тогтолцоо (7g)**



Газрын маргаан буюу маргаантай газрын заргын тодорхой бус байдал гэсэн хүчин зүйлийн талаар ирүүлсэн судалгаанд оролцогчдын хариултыг харьцуулахад Чили улс эерэг хариултын хамгийн өндөр хувийг (1 эсвэл 2 оноо) авсан байна. Энэ үзүүлэлтээр бас Монгол улс энэ үзүүлэлтээрээ бусад харьцуулах боломжтой улс орнуудын ард хоцорч байна.

**Зураг 4.11: Газрын маргаантай холбоотой тодорхой бус байдал (7h)**




Орон нутгийн иргэдтэй харилцах, үүрэг амлалтын тухайд судалгаанд оролцогчдын дийлэнх нь Баруун Австрали, Чили улсын хувьд энэ нь хөрөнгө оруулалтыг саатуулах хүчин зүйл биш гэж үзсэн бол Монголын хувьд судалгаанд оролцогчдын дийлэнх нь энэ нь хөрөнгө оруулалтад бага зэрэг саад




учруулна гэж үзсэн харин Замби улсын хувьд дийлэнх оролцогчид энэ хүчин зүйл нь хөрөнгө оруулалтыг зогсоох хүчин зүйл мөн гэж үзжээ. Хөрөнгө оруулалтад саад учруулна гэсэн утга бүхий нийт онооны нийлбэрээр (3, 4, 5 оноо) нь авч үзвэл Монгол улс харьцуулах боломжтой гурван орноос хамгийн муу оноог авч байгааг тэмдэглэх нь зүйтэй. Ялангуяа, Монгол улсад хүн амын нягтрал Замби улстай харьцуулахад маш бага байдаг талаас нь авч үзвэл энэ нь онцгой анхаарал татах асуудал юм.

**Зураг 4.12: Орон нутгийн иргэдтэй харилцах, үүрэг амлалт (7i)**




Худалдаа, арилжаа нь 3, 4, 5 онооны нийлбэрээр нь харьцуулахад Монгол Улс хамгийн харьцуулах боломжтой улс болох Замби улсаас илүү сайн үнэлгээ авсан цорын ганц бодлого, институцын чиглэл юм. Харин Замби улсын хувьд энэ оноог хэн ч сонгоогүй байхад Монголыг санал асуулгад оролцогчдын 7% нь энэ хүчин зүйлээс шалтгаалж хөрөнгө оруулалт хийхгүй гэж үзэж байна.

**Зураг 4.13: Худалдааны саад бэрхшээл (7j)**




Хөдөлмөрийн зохицуулалт, зөвшөөрлийн хүчин зүйл нь анхаарал татсан асуудал биш ч харьцуулах боломжтой орнуудтай харьцуулахад Монгол Улсын үзүүлэлт бага зэрэг тааруу байна. Судалгаанд оролцогчдын 53 хувь нь Монгол Улсын энэ хүчин зүйлд 3 оноо, 7% нь 4 оноо өгсөн бол Замби улсын хувьд судалгаанд оролцогчдын 50% нь 3 гэсэн оноог сонгосон байна. Түүнчлэн, судалгаанд оролцогчдын 17% нь энэ хүчин зүйл Замби дахь хөрөнгө оруулалтыг дэмжинэ гэж үзсэн бол харин Монголын хувьд ийм саналтай оролцогч байгаагүй.

**Зураг 4.14: Хөдөлмөрийн зохицуулалт, зөвшөөрөл (7к)**



Улс төрийн тогтвортой байдал, аюулгүй байдлын хүчин зүйлийн хувьд судалгаанд оролцогчдын 33 хувь нь энэ хүчин зүйлээс болж Замби улсад хөрөнгө оруулалт хийхгүй гэж үзсэн нь Замби улсыг онцолж байгаа хэрэг. Уг хүчин зүйлийн хувьд нийт бүх улс орнуудын хувьд нийт 13 хүчин зүйлээс хамгийн олон 5 оноо авсан хүчин зүйл юм. Энэ нь Африкийн улс орнууд улс төрийн орчин тогтворгүй байдаг гэсэн хөрөнгө оруулалтын компаниудын төсөөллийн илэрхийлэл байх талтай. Харин Монгол улсын хувьд улс төрийн тогтворгүй байдал нь анхаарал татах асуудал хэвээр байгаа бөгөөд судалгаанд оролцогчдын 47% нь Монгол улсын хувьд 4 оноо өгсөн байна. Түүнчлэн 4 оноо ба 5 онооны нийлбэрийг харьцуулж үзвэл Монгол улсын үзүүлэлт (53%) нь Замби улсынхаас (50%) дор үзүүлэлттэй байна.

**Зураг 4.15: Улс төрийн тогтвортой байдал (7l)**




## 5. ЗӨРҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ

Энэ хэсэгт бид хоёр судалгааны үр дүнд (Фрейзерийн судалгаа ба УУСОТС) үндэслэн Зөрүүгийн шинжилгээ хийсэн. Хоёр судалгааны үр дүнд (Фрейзер ба УУСОТС) үндэслэн харьцуулах боломжтой Зөрүүгийн шинжилгээг хялбаршуулсан байдлаар хийхийн тулд хүчин зүйл, улс тус бүрт өгсөн 3, 4, 5 гэсэн онооны нийлбэр хувийг тооцсон. Энэ нь тодорхой хүчин зүйл тус бүрийн талаарх судалгаанд оролцогчдын сөрөг төсөөллийг ерөнхийд нь гаргаж харьцуулалт хийж буй дөрвөн улс орны үр дүнг хооронд нь харьцуулах зорилготой юм.

Ийнхүү харьцуулалт хийх замаар доорх Зурагт үзүүлсэн шиг улс орнуудын хоорондын зөрүүг дүрслэн харуулах боломжтой. Дөрвөн улсыг график тус бүр дээр өөр өөр өнгийн шугамаар харуулсан болно. Тухайн улс орны шугам хэдий чинээ өргөн байна, төдий чинээ муу үзүүлэлттэй гэсэн үг юм. Жишээлбэл, Зураг 5.1-д Замби (улбар шар шугам) нийлүүлэлттэй холбоотой гурван хүчин зүйлийн үзүүлэлтээр Монголоос доогуур (цэнхэр шугам) үнэлгээ авсан байна. Зөвхөн ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулах боломжийн хувьд Монгол улс харьцуулах боломжтой гурван орноос илүү үнэлгээ авчээ.


**Зураг 5.1: Нийлүүлэлтийн хүчин зүйлийн Зөрүүгийн шинжилгээ**



Зураг 5.1-ийн утгыг нэгтгэн дүгнэхэд ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулах боломжийн хүчин зүйл дээр Монгол Улс Баруун Австралиас арай илүү оноо авсаныг эс тооцвол Баруун Австрали, Чили улс нь хоёулаа нийлүүлэлтийн талын бүх хүчин зүйлээр Монголоос илүү байгаа нь тодорхой байна. Монгол Улс Замбиас доогуур оноо авсан нийлүүлэлтийн талын ганц хүчин зүйл (*Дэд бүтцийн чанар*) нь хайгуул, ашиглалтын компаниудын хувьд тийм ч чухал хүчин зүйл биш юм. *Геологийн мэдээллийн сангийн чанарын* хүчин зүйл нь бас муу (Замбитай адил) боловч ерөнхийдөө эдгээр нийлүүлэлтийн хүчин зүйлүүд нь хайгуулын компаниуд болон хөрөнгө оруулагчдыг Монгол руу нэвтрэхэд саад болохгүй гэж хэлж болно.

Гэхдээ бодлого, институцийн хүчин зүйлсийн хувьд сөрөг гурван онооны (3, 4, 5) нийлбэрийг авч үзвэл Монгол улс харьцуулах боломжтой гурван оронтой харьцуулахад тааруу байгаа нь тодорхой байна. Харьцуулах боломжтой аль нэг улсаас илүү сайн үзүүлэлттэй байгаа цорын ганц хүчин зүйл нь *Худалдааны саад бэрхиээл* бөгөөд бол Замби улс Монгол улсаас илүү муу үзүүлэлттэй байна. Доорх Зураг 5.2-ыг үзнэ үү

**Зураг 5.2: Бодлого, институцын хүчин зүйлийн Зөрүүгийн шинжилгээ**




Эдгээр хоёр график буюу Зураг 5.1, 5.2-оос харахад Монгол Улсын уул уурхайн хөрөнгө оруулалтын орчин муу байгаагийн ихэнх шалтгааныг бусад улс орнуудтай харьцуулахад ихэвчлэн бодлого, институцийн хүчин зүйлээс шалтгаалж байгаа нь харагдаж байна. Дараах хэсгүүдэд бид харьцуулах боломжтой 3 улстай харьцуулсан зөрүүг шинжлэх болно.

*Баруун Австралитай харьцуулсан зөрүүгийн шинжилгээ.*

Өмнөх хэсэгт хийсэн зөрүүгийн шинжилгээг үргэлжлүүлж, энэ хэсэгт бид Монгол улсын хувьд стратегийн загвар болж буй Баруун Австралитай Монголыг харьцуулж үзлээ. Баруун Австрали нь бүх хүчин зүйлээр байнга дээгүүр байр эзэлдэг. Түүнчлэн одоогоор Монгол улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа хайгуулын компаниудын ихэнх нь Австралийн хөрөнгө оруулалттай, Австралийн хөрөнгийн биржэд бүртгэлтэй компаниуд байдаг. Иймд Монгол Улс уул уурхайн салбарын гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого боловсруулахдаа Баруун Австралийн практик, туршлагыг харгалзаж үзэх боломжтой.

Баруун Австралитай шууд харьцуулалт хийх үүднээс Монгол улсын хүчин зүйл тус бүрээр авсан 3, 4, 5 гэсэн онооны нийлбэр хувийг Баруун Австралийн авсан эдгээр онооны нийлбэрээс хассан. Энэ зөрүү нь хоёр улсын хоорондын ялгааг буюу Монгол Улс Баруун Австралитай ижил түвшинд хүрэхэд хэр их зүйлийг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна. Үүнийг Зураг 5.3-аас харахад хэрэв Монгол улс Баруун Австралийн түвшинд хүрэхийг хүсвэл *Хууль эрх зүйн тогтолцоо, Хүчин төгөлдөр үйлчилж буй дүрэм журмын зохицуулалт, тайлбар, хэрэгжүүлэлттэй холбоотой тодорхой бус байдал, Улс төрийн тогтвортой байдал, Татварын зохицуулалтын орчныг* тус тус хамгийн их сайжруулах шаардлагатай байгаа нь илт байна.

**Зураг 5.3: Баруун Австрали, Монгол улс хоорондын зөрүү**




#### Чили улстай харьцуулсан зөрүүгийн шинжилгээ

Зураг 5.4-т үзүүлсэнчлэн, *одоо хүчин төгөлдөр үйлчилж буй дүрэм журмын зохицуулалт, тайлбар, хэрэгжүүлэлттэй холбоотой тодорхой бус байдал* болон *Хууль эрх зүйн тогтолцоо* нь Баруун Австралийн нэгэн адил Чили болон Монгол улсын хоорондын зөрүүд хамгийн их нөлөөлж байна. Энд *Маргаантай газрын нэхэмжлэлтэй холбоотой тодорхой бус байдал* болон *Дэд бүтцийн чанар* нь эдгээр хоёр улсын хоорондын зөрүүд нөлөөлж буй хүчин зүйлсийн тавдугаарт бичигддэг *Татварын горимоос* илүү нөлөөлж байна.

Иймд Монгол Улс Чили улстэй ижил уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтыг татахын тулд дээрх хүчин зүйлсийн тодорхой бус байдлыг уул уурхайн салбарт нөлөөлөх хэмжээнд эрс бууруулж, хууль эрх зүйн тогтолцооны найдвартай байдлыг сайжруулах шаардлагатай. Татварын горим болон Дэд бүтцийн чанарын ялгаа нь хоёр улсын хоорондын зөрүүнд тийм ч их байр суурь эзэлдэггүй.


#### Зураг 5.4: Чили улс ба Монгол улсын хоорондын Зөрүү



### Замби улстай харьцуулсан зөрүүгийн шинжилгээ

Баруун Австрали, Чили улстай харьцуулсан зөрүүгийн нэгэн адил *Маргаантай газрын нэхэмжлэлтэй холбоотой тодорхой бус байдал* болон *Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй дүрэм журмын зохицуулалт, тайлбар, хэрэгжүүлэлттэй холбоотой тодорхой бус байдал* нь Замби болон Монгол улсын хоорондын зөрүүд хамгийн их нөлөөлж байна. *Хууль эрх зүйн тогтолцоо, Татварын зохицуулалт* нь энэ зөрүүд хамаагүй бага нөлөөтэй байгаа нь энэ хоёр хүчин зүйл нь хоёр улсын хувьд ижил түвшинд, харин Замби улсад Монголоос илүү дээр байна гэсэн үг юм. *Шилдэг туршилагын бодлого хэрэгжүүлсэн тохиолдолд Ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулах боломж, Ажиллах хүч, ур чадварын боломж, Худалдааны саад бэрхшээл, Дэд бүтцийн чанар, болон Геологийн мэдээллийн сангийн чанар* зэрэг хүчин зүйлүүд бүгд Монгол улсад Замби улсаас илүү сайн гэж хөрөнгө оруулагчид төсөөлдөгийг тэмдэглэх нь зүйтэй юм.

**Зураг 5.5: Замби улс ба Монгол улсын хоорондын Зөрүү**



## 6. МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН СВОТ-ЫН ШИНЖИЛГЭЭ

Тайлангийн энэ хэсэгт Монголын уул уурхайн салбар, түүний хөрөнгө оруулалтын орчинд СВОТ (SWOT)-ын шинжилгээний аргыг ашиглан дүн шинжилгээ хийсэн болно<sup>2</sup>. Энэ нь Монголын уул уурхайн салбарыг бусад орнуудтай харьцуулсан давуу болон сул талуудад дүн шинжилгээ хийж, ГШХО-ыг татах, ялангуяа УУСОТС-д ороогүй Монгол Улсад тулгарч буй асуудал, сорилтуудыг тодорхойлох үндсэн зорилготой. Энэ хэсэгт Баруун Австрали биш харин Австрали улсыг харьцуулах улсуудын нэг болгон ашигласан болно.

Энэхүү судалгааны зорилгоор Монгол улсын СВОТ-ын шинжилгээний “Сул тал”-ын шинжилгээнд түлхүү анхаарах нь зүйтэй. Эдгээр нь улсын хэмжээнд шинээр ашигт малтмал олборлох, хайгуулын хөрөнгө оруулалт орж ирэхийг саатуулж байгаа дотоод хүчин зүйлүүд бөгөөд эдгээрт Засгийн газар зохицуулалт хийх бүрэн эрх, боломжтой юм.

### *Давуу талууд*

Монголын уул уурхайн салбарын харьцангуй давуу талуудын гол хөдөлгөгч хүчин зүйл нь ашигт малтмалын ордын арвин их нөөц, түүхий эдийн эрэлтийн гол төв болох Хятад улстай газарзүйн хувьд ойрхон байдал юм. Монгол Улс үндэстэн ястны, үндэс угсаа, шашин хоорондын ноцтой зөрчилдөөнгүй, энх тайван орон учраас аюулгүй байдлын эрсдэл, терроризмын аюул багатай.

Монгол Улсын хүн ам залуу, боловсролтой, мөн чанартай ажиллах хүчтэй нь давуу тал болохын зэрэгцээ ажиллах хүчний өртөг нь бусад оронтой харьцуулахад харьцангуй бага байдаг. Монголчууд шинэ дижитал технологид хурдан дасан зохицоход боломж олгох гар утас, интернетийн хүртээмж сайн байдаг. Жишээлбэл, 15 ба түүнээс дээш насны хүн амын бараг 93% нь санхүүгийн байгууллага, мобайл санхүүгийн үйлчилгээг цахимаар авдаг (Хүснэгт 6.1-ийг үзнэ үү).

2019 оны ОУИТБС-ын тайланд<sup>3</sup> Монгол Улсыг ОУИТБС-ын зарчмуудыг сайн дагаж мөрдөж байгааг хүлээн зөвшөөрч, "даган мөрддөг" улсын статус олгосон. 2018 оны хоёрдугаар сард “Байгалийн баялаг ихтэй 50 гаруй улс ОУИТБС-д нэгдсэнээс Монгол Улс ОУИТБС-ын стандартын бүх шаардлагыг хангасан хоёр дахь орон болсон нь тус улсын хувьд гайхалтай амжилт болсон” хэмээн онцолжээ.

<sup>2</sup> Монгол улсын уул уурхайн хөрөнгө оруулалтын орчинд СВОТ (SWOT)-ын шинжилгээ хийсэн бөгөөд үүнд Давуу тал, Сул тал, Боломж, Аюул занал бий болгож буй янз бүрийн хүчин зүйлсийг жагсааж, дөрвөн квадрат бүхий матрицад дүрсэлсэн. Давуу болон Сул тал нь дотоод хүчин зүйл, харин Боломж, Аюул занал нь гадны нөлөөллөөс шалтгаалдаг. Хэрэв хүсвэл эхний хоёрыг нь (зарим хэмжээгээр) өөрчлөх боломжтой, харин сүүлийн хоёр нь гадны хүчин зүйл учраас өөрчлөгдөхгүй. Стратегийн хувьд энэ нь аливаа байгууллага (эсвэл засгийн газар) давуу талыг сайжруулах, сул талыг арилгах эсвэл багасгахын тулд ажиллах боломжтой боловч боломж, аюул заналтай дасан зохицох шаардлагатай болно гэсэн үг юм.

<sup>3</sup> [https://eiti.org/files/documents/eiti\\_14\\_report\\_en-20201230\\_mongolia\\_report\\_2019.pdf](https://eiti.org/files/documents/eiti_14_report_en-20201230_mongolia_report_2019.pdf)



**Хүснэгт 6.1. Сонгогдсон хөгжлийн үзүүлэлтүүд**

<b>Сонгогдсон үзүүлэлтүүд</b>	<b>Монгол</b>	<b>Австрали</b>	<b>Чили</b>	<b>Замби</b>
Санхүүгийн байгууллага эсвэл мобайл мөнгөний үйлчилгээний байгууллагын данс эзэмшсэн байдал (15 ба түүнээс дээш насны хүн амын хувь), 2017 он.	92.97	99.52	74.35	45.86
Бичиг үсэг тайлагдалтын түвшин, нийт насанд хүрэгсдийн (15 ба түүнээс дээш насны хүн амын хувь), 2018 он.	98.42		96.40 (2017)	86.75
Үүрэн холбооны операторын хэрэглээ (100 хүн тутамд), 2016 он.	111.24	110.05	130.11	72.43
Хөдөлмөр эрхлэгчдийн сарын дундаж орлого, ам.доллар*	433.87 (2020)	4467.22 (2018)	1151.5 (2019)	240.92 (2019)

Эх сурвалж: Дэлхийн банкны Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд

\* ОУХБ

Хүснэгт 6.2-т Монгол улсад тодорхойлсон СВОТ-ын шинжилгээний олон төрлийн хүчин зүйлсийг тоймлон харуулав.

**Хүснэгт 6.2: Монголын уул уурхайн салбарын СВОТ-ын шинжилгээ**

<b>ДАВУУ ТАЛУУД</b>
Байгалийн арвин баялаг, тэр дундаа зэс, нүүрс, алтны өндөр чанартай ордууд, мөн ихэнх судлагдаагүй газар нутгийг харгалзан нэмэлт нээлт хийх асар их боломж, бололцоо
Томоохон хэрэглэгчийн зах зээл, дэлхийн эрэлт хэрэгцээний төв болох Хятад улстай газарзүйн хувьд ойр байдал
Аюулгүй байдлын эрсдэл, террорист аюул заналын түвшин бага
Улсын хэмжээнд интернэт, үүрэн холбооны сүлжээний хамрах хүрээ сайн
Уул уурхайн талбай болон ирээдүйд олборлолт хийх боломжтой газруудад нэвтрэх боломж сайтай, учир нь хүн амын нягтрал бага, ургамал багатай
Залуу, боловсролтой, чадварлаг боловсон хүчин
ОУИТБС-ын зарчмуудыг сайн дагаж мөрддөг
Ажиллах хүчний зардал харьцангуй бага

<b>СУЛ ТАЛУУД</b>
<i>Нийгэм-эдийн засгийн хүчин зүйлс:</i>
Улс төрийн тогтворгүй байдал
Тусгаар тогтнолын байдал эрсдэлтэй, өөрийн хөрөнгийн өртөг өндөр
Баялгийг өмчирхөх үндсэрхэг үзэл, популист хөдөлгөөн
Авлигын түвшин өндөр
<i>Бодлого ба институцийн хүчин зүйлс:</i>

Хууль эрх зүй, зохицуулалт, бодлогын тогтолцоо сул
Уул уурхайн татварын хувь хэмжээ, ялангуяа ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ өрсөлдөхүйц биш
Төрийн уул уурхайн орлогын менежмент сул байна
Засгийн газрын өөрчлөлтөөс шалтгаалж бодлого, зохицуулалтын орчин байнга өөрчлөгдөж байдаг
Уул уурхайн салбарт ГШХО зэрэг хөрөнгө оруулалтыг татах манлайлагч байгууллага дутмаг
Хөрөнгө оруулалт татах агентлагуудын институцийн чадавхи сул
Засгийн газар хөрөнгө оруулагчидтай олон удаа маргаан үүсгэсэн түүх
Салбар болон ГШХО-ын талаар олонд танигдсан амжилтын түүх эсвэл сүүлийн үед хүчтэй эерэг мессеж байхгүй
<i>Нийлүүлэлтийн тал ба үйлдвэрлэлтэй холбоотой хүчин зүйлүүд:</i>
Уул уурхайн салбар маш цөөн тооны том уурхайгаас хамааралтай
Хязгаарлагдмал хайгуулын ажлаас үүдэн нарийн хэлэлцээрийн шугамтай
Судалгаа болон хөгжүүлэлт, шинэ технологи, ялангуяа жижиг уул уурхайн хөрөнгө оруулалт бага
Дэд бүтэц дутмаг, эрчим хүчний хангамжийн хомсдол
Хилийн боомтуудын экспортын ложистикийн гацаа
Далайд гарцгүй улс
Үйлдвэрлэлийн зардал харьцангуй өндөр

<b>БОЛОМЖ</b>
Гол эрдэс бүтээгдэхүүний дэлхийн эрэлт хэрэгцээ, үнэ өсөх боломжтой
Шинэ томоохон ордуудыг илрүүлсэн
Гадаадын хөрөнгө оруулагчидтай томоохон хэмжээний шинэ хэлэлцээр хийх
Гол эрдэс бүтээгдэхүүний нэмүү өртөг шингэсэн боловсруулах үйлдвэрүүдийн хөгжүүлэлт
Уул уурхайн салбарт үйлчлэх, дэмжих салбаруудын хөгжүүлэлт
Хий, нүүрсний давхаргын метан, газрын ховор элемент, устөрөгч, занарын хий зэрэг шинэ салбаруудын хөгжүүлэлт
Чөлөөт худалдаа, хоёр талын худалдаа, татварын гэрээ зэргийн байгуулалт

<b>АЮУЛ ЗАНАЛ</b>
Дэлхийн түүхий эдийн эрэлт үе үе буурч, улмаар Монголын гол эрдэс бүтээгдэхүүний үнэ буурах магадлалтай
Уур амьсгалтай холбоотойгоор чулуужсан түлшийг хоригловол Монголын эрчим хүчний нүүрсний экспортыг хязгаарлах эрсдэлтэй
Цар тахал/дэгдэлтийн улмаас хил хаагдах
Байгаль орчны гамшиг, уул уурхайн байгальд үзүүлэх сөрөг нөлөө
Хятад улстай хоёр талын харилцаа муудах
Монгол шиг эрсдэлтэй газарт хөрөнгө оруулах хөрөнгө оруулагчдын дур сонирхол буурах
Хөрөнгө оруулагчдын дунд шинэ хөрөнгө оруулагчдын маргаан, Монголын талаарх сөрөг сурталчилгаа

Бид СВОТ-ын хүснэгтийн Сул талуудыг илүү анхаарч үзэхдээ энд тусгасан хүчин зүйлсийг *Нийгэм-эдийн засгийн, Бодлого, институцын, болон Ханган нийлүүлэлт, аж үйлдвэртэй холбоотой* гэсэн гурван өргөн хүрээнд ангилж болно.

Монгол Улсын улс төр, нийгэм эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал нь Монголын уул уурхайн салбарын өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулагчдын сонирхолд нөлөөлж байна. Тухайлбал, Монголын Улсын төрийн түвшинд Засгийн газар байнга солигдож, түүнээс үүдэлтэй бодлогын чиг баримтжаа байнга өөрчлөгддөг. 2009 оны аравдугаар сараас хойшхи сүүлийн 12 жилийн хугацаанд Монгол Улсын Ерөнхий сайд зургаан удаа солигдож тус бүр дунджаар хоёр жилийн хугацаанд ажилласан. Засгийн газрын бүрэлдэхүүний өөрчлөлт, үүнээс үүдсэн төрийн албан хаагчдын халаа сэлгээ нь тогтворгүй орчинг бий болгож, хувийн хэвшлийн тоглогчид, хөрөнгө оруулагчдын урт хугацааны, тогтвортой төлөвлөлт, үйл ажиллагаанд саад учруулж байна. Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт маш том бөгөөд маш урт хугацааны байдаг. Тиймээс хөрөнгө оруулагчид улс төрийн хувьд маш тогтвортой, эсвэл холбогдох бодлого нь засгийн газрын өөрчлөлтөөс хамаардаггүй улс орныг илүүд үздэг.

Энэхүү тайлангийн 2-р хэсэгт дурдсанчлан 2000-аад оны эхээр Монголд хайгуулын компаниуд олшрохын зэрэгцээ дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн өссөний лараа тус улсад баялгийг өмчирхөх үндсэрхэг үзэл бий болсон бөгөөд байгаль орчныг хамгаалах, уул уурхайг эсэргүүцэх, гадаадын хөрөнгө оруулагчдын эсрэг сурталчилгаа хийх олон тооны төрийн бус байгууллага, улс төрийн хөдөлгөөнүүд бий болсон. Орон нутгийн засаг захиргааны дэмжлэг ч тодорхой хэмжээгээр суларч байна. Тухайлбал, Хөвсгөл, Завхан, Увс аймаг уул уурхайг дэмжихгүй гэдгээ мэдэгдсэн. Өмнө нь Хөвсгөл, Дорнод аймгийн иргэд нутаг дэвсгэртээ уул уурхайн төслийг эсэргүүцэж жагсаал цуглаан зохион байгуулж байсан.

Авлигын түвшин өндөр гэсэн төсөөлөл нь Монголын бас нэг том сул тал юм. Транспэрэнси Интернэшнл байгууллагын 2020 оны Авлигын төсөөллийн индекс<sup>4</sup>-ээр Монгол Улс 180 орноос 111-д жагссан байна. Харин Австрали улс 11-д, Чили 25-д жагсчээ. Замби улс 117 дугаарт бичигджээ.

Хэдийгээр Монгол Улс уул уурхайн орлогоос улсын баялгийн сан байгуулах санааг олон жилийн турш туршиж, өнгөрсөн хугацаанд ИӨС-ийн янз бүрийн хэлбэрийг туршиж үзсэн ч уул уурхайн орлогын зөв менежментийг дэмжих томоохон хэмжээний хөрөнгийн хуримтлал үүссэнгүй. Хамгийн сүүлд байгуулагдсан Монголын Ирээдүйн өв сан нь 2020 оны эцэст ойролцоогоор 326 сая ам. долларын хөрөнгөтэй байсан ч саяхан уг санг Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулахад ашиглах шийдвэр гаргасан. Иймд уул уурхайн салбарын оролцогч талууд болон ард иргэдийн дунд Засгийн газар уул уурхайн орлогыг удирдаж байгаа байдалд сэтгэл хангалуун бус байх төлөв байдал нэмэгдсээр байна.

Монгол Улсын улс төр, нийгэм эдийн засгийн орчны сул тал нь дэлхийн зээлжих зэрэглэлийг үнэлэх байгууллагаас Монгол улсад өгсөн зээлжих зэрэглэлийн түвшингээр тод илэрнэ. Харьцуулах боломжтой орнууд болох Австрали, Чили улсуудтай харьцуулахад зээлжих зэрэглэл доогуур байгаа нь Монгол дахь төслүүдэд хөрөнгө босгоход хөрөнгийн өртөг өндөр болж, Монголыг хөрөнгө оруулалтын эрсдэлтэй орон гэж ойлгоход хүргэж байна.

### Хүснэгт 6.3. Харьцуулах боломжтой орнуудын зээлжих зэрэглэл

<sup>4</sup> <https://www.transparency.org/en/countries/mongolia>

Улс	Фитч <sup>5</sup> , урт хугацааны үнэлгээ	Мүүдис <sup>6</sup>
Монгол	B, 2021 оны 5-р сарын 25	B3, 2021 оны 10-р сарын 30
Австрали	AAA, 2021 оны 10-р сарын 13	Aaa, 2021 оны 10-р сарын 30
Чили	A, 2021 оны 10-р сарын 21	A1, 2021 оны 10-р сарын 26
Замби	RD, 2021 оны 4-р сарын 12	Ca, 2021 оны 10 дугаар сарын 19

УУСОТС-ыг явуулах явцад Монгол Улсын бодлого, институцын олон сул талууд илэрсэн бөгөөд тайлангийн өмнөх хэсгүүдэд хэлэлцсэн. Энэ нь харьцуулах боломжтой орнуудтай харьцуулахад Монгол Улс хамгийн их сайжруулалт хийх шаардлагатай талбар юм. Нэг жишээ татахад, Монгол Улс уул уурхайн татварын хувь хэмжээгээр, тэр дундаа ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр олон улсад өрсөлдөх чадваргүй гэдгийг дурьдаж болно. Монголын Бизнесийн зөвлөлийн 2019 оны баялгийн нөөц ба байгаль орчны ажлын хэсгийн хуралдааныг үеэр Монгол Улсын татварын горимыг “ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ хэт өндөр, татварын хөнгөлөлт, урамшуулал байхгүй, ..., аж үйлдвэрийн зориулалттай эрдэс бүтээгдэхүүний хувьд татварын хувь хэмжээ нь өрсөлдөхүйц биш” гэж тодорхойлсон.

Түүнчлэн 2021 онд Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд бэлтгэсэн “Дагалдах металл, бүтээгдэхүүнд Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах тухай хэлэлцүүлгийн баримт бичиг”<sup>7</sup>-т “Монгол Улсын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах горим нь олборлогч ашигт малтмалын бүтээгдэхүүнд агуулагдах гол металлын борлуулалтын үнээс гадна нэмэлт “урамшуулал” буюу төлбөр авдаг дагалдах металл, бүтээгдэхүүнд нөөц ашигласны төлбөр ногдуулах олон улсын жишигээс хальж, улмаар:

-Худалдан авагч хайлуулах, цэвэршүүлэх үйл явцад хорттой нөлөө үзүүлдэг шалтгаанаар гол металлын борлуулалтын үнээс “торгууль”-ийг хасагдуулж тооцдог эрдэс /элементүүдэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулж байгаа, бөгөөд ... Монгол дахь зэсийн баяжмалд ногдуулж буй нөөц ашигласны төлбөр нь Баруун Австралийнхаас хамаагүй өндөр байна (тухайлбал, Баруун Австралид 52.97 ам.доллар бол Монгол улсад 209.90 ам. доллар). Монголын нөөц ашигласны төлбөрийн орлогын дийлэнх хувийг зэсийн үнийн өсөлтөөс хамаарч 5 хувийг 12 хувийн нөөц ашигласны төлбөр дээр нэмсэн дүнгээр ногдуулсан нөөц ашигласны төлбөр эзэлж байна.”

Энэ чиглэлийн бас нэг томоохон сул тал нь улсын байгууллагын удирдлага, хөрөнгө оруулалтыг дэмжих институцын чадавхи сул байгаа явдал юм. Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулах байгууллагуудын үйл ажиллагаа, чиг үүрэг, эрх мэдэл нь давхцах тохиолдол их бий. Засгийн газрын хувь эзэмшигчийн чиг үүргийг зохицуулах, бодлого боловсруулах чиг үүргээс нь салгаж зааглахгүй байх нь ихэвчлэн ашиг сонирхлын зөрчилд хүргэдэг.

<sup>5</sup> [www.fitchratings.com](http://www.fitchratings.com)

<sup>6</sup> [www.moody.com](http://www.moody.com)

<sup>7</sup> <https://www.bcmongolia.org/en/resources-and-environment-wg-news/is-the-mongolian-mining-sector-in-crisis.html>

<sup>8</sup> [https://amep.mn/userfiles/files/PDF/Royalty%20Report\\_Eng.pdf](https://amep.mn/userfiles/files/PDF/Royalty%20Report_Eng.pdf)

Төв болон орон нутгийн засаг захиргааны чиг үүргийн хооронд давхцал, ойлгомжгүй байдлаас шалтгаалж төв засгийн газар нь орон нутгийн засаг захиргаатай тууштай, хүчтэй харилцаж чадахгүй байгаа нь тусгай зөвшөөрөл олгох үйл явцад нөлөөлж байна. Монголд хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны талаарх мэдээллийг төвлөрсөн, цогц байдлаар хүргэдэггүй, үүний улмаас хөрөнгө оруулагчын хүлээж авч байгаа Монголын хөрөнгө оруулалтын орчны талаарх мэдээлэл нь хэсэгчилсэн, эсвэл бүр зөрчилтэй мэдээлэл байдаг гэж УУСОТС-нд ярилцлага өгсөн олон хүн дурдсан байдаг.

Нийлүүлэлтийн талын болон аж үйлдвэртэй холбоотой хүчин зүйлсийн хязгаарлалт нь салбарын сул талыг улам бүр нэмэгдүүлж байна. Бүтцийн хувьд Монголын уул уурхайн салбар цөөн тооны томоохон уурхайгаас хамааралтай. Цаашилбал, лицензийн хоригийн улмаас хайгуулын үйл ажиллагаа багассан нь уул уурхайн хөрөнгө оруулалтын мөчлөгийг тасалдуулж, улмаар хөрөнгө оруулалт хийх боломж эрс цөөрч, хэлцэл хийх боломжийг бууруулсан. Хүснэгт 6.4-ээс харахад Монгол Улс ашиглагдаж буй уурхайн тоо болон уул уурхайн төслийн тоогоор харьцуулах боломжтой улс орнуудаас эрс цөөн байгааг харж болохоор байна.

**Хүснэгт 6.4. Олборлолт хийж буй металл ба уул уурхайн төслийн тоо (S&P Global 2021)**

	Монгол	Австрали	Чили	Замби
Үйлдвэрлэл	9	305	126	70
Үйлдвэрлэлийн өмнөх	4	3	9	5
ТЭЗҮ	1	18	17	3
Нөөц	4	53	56	20
<b>Нийт</b>	<b>18</b>	<b>379</b>	<b>208</b>	<b>98</b>

Монгол улс нь (Замби улсын нэгэн адил) далайд гарцгүй, далайн боомтод нэвтрэх боломжгүй орон бөгөөд энэ нь бусад улсруу бараа экспортлох тээврийн зардал, Хятадаас өөр бүтээгдэхүүн экспортлох боломжтой орны тоогоор сул талтай болгож байна. Экспорт хийхэд тулгалж буй саад бэрхшээл, худалдааны логистикийн асуудал нь дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөлөөгөөр улам хүндэрсэн. Экспортын хэмжээнд шууд их нөлөөлөөгүй ч шилжүүлэн ачих хүчин чадал, эрүүл мэнд, аюулгүй байдлын стандарттай холбоотой асуудлууд нь тээврийн зардлыг нэмэгдүүлсэн. Дэлхийн банкны “Бизнес эрхлэх нь 2020” тайлан<sup>9</sup>-гийн “Хил дамнасан худалдаа” гэсэн ангилалд Монгол Улс хамгийн доогуур бичигдсэн (Хүснэгт 6.5-ыг үзнэ үү).

**Хүснэгт 6.5. Сонгосон үзүүлэлтээрх эрэмбэ, Дэлхийн банкны Бизнес эрхлэх нь тайлан 2020**

Эдийн засаг	Дэлхийн эрэмбэ	Цахилгаан эрчим хүч авах боломж	Зээл авах боломж	Татвар төлөлт	Хил дамнасан худалдаа хийх боломж
Монгол	81	152	25	71	143

<sup>9</sup> <https://www.doingbusiness.org/content/dam/doingBusiness/country/m/mongolia/MNG.pdf>

Австрали	14	62	4	28	106
Чили	59	39	94	86	73
Замби	85	129	4	17	155

Монгол улсын дэд бүтэц, эрчим хүчний хангамж сул байгаа нь үйлдвэрлэлийн өртөг харьцуулах боломжтой орнуудтай харьцуулахад илүү өндөр байгаад нөлөөлж байж болзошгүй (доорх Хүснэгт 6.6-г үзнэ үү).

**Хүснэгт 6.6. Үйлдвэрлэлийн өртөг фунт тутамд, Зэс (C1)**

Уурхай	Байршил	Хөрөнгө оруулагч компани	C1, ам.доллар	Эх сурвалж
Оюу толгой	Монгол	Рио Тинто	1.45	Торкуойс Хилл-ийн жилийн тайлан, 2020
Эскондида	Чили	ВНР	1.00	ВНР-ийн жилийн тайлан, 2021
Кансанши	Замби	Фирст Куантум	1.21	Фирст Куантумийн жилийн тайлан, 2020
ДеГрусса	Баруун Австрали	Сэндфайр	0.81	Сэндфайр, 2021

### *Боломж ба аюул занал*

Зарим гадаад хүчин зүйлс нь яаж үйлчлэхээсээ хамаараад хэрхэн Монгол улсад боломж эсвэл аюул занал бий болгож болохыг СВОТ-ын хүснэгтээс харж болохоор байна. Тухайлбал, гол эрдэс бүтээгдэхүүний эрэлт, дэлхийн зах зээл дээрх үнийн өсөлт нь Монголын уул уурхайн салбарын үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлж, хөрөнгө оруулалтыг татах болно. Харин үүний эсрэгээр дэлхийн түүхий эдийн эрэлт үе үе буурч, улмаар Монголоос нийлүүлэх гол эрдэс бүтээгдэхүүний үнэ буурах магадлал нь Монголын өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлнө.

Томоохон шинэ ордуудыг нээх, гадаадын хөрөнгө оруулагчидтай томоохон хэмжээний шинэ хэлцлүүд хийх, гол эрдэс бүтээгдэхүүнийг боловсруулах нэмүү өртөг шингээсэн боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлэх, уул уурхайн салбарт үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх салбаруудыг хөгжүүлэх, байгалийн хий, нүүрсний давхаргын метан, газрын ховор элемент, устөрөгч, занарын хийн зэрэг шинэ үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь уул уурхайн салбарт ихээхэн бүтцийн сайжруулалт, харьцангуй давуу талыг авчрах болно.

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой чулуужсан түлшийг хориглох, цар тахлын дэгдэлттэй холбоотой удаан хугацааны хилийн хязгаарлалт, байгалийн гамшиг, уул уурхайн байгальд үзүүлэх сөрөг нөлөө, Хятадтай хоёр талын харилцаа муудах, хөрөнгө оруулагчдын Монгол шиг эрсдэлтэй газар руу тэмүүлэх сонирхол буурах, хөрөнгө оруулагчдын маргаан, хөрөнгө оруулагчдын дундах Монголын талаарх сөрөг мэдээлэл сурталчилгаа зэрэг нь Монголын уул уурхайн хөрөнгө оруулалтын орчинд занал учруулж байна.

### **Дүгнэлт**

Монгол Улс ашигт малтмалаар баялаг, Хятадтай ойр оршдог учраас уул уурхай, хайгуулын хөрөнгө оруулагчдын сонирхолийг татдаг. Гэсэн хэдий ч СВОТ-ын шинжилгээ нь Сул талууд нь Давуу талуудаас давж, уул уурхайн салбарт ГШХО татах Монголын боломжийг хязгаарлаж байгааг харуулж байна. *Бодлого, институцийн* талбарын олон асуудлуудыг УУСОТС-ны үеэр болон харьцуулах

боломжтой улс орнуудад хийсэн УУСОТС болон Фрейзерийн судалгааны үр дүнг харьцуулах явцад илэрсэн.

СВОТ-ын шинжилгээний аргыг ашиглан харьцуулах боломжтой орнуудыг харьцуулж Монгол Улсад тулгарч буй бусад сорилтуудыг, ялангуяа *Нийгэм-эдийн засгийн хүчин зүйлс*, *Нийлүүлэлт* болон *Аж үйлдвэртэй холбоотой хүчин зүйлсийг* тодорхойлсон. Эдгээр харьцангуй сул талуудад дараах орно. Үүнд:

- Монгол Улсын зээлжих зэрэглэл бага
- Баялгийг өмчирхөх үндсэрхэг үзэл, популист хөдөлгөөн үүсэх
- Авлигын түвшин өндөр
- Уул уурхайн орлогыг удирдах Засгийн газрын арга барил сул
- Уул уурхайн салбарын ГШХО зэрэг хөрөнгө оруулалтыг дэмжих манлайлагч институци дутмаг
- Уул уурхайн салбар маш цөөн тооны том уурхайгаас хамааралтай
- Хайгуулын үйл ажиллагаа бага байгаагийн улмаас шинэ хэлцлийн тоо хязгаарлагдмал
- Дэд бүтэц сул, эрчим хүчний хангамжи хомс
- Хилийн боомтуудын экспортын ложистикийн гацаа
- Үйлдвэрлэлийн өртөг харьцангуй өндөр

Эдгээр асуудал нь Монголын уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг бууруулж, Монгол Улсыг дэлхийн хөрөнгө оруулалтын талбарт харьцуулах боломжтой орнуудтай харьцуулахад сул талтай байдалд оруулж байна. Монгол Улс бараг бүх үзүүлэлтээр, ялангуяа Австрали, Чилитэй харьцуулахад ихээхэн хоцрогдолтой байна.

# 7. КЕЙСИЙН СУДАЛГАА

Монгол улстай харьцуулах боломжтой Баруун Австрали, Чили, Замби зэрэг сонгогдсон орнуудын уул уурхайн хөрөнгө оруулалтын орчинтой холбоотой асуудлуудыг авч үзсэн гурван кейсийн судалгааг энэ хэсэгт танилцуулах болно.

## 7.1 Баруун Австралийн уул уурхайн хөрөнгө оруулалтын орчин - Хязгаарлалт ба урамшуулал

### Баруун Австралийн тойм

- Фрейзер институтээс 2019 онд хийсэн үнэлгээгээр ашигт малтмалын хайгуулын хөрөнгө оруулалт хийх боломжоор (Хөрөнгө оруулалт хийх боломжийн индекс) №1 гэсэн үнэлгээ авсан.
- Төмрийн хүдэр, алт, шингэрүүлсэн байгалийн хий, хөнгөн цагаан, боксит зэрэг гол ашигт малтмалуудыг олборлодог.
- 2020-2021 оны байдлаар уул уурхайн 125 үндсэн төсөл хэрэгжиж байсан<sup>10</sup>.
- 2020-2021 оны санхүүгийн жилд ашигт малтмал, газрын тосны үйлдвэрлэл 209 тэрбум австрали доллар, экспорт 205 тэрбум австрали доллар байсан.
- 2020-2021 онд уул уурхай, газрын тосны салбарт 21 тэрбум австрали долларын хөрөнгө оруулалт хийгдсэн (сүүлийн таван жилийн хамгийн өндөр үзүүлэлт) нь гол төлөв Рио Тинто, ВНР болон Fortescue Metals Group-ийн төмрийн хүдрийн үйлдвэрлэлийг дэмжих томоохон төслүүдэд хийсэн хөрөнгө оруулалт, түүнчлэн FMG-ийн Төмөр гүүр магнетит төсөлд оруулсан хөрөнгө оруулалт байсан.
- Баруун Австралийн уул уурхай, газрын тосны салбарын хөрөнгө оруулалт улсын нийт хөрөнгө оруулалтын 58 хувийг эзэлдэг (10 жилийн дундаж нь 56 хувь юм).

### Уул уурхайн салбар дахь ГШХО-ын хязгаарлалт

Австрали нь холбооны улс бөгөөд хууль тогтоомж нь холбооны болон мужийн гэсэн хоёр түвшинд үйлчилдэг. Хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг үндсэндээ муж улсын түвшинд зохицуулдаг боловч албан татвар, уугуул иргэдийн газар өмчлөх эрх, гадаадын хөрөнгө оруулалтын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах зэрэг зарим асуудлыг холбооны хуулиар зохицуулдаг.

1975 онд батлагдсан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн (FATA) дагуу Австралийн Төрийн сангийн дарга нь Гадаадын хөрөнгө оруулалтыг хянах зөвлөл /ГХОХЗ/<sup>11</sup>-өөс гаргасан зөвлөмжийн дагуу гадаадын компаниудын хөрөнгө оруулалтыг хянадаг. Үүнээс гадна ГХОХЗ нь дараахь чиг үүргийг хариуцдаг. Үүнд:

- гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой үйл ажиллагааны талаар зөвлөгөө өгөх;
- Австралийн гадаадын хөрөнгө оруулалтын бодлогын талаарх мэдлэг, ойлголтыг төлөвшүүлэх;
- гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалтын талаар гадаадын этгээд, тэдгээрийн төлөөлөгч, зуучлагчдад зориулсан заавар зөвлөмж гаргах; түүнчлэн
- гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжийн даган мөрдөлтөд хяналт тавих.

<sup>10</sup> <https://www.dmp.wa.gov.au/About-Us-Careers/Latest-Statistics-Release-4081.aspx> -аас авсан

статистик мэдээ

<sup>11</sup> [www.firb.gov.au](http://www.firb.gov.au)



ГХОХЗ нь зөвшөөрлийг авахыг хүссэн бүх хөрөнгө оруулалтын өргөдлийг хянан шийдвэрлэдэг. Үүнд:

- a. Австралид газар эзэмших эсвэл Австралид газар бүхий аж ахуйн нэгжийн (уурхай болон үйлдвэрийн байрыг оролцуулсан) хувийг эзэмших;
- b. Австралийн аж ахуйн нэгж эсвэл хөдөө аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг Австралийн бизнест шууд хувь эзэмших (ихэвчлэн 10 ба түүнээс дээш хувь);
- c. Австралийн аж ахуйн нэгжид ихээхэн хэмжээний хувь эзэмших (ихэвчлэн 20 ба түүнээс дээш хувь); эсвэл
- d. Австралийн хэвлэл мэдээллийн бизнест 5 ба түүнээс дээш хувь эзэмших.

Гадаадын этгээд уул уурхайн үйл ажиллагаа явуулах орон байр эсвэл газар эзэмшихийн тулд гадаадын хөрөнгө оруулалтын зөвшөөрөл авах шаардлагатай. ГХОХЗ-өөс гаргасан Уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт хийх Удирдамж 5<sup>12</sup> -д “Ашигт малтмалын олборлолт, үйлдвэрлэлийн зориулалттай орон байр гэж худалдан авахын тулд тухайн ажлын байрын үнэ цэнээс үл хамааран зөвшөөрөл авах шаардлагатай Австралийн газрын төрөл гэж тодорхойлсон. Чөлөөт худалдааны гэрээтэй зарим түншүүдийн хувийн хөрөнгө оруулагчдад илүү өндөр мөнгөн босго тавигддаг. Харин үндэсний аюулгүй байдлын газарт хамаарах уул уурхай, үйлдвэрлэлийн зориулалттай орон байрт хувийн эзэмших нь гадаадын бүх хөрөнгө оруулагчдын хувьд 0 ам.долларын босготой байна” гэж тусгасан. Түүнчлэн, “Гадаадын засгийн газрын хөрөнгө оруулагчид ашигт малтмал олборлолт, үйлдвэрлэл, хайгуулын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн хувьцааны үнийн дүнгээс үл хамааран 10 ба түүнээс дээш хувийг эзэмшихийн тулд Төрийн Сангийн даргад мэдэгдэж зөвшөөрөл авах ёстой”.

Хяналтын механизмд өөр хоёр чухал зохицуулалт бий. Нэгдүгээрт, удирдамжид “Уул уурхайн зориулалтаар ашиглах орон байртай холбоотой эрх эзэмшихдээ тухайн эрх нь газар эзэмших, түүнийг хянах, газарт нөлөөлөх эрх олгоогүй тохиолдолд гадаадын хөрөнгө оруулалтын хяналт шалгалтаас чөлөөлөгдөнө” гэж заасан.

Хоёрдугаарт, хайгуулын талбайг ашиглалтын болон үйлдвэрлэлийн орон байраас тодорхой салгаж өгсөн зохицуулалттай. Хайгуул хийх зориулалтаар талбай худалдаж авахдаа гадаадын засгийн газрын хөрөнгө оруулагчид болон үндэсний аюулгүй байдалд хамаарах газрыг эзэмшихээс бусад тохиолдолд гадаадын хөрөнгө оруулалтын зөвшөөрөл авахыг шаарддаггүй.

ГХОХЗ нь хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэр гаргаж, 40 хоногийн дотор мэдэгдэх ёстой. Олон хүсэлтийг нөхцөл болзолтойгоор шийдвэрлэдэг; харин татгалзсан хариу өгөх явдал маш бага байдаг.

### Хүснэгт 7.1. ГХОХЗ-ийн хянан шийдвэрлэсэн хүсэлтийн тоо

	2016-2017	2017-2018	2018-2019	2019-2020
Ямар ч нөхцөлгүйгээр зөвшөөрсөн	8,607	6,301	4,575	4,508
Нөхцөлтэйгээр зөвшөөрсөн	5,750	4,844	4,149	3,713
<b>Нийт зөвшөөрсөн</b>	<b>14,357</b>	<b>11,145</b>	<b>8,724</b>	8,221
Татгалзсан хариу өгсөн	3	2	1	3
Буцаасан		3		-
<b>Нийт шийдвэрлэсэн</b>	<b>14,360</b>	<b>11,150</b>	<b>8,725</b>	<b>8,224</b>

<sup>12</sup> <https://firb.gov.au/guidance-notes>

Татан авсан	770	644	670	715
Чөлөөлсөн	60	61	71	65
<b>Нийт хянан шийдвэрлэсэн</b>	<b>15,190</b>	<b>11,855</b>	<b>9,466</b>	<b>9,004</b>

Эх сурвалж: Гадаадын хөрөнгө оруулалтын зөвлөлийн Жилийн тайлан 2019–2020

2019-2020 онд ашигт малтмал, хайгуулын салбарын нийт 11.2 тэрбум австрали долларын хөрөнгө оруулалтыг баталсан нь нийт зөвшөөрөл олгосон хөрөнгө оруулалтын 6 хувийг эзэлж байна.

### Хүснэгт 7.2. Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын салбарын зөвшөөрөл

	2016-2017		2017-2018		2018-2019		2019-2020	
	№	Австрали доллар, тэрбум	№	Австрали доллар, тэрбум	№	Австрали доллар, тэрбум	№	Австрали доллар, тэрбум
Нүүрс	24	5.5	23	8.5	37	6.5	27	1.3
Газрын тос, байгалийн хийн олборлолт	17	1.1	20	1.6	17	4.1	14	2.5
Металл ашигт малтмал	73	6.3	51	4.9	43	4.6	34	3.1
Металл бус ашигт малтмалын ашиглалт, олборлолт	4	0.2	3		3	0.8	7	0.1
Хайгуул болон уул уурхайн бусад туслах үйлчилгээ	22	2.8	18	2.4	21	0.9	26	4.15
<b>Нийт</b>	<b>140</b>	<b>15.9</b>	<b>115</b>	<b>17.4</b>	<b>121</b>	<b>16.9</b>	<b>108</b>	<b>11.2</b>

Эх сурвалж: Гадаадын хөрөнгө оруулалтын зөвлөлийн Жилийн тайлан 2019–2020

### Баруун Австралийн уул уурхайн хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого

Баруун Австралийн Хөрөнгө оруулалт, худалдааны газраас Баруун Австралийг хөрөнгө оруулалт хийх газар сурталчилж, худалдаа, хөрөнгө оруулалттай холбоотой асуудлаар "нэг цонхны үйлчилгээ" үзүүлж Баруун Австралийн бизнесүүдэд бүтээгдэхүүн экспортлоход нь тусалдаг.

Уул уурхайн салбар бол эдийн засгийн гол салбар гэдгийг хүлээн зөвшөөрч, Мужийн засгийн газар нь Уул уурхай, аж үйлдвэрийн зохицуулалт, аюулгүй байдлын ямаараа дамжуулан энэ салбарыг тогтвортой хөгжүүлэх, дэмжих чиглэлээр олон арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. 2021-2022 оны Хөрөнгө оруулалт, худалдааны төлөвлөгөө<sup>13</sup>нд “Ашигт малтмалын салбар болон Баруун Австралийн Засгийн

<sup>13</sup> <https://www.wa.gov.au/government/document-collections/western-australian-investment-and-trade-plan-2021-22>

газар нь шинэ зах зээлд худалдаа, хөрөнгө оруулалтын боломжийг эрэлхийлэхэд гол анхаарлаа хандуулна. Баруун Австрали нь хэд хэдэн гол зах зээлтэй одоо байгаа хүчтэй худалдааны харилцаагаа улам бэхжүүлж, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийн үйл явцыг тууштай хэрэгжүүлэхийг зорьж байна. Найдвартай ханган нийлүүлэлтээс гадна Баруун Австрали нь уул уурхайн дэвшилтэт техникийг ашиглах туршлага, дэлхийн жишигт нийцсэн үйлчилгээний салбар, боломжийн, бат бөх хууль эрх зүйн орчин, Азийн гол зах зээлд ойр оршдог зэрэг харьцангуй давуу талтай." хэмээн тусгажээ.

Энэхүү төлөвлөгөөний дагуу мужийн засгийн газрын зүгээс хөрөнгө оруулалтыг дэмжих, уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, Баруун Австралид хайгуулын үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр төрөл бүрийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсээр байна.

Тухайлбал, мужийн засгийн газраас Баруун Австралийн байгалын нөөцийн салбарын үйл ажиллагааг сайжруулахын зэрэгцээ байгаль орчны нөхөн сэргээлт, уурхайн хаалтын зохицуулалтыг сайжруулах зорилгоор "Ашиглалтын зөвшөөрлийг шуурхай олгох" стратегийг хэрэгжүүлдэг. *Геологийн шинжлэх ухааны мэдээллийг боловсруулах стратегийн* хүрээнд Баруун Австралийн геологийн мэдээллийг машин сургалт, хиймэл оюун ухаанд ашиглах боломжтой өгөгдөл болгон хөрвүүлж байна.

Харин 2009 оны 4 дүгээр сард хэрэгжиж эхэлсэн Уул уурхайн хөрөнгийн түрээсийн орлогоор санхүүжүүлдэг *Хайгуулын хөрөнгө оруулалтын схем (ХХОС)* нь хамгийн их анхаарал татсан бодлогын санаачилга юм. 2021 оноос эхлэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай хайгуулыг дэмжих, улмаар ашигт малтмал, эрчим хүчний шинэ эх үүсвэр нээлтийг дэмжих зорилгоор жил бүр 10 сая австрали доллар хуваарилж байсныг 12.5 сая австрали болгон нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнд геофизикийн судалгаа, хэтийн төлөвийн зураглал, стратегийн судалгааны хамтын ажиллагааг дэмжих, аж үйлдвэртэй хамтран санхүүжүүлдэг хайгуулын үйл ажиллагааны хөтөлбөрүүд багтана. Шинэ нээлтүүд нь мужийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, мэдлэгийн санг нэмэгдүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэхэд тусалдаг гэж үздэг. ХХОС-ийн эхний 10 жилийн эдийн засгийн нөлөөллийн хөндлөнгийн үнэлгээний тайланд Баруун Австрали нь ХХОС-д оруулсан нэг доллар тутамд нийт 31 австрали долларын өгөөж хүртсэн гэсэн тооцоолол гарчээ<sup>14</sup>.

## Гол дүгнэлтүүд

- Холбооны засгийн газар болон мужийн засгийн газрын хариуцах асуудлыг тодорхой заагласан.
- Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж буюу ГШХО-ын хязгаарлалтын дагуу хяналтын үйл явцыг сайтар боловсруулсан бөгөөд, үр дүнтэй хэрэгжүүлдэг. Түүнчлэн, хууль эрх зүйн тогтолцоо нь хөрөнгө оруулалтыг дэмжихийн зэрэгцээ даган мөрдөлтийг баталгаажуулсан. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай хайгуулын үйл ажиллагаанд хяналт шалгалт хамаарахгүй.
- Баруун Австралийн Засгийн газар нь уул уурхайн салбарын орон нутгийн эдийн засагт оруулж буй хувь нэмрийг ойлгодог бөгөөд, хувийн операторуудтай хамтран хайгуулын ажилд тасралтгүй хөрөнгө оруулалт хийдэг. Энэ нь эдийн засгийн үр өгөөж өгдөг нь батлагдсан.
- Хэрэгжүүлж буй стратеүүд нь Баруун Австралийн уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг тасралтгүй сайжруулахад чиглэгддэг.

## 7.2 Чили улсын уул уурхайн хөрөнгө оруулалтын орчин - Хүнд сурталтай, тогтвортой, гэхдээ өөрчлөгдөж байна?

<sup>14</sup> <https://www.dmp.wa.gov.au/Geological-Survey/Exploration-Incentive-Scheme-1428.aspx>

## Чили улсын уул уурхайн салбарын тойм

- Уул уурхайн салбар нь Чили улсын эдийн засгийн тулгуур багана бөгөөд нийт төсвийн орлогын 40-43 хувь, ДНБ-ий 10 орчим хувь, экспортын талаас илүү хувийг тус тус бүрдүүлдэг (2019).
- Чили улс нь дэлхийн хамгийн том зэс үйлдвэрлэгч (одоогоор).
- Түүнчлэн, алт, молибден, лити (дэлхийн 2 дахь том үйлдвэрлэгч) зэрэг бүтээгдхүүнийг голлон үйлдвэрлэдэг.
- 2020 онд 458 сая ам.долларыг хайгуулын үйл ажиллагаанд төсөвлөн зарцуулсан.
- 2020-2029 онд уул уурхайн салбарын нийт 49 төсөлд, түүний дотор 32 зэс олборлох төсөлд нийт 74,05 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байна.
- Эдгээр хөрөнгө оруулалтын 32 хувийг ногоон талбайн хайгуулын 19 төсөлд оруулахаар төлөвлөж байна.<sup>15</sup>

## Тусгай зөвшөөрөл олгох тогтолцоо

Бүх ашигт малтмал улсын өмч бөгөөд компаниуд ашигт малтмал олборлохын тулд тусгай зөвшөөрөл авах шаардлагатай болдог. Ашигт малтмал, хайгуулын төслийн 98 орчим хувь нь цөл газарт байрладаг учраас усны ашиглалтыг зохицуулдаг ижил хууль эрх зүйн зохицуулалттай.

Чили улсад ашигт малмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл авах үйл явц нь нэлээд хүнд сурталтай боловч нарийн зохицуулагдсан байдаг.

Хайгуулын тусгай зөвшөөрлийг шүүх бүрэлдэхүүн олгодог. Тусгай зөвшөөрөл авах талбайн хэмжээ нь эхний ээлжинд 100-5000 га байх ёстой. Лицензийн талбай дээр хайгуул хийж эхлэхээс өмнө байгаль орчны зөвшөөрөл авах шаардлагагүй бөгөөд тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахын тулд тодорхой ажил гүйцэтгэсэн байх шаардлага тавьдаггүй. Тусгай зөвшөөрөл эзэмшигч жилийн хураамж төлнө. Хайгуулын тусгай зөвшөөрлийг эцэслэн олгохоос өмнө хүсэлт болон холбогдох бичиг баримтыг хэд хэдэн төрийн байгууллагуудыг хэд хэдэн үе шаттайгаар (тус бүр тодорхой хугацаанд) хянаж нягтлах ёстой. Хайгуулын тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаатай (талбайн 50%-ийг чөлөөлсөнийн дараа дахиж 2 жилээр сунгах боломжтой) олгодог.

Уурхайн бүтээн байгуулалтыг хийж ашиглахын тулд ашиглалтын тусгай зөвшөөрөл авах шаардлагатай. Хайгуулын тусгай зөвшөөрлийг хугацаа нь (2 эсвэл 4 жил) дуусахаас өмнө ашиглалтын тусгай зөвшөөрөл болгон хувиргаж болно. Ашиглалтын тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргах үйл явц нь илүү нарийн төвөгтэй бөгөөд 1-10 га талбайг хамрах боломжтой. Ашиглалтын тусгай зөвшөөрөл авахын тулд байгаль орчны зөвшөөрөл, уурхайг хаах төлөвлөгөө боловсруулсан байх шаардлагатай. Уурхайд ажиллах ажиллах хүчний 85 хувийг Чили улсын иргэд эсвэл оршин суугчдыг бүрдүүлэх ёстой. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг үндэсний аюулгүй байдлын асуудал үүсгэж болзошгүй хилийн ойролцоо байхаас бусад тохиолдолд гадаадын этгээд эзэмшихэд ямар нэгэн хориг хязгаарлалт байхгүй. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг хугацаагүй олгодог бөгөөд жилийн төлбөр хураамж тооцдог.

## Нөөц ашигласны төлбөр

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийт борлуулалтын хэмжээ 12 мянган тонн зэсийн борлуулалтын үнэд хүрмэгц уг металлыг ашигласнаас олсон “жилийн үйл ажиллагааны орлого”-д ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулдаг. Жилийн борлуулалт 12 -оос 50 мянган тонн зэс (түүнтэй дүйцэх хэмжээний) бол 0,5 -4,5 хувийн АМНАТ ногдуулдаг. Жилийн борлуулалт нь 50,000 тонноос давсан тохиолдолд 5 -14 хувийн өсөн нэмэгдэх АМНАТ ногдуулдаг. Эцсийн хувь хэмжээг ашигт ажиллагааны шалгуур буюу “уул уурхайн ашиглалтын марж” дээр үндэслэн тогтооно. Ашгийн

<sup>15</sup> Chilean Mining – Powering the Green Economy, a report by InvestChile, [www.investchile.gob.cl](http://www.investchile.gob.cl)

хэмжээ 35 ба түүнээс доош хувьтай бол 5 хувийн, 85 ба түүнээс дээш хувьтай бол дээд тал нь 14 хувийн АМНАТ ногдуулдаг.

Тиймээс ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ маш их ашигтай үйл ажиллагаа явуулахад нэлээд өндөр болж магадгүй ч энэ нь хөрөнгө оруулагчдыг саатуулахгүй байгаа бололтой.

## Хөрөнгө оруулалт

Бейкер Маккензи “Уул уурхайн салбарын сүүлийн үеийн өсөлтийг гадаадын хөрөнгийн өсөлттэй холбон үзэж болно. Чилийн засгийн газар гадаадын хөрөнгө оруулалтыг тууштай дэмжиж байгаа бөгөөд Чилид бизнес эрхлэх хүсэлтэй гадаадын компаниудад хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэхийн тулд олон хууль тогтоомжоо өөрчилсөн.” гэсэн байдаг.<sup>16</sup>

Тус улсын уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг тус бүр өөрийн өнцгөөс дэмжиж сурталчилдаг төрийн болон хувийн хэвшлийн хэд хэдэн байгууллага бий.

**InvestChile** бол Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих агентлаг юм. Энэ нь “гадаадын хөрөнгө оруулагчдын ашиг сонирхолыг Чили улсын зүгээс санал болгож буй бизнесийн боломжуудтай холбох гүүр болж Чили улсын эдийн засгийн хөгжлийн бодлоготой уялдах дэлхийн жишигт нийцсэн үйлчилгээ үзүүлдэг” төрийн байгууллага юм<sup>17</sup>. Тус агентлаг нь Чили улсын уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт хийх боломжуудийг идэвхтэй сурталчилж, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх тодорхой боломжуудын талаар мэдээллийг түгээдэг. Тухайлбал, тэдний “Ногоон эдийн засгийг эрчимжүүлэх нь” нийтлэлд зэс, металлын төсөл хэрэгжүүлэх боломжуудыг жагсаасан байна. Уг жагсаалтад хайгуулын шинэ 7 төсөл, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх 18 төсөл, ахисан шатны хайгуулын 3 төсөл, мөн одоо бүтээн байгуулалтын өмнөх шатанд байгаа 5 төсөл орсон байна.<sup>18</sup>

**Cochilco** агентлаг нь 1976 онд байгуулагдсан бөгөөд уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангах үүднээс уул уурхайн бодлого, хэрэгжилтийн талаар засгийн газарт зөвлөгөө өгдөг. Мөн тус мужийн томоохон уул уурхайн компани болох **Codelco**-д зөвлөгөө өгдөг. Жишээлбэл, **Cochilco** агентлаг нь өмнө нь тусгай зөвшөөрөл, лицензийг олгох үйл явцыг хурдан шуурхай болгох чиглэлээр Уул уурхайн сайдын албанд зөвлөгөө өгч байсан.

**Consejo Minero** нь бүх томоохон уул уурхайн компаниудыг төлөөлдөг хувийн хэвшлийн уул уурхайн холбоо бөгөөд гишүүдийн үйл ажиллагаа, эдийн засагт оруулж буй хувь нэмрийг олон нийтэд мэдээлэх, салбарын тогтвортой байдлыг дэмжих, бодлогын хэлэлцүүлэгт оролцох, салбарын чадавхийг бэхжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Гадаадын хөрөнгө оруулалтад ямар нэгэн хязгаарлалт тавигддаггүй ч Гадаадын хөрөнгө оруулалтын тухай шинэ хуулийн дагуу гадаадын хөрөнгө оруулагч нь тухайн хөрөнгө оруулалтыг хүлээн авч буй Чили улсын компанийн хувьцааны 10-аас доошгүй хувь буюу саналын эрхийн хяналтыг шууд болон

<sup>16</sup> Global Mining Guide - Chile, by Baker McKenzie : <https://resourcehub.bakermckenzie.com/en/resources/global-mining-guide/latin-america/chile/topics/global-mining-guide#:~:text=Chile%20has%20a%20civil%20law,concession%20rights%20from%20the%20state.>

<sup>17</sup> InvestChile : <https://investchile.gob.cl/aboutus/>

<sup>18</sup> Chilean Mining – Powering the Green Economy, a report by InvestChile, [www.investchile.gob.cl](http://www.investchile.gob.cl)

шууд бусаар хянадаг байх ёстой. 5 сая ам.доллараас давсан хөрөнгө оруулалтыг гадаадын шууд хөрөнгө оруулалт гэж үзнэ.<sup>19</sup>

## Сүүлийн үеийн үйл явдлууд

Чили улсад сүүлийн жилүүдэд ихээхэн нийгмийн эмх замбараагүй байдал үүсэх болсон ба үүний үр дүнд 2022 оны 7-р сарын 5-наас өмнө үндсэн хуулийн шинэчлэлийн төслийг өргөн барихаар ажиллаж байна. Үүнд Чиличүүд уулуурхайн салбараас гадаадын компаниудтай адил түвшинд үр өгөөж хүртэхгүй байна гэсэн олон нийтийн төсөөлөл голлон нөлөөлсөн.

Үндсэн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд зэс, лити, нүүрсустөрөгч зэрэг “стратегийн хөрөнгө”-ийн хайгуул, ашиглалтын зөвшөөрлийг зөвхөн дотоодын компаниудад олгох тухай заалт орсон. Энэхүү заалт нь Үндсэн хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаас хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно. Ингэхдээ ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг ямар нэгэн нөхөн олговоргүйгээр улсын мэдэлд шилжүүлэх бөгөөд компаниудын дансны үнэ цэнийн нөхөн төлбөрийг компанийн өнгөрсөн хугацаанд олсон "илүү орлого" орлогын дүнгээр бууруулна. Ийм нөхөн төлбөрийг тогтоосон хугацаанд буюу 30 хүртэлх жилийн хугацаанд төлнө. Түүнчлэн, шинэ үндсэн хуулийн дагуу Чили улсын нэгдэн орсон аливаа олон улсын гэрээ нь шинэ үндсэн хуультай зөрчилдөнө гэж үзсэн тохиолдолд гурван жилийн дотор тухайн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсвэл тухайн гэрээг цуцлахаар заасан. Эдгээр олон улсын гэрээ нь оруулсан хөрөнгө оруулалтын үнэ цэнийг хамгаалж, нөхөн олговор зохих ёсоор олгох нөхцлийг хангадаг тул тусгай зөвшөөрлийн нөхцлийг өөрчлөх, цуцлах ихээхэн боломжгүй байдаг.<sup>20</sup>

Ийм хууль эрх зүйн тодорхойгүй байдал нь салбарын хөрөнгө оруулалтад ойрын ирээдүйд маш их доройтуулах магдлалтай. Гэсэн хэдий ч Mining Journal 2021 оны Дэлхийн эрсдэлийн тайланд Чили улс Өмнөд Америкийн хэмжээнд эрсдэлийн үзүүлэлтээрээ хамгийн сайн жагссан хэвээр байгаа бөгөөд Хөрөнгө оруулалтын эрсдэлийн индекс (IRI) нь 75 байгаа нь Өмнөд Америк болон Африкийн бусад улс орнуудаас хамаагүй бага эрсдэлтэй, тэр ч байтугай Баруун Австрали, мөн Шведээс ч илүү (энэ хоёр улсын IRI нь 71) хөрөнгө оруулалт хийх боломжтой улс гэж тооцогддог.<sup>21</sup> (Монгол Улсын IRI нь Сенегал, Болгар, Кени, Нигер улсынхтай адил 55 байна.)

Дээр дурдсан InvestЧили болон Consejo Minero агентлаг нь улс төрийн өөрчлөлтөөс үүдэн тодорхой бус байдал үүсэж болзошгүйг хүлээн зөвшөөрч байгаа хэдий ч уул уурхайн салбарт хэт нөлөөлөхгүй гэдэгт итгэлтэй байна. Уул уурхайн сайд *“Чили улс хөрөнгө оруулалтын тогтвортой орчны олон жилийн түүхтэй, өнөөгийн нөхцөл байдал үүнийг үгүй болгохгүй. [...] ... Чили улс хөрөнгө оруулагчдыг хамгаалах, хувийн өмчийг хүндэтгэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хүний эрхийг дээдэлсэн маш тодорхой хуультай гэдгийг санах хэрэгтэй.”* гэж мэдэгдэл хийсэн.<sup>22</sup>

Үүнээс дараагаар "Уул уурхайн салбарын бухимдал" буюу шинэ үндсэн хуулийн мэтгэлцээн эхэлсэн талаар Ройтерс агентлаг мэдээлсэн. Чили улсын үндсэн хуулийн ассамблей нь 2 дугаар сарын дундуур албан ёсны хэлэлцүүлгийг эхлүүлсэн бөгөөд уг асуудлыг 20 чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, санал хураах юм. Шинэ Үндсэн хуулийн төсөл нь хөрөнгө оруулагчид болон уул уурхайн компаниудын дунд “түгшүүр төрүүлэв” гэсэн мэдээлэл байна. Шинэ үндсэн хуулийг батлахын тулд

<sup>19</sup> Global Mining Guide - Chile, by Baker McKenzie : <https://resourcehub.bakermckenzie.com/en/resources/global-mining-guide/latin-america/chile/topics/global-mining-guide#:~:text=Chile%20has%20a%20civil%20law.concession%20rights%20from%20the%20state>

<sup>20</sup> Lexology.com, <https://www.lexology.com/library/detail.aspx?g=7d4e75e0-ba26-42ce-a09c-7eeb8a0020bb>

<sup>21</sup> World Risk Report 2021, Mining Journal and MineHutte.

<sup>22</sup> Chile Mining 2020

нийт төлөөлөгчдийн гуравны хоёрын дэмжлэгийг авах шаардлагатай. Үүний дараа өөрчлөлт оруулах үйл явц, хоёр дахь эцсийн санал хураалт явагдана. Одоогоор үнэ үндсэн хуулийн санал хэр хэмжээний дэмжлэг авах нь тодорхойгүй хэвээр байгаа бөгөөд саяхан явуулсан нэгэн санал асуулгаар дэмжлэг буурч байна гэсэн үр дүн гарчээ. Гэхдээ, хэрэв санал дэмжигдээгүй тохиолдолд хуулийн төслийг комисс руу буцааж очиж, дахин хянуулах боломжтой.<sup>23</sup> Иймээс Чили улсын уул уурхайн салбарын тодорхой бус байдал дор хаяж хэдэн сар үргэлжлэх бололтой.

## Гол дүгнэлтүүд

- Чили улс нь ялангуяа зэсийн олборлолтоор дэлхийд тэргүүлэгч, литийн зах зээл хурдацтай өсч буй уул уурхай голлосон орнуудын нэг юм.
- Тусгай зөвшөөрөл олгох үйл явц нь шат дамжлага ихтэй, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь ашигт малтмалын үйл ажиллагааг ашигтай явуулахад хүндрэл учруулахуйц, одоогоор шинэ үндсэн хуулийн төсөл боловсруулж байгаатай холбоотойгоор тодорхой бус байдал үүссэн.
- Гэсэн хэдий ч уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт өндөр, цаашид ч өсөх хандлагатай байна.
- Хүчтэй, нэр хүндтэй төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд тодорхой бус байдлыг саармагжуулж байх шиг байна.
- Тогтвортой хөрөнгө оруулалтын орчин, хөрөнгө оруулагчдыг хамгаалах тогтолцоо нь Чили улсыг хөрөнгө оруулалт татахад нь тусалж байна.
- Уул уурхайн тусгай зөвшөөрлийг дотоодын компаниудад олгох, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй олон улсын гэрээнүүдийг эргэн харах зэрэг арга хэмжээг хамарсан шинэ үндсэн хуулийн төслийг хэлэлцэж байгаа явдал нь одоогийн хөрөнгө оруулагчдын санааг зовоож, шинээр орж ирэх хөрөнгө оруулалтыг саатуулах төлөвтэй байна.

## 7.3 Замби улс дахь уул уурхайн хөрөнгө оруулалт – бодлогын байнгын өөрчлөлтийн нөлөө

### Замби улсын уул уурхайн салбарын тойм

- Төв Африкийн энэ улс нь тивдээ хоёр дахь том зэс үйлдвэрлэгч (мөн дэлхийд наймдугаарт ордог) юм.
- Колоничлолын үед уул уурхайн салбар хувийн хэвшлийн өмчлөлд байж эхлээд 1964 оны тусгаар тогтнолын дараа ч ийнхүү үргэлжилсэн боловч 1969-1974 оны хооронд уурхайнуудыг улсын мэдэлд шилжүүлсэн. Зэсийн үнэ 1974-1975 онд унаж, хэдэн арван жилийн турш доогуур хэвээр байсан тул энэ нь харамсалтай цаг үе байлаа.<sup>24</sup>
- 1990-ээд онд уул уурхайн салбар дахин хувьчлагдсан.
- Замби улсын эдийн засаг уул уурхайгаас ихээхэн хамааралтай бөгөөд 2020 онд ДНБ-ий 11 гаруй хувь, экспортын 79,5 хувь (борлуулалтаар) болон улсын төсвийн орлогын 31,4 хувийг бүрдүүлсэн.<sup>25</sup>
- Бусад гол эрдэм бүтээгдэхүүнд алт, маргад, манганы хүдэр, хайлш, кобальт орно.
- Уул уурхайн салбарт Хятадын компаниудын хөрөнгө оруулалт их, тоо нь нэмэгдэж байна.

<sup>23</sup> Reuters, 15<sup>th</sup> February, 2022: <https://www.reuters.com/world/americas/chile-starts-debate-new-constitution-amid-jitters-over-mining-congress-plans-2022-02-15/>

<sup>24</sup> Family Silver -ийг эргүүлэн авсан нь: Замби улс зэсийн уурхайнуудаа дахин улсын мэдэлд авлаа, Африк судлалын төв Лейден, <https://www.ascleiden.nl/content/ascl-blogs/duncan-money/repurchasing-family-silver-zambia-nationalises-its-copper-mines>

<sup>25</sup> ZEITI 2020 Report - <https://zambiaeiti.org/wp-content/uploads/2022/01/2020-ZEITI-Report.pdf>

- Сүүлийн жилүүдэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, татварын горим олон удаа өөрчлөгдөж, мөн баялгийг өмчирхөх үндсэрхэг үзэл нэмэгдсэн нь тус салбарт хөрөнгө оруулалт хийхэд саад болж байна.

### **Ашигт малтмалын үйлдвэрлэл**

Цөөн хэдэн том уурхайгаас олборлодог зэсийн үйлдвэрлэл энэ салбарт давамгайлж байна. Зэсийн үйлдвэрлэлийн өнгөрсөн түүхээс харахад ихэвчлэн Төв Африкийн Зэсийн бүсийн Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улстай (БНАКУ) хиллэдэг Замбийн нутаг дэвсгэрээс олборлодог байсан. Энэ нь Африк тив дэх хамгийн том зэсийн ордын бүс нутаг юм. Сүүлийн үед Замби улсын баруун хойд хэсэгт орших заримдаа “шинэ Зэсийн бүс” гэж нэрлэдэг хэд хэдэн маш том ил уурхайгаас илүү их зэс үйлдвэрлэж байна.

2020 онд зэсийн үйлдвэрлэл 837,000 гаруй тонн буюу бараг 5.2 тэрбум ам.долларт хүрсэн. Энэ онд 3,672 кг алт үйлдвэрлэсэн бөгөөд үүний дийлэнхийг алт нь гол дагалдах бүтээгдэхүүн болох зэсийн томоохон нэг уурхай (Кансанши)-гаас олборлосон. Алтны үйлдвэрлэл 208 сая ам.доллар байв. Түүнчлэн 316 тонн кобальт, 28,409 тонн манганы хүдэр, 9,783,43 кг маргад, берилл үйлдвэрлэсэн. Замби улс мөн тухайн жилд цемент (2,796,896 тонн), нүүрс (448,821 тонн) үйлдвэрлэсэн.<sup>26</sup>

### **Нөөц ашигласны төлбөр ба татварын горим**

Сүүлийн 10 жилийн хугацаанд Замби улсын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн татварын горим хэд хэдэн удаа өөрчлөгдсөн. СМН-ийн 2016 оны тайланд *"Замбичууд, хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн байгууллагуудын дунд гадны уул уурхайн компаниуд Замбичуудын баялгийг нь булааж, засгийн газар баялгаас хүртэх ашигаа хангалттай хүртэж чадахгүй байна гэсэн хүчтэй төсөөлөл бий"* гэж бичжээ.<sup>27</sup> 2014 онд Засгийн газар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг нэмэгдүүлж, уул уурхайн компаниудыг орлогын албан татвараас түр хугацаагаар чөлөөлсөн. Ил уурхайн олборлолт зардал багатай, далд уурхайгаас илүү ашигтай гэсэн үндэслэлээр ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг бүр 20% хүртэл өсгөсөн. Салбарынхны зүгээс шуугиан дэгдэж, эрдсийн агууламж харьцангуй багатай хүдрийн биеттэй Лумвана зэсийн ил уурхайн эзэн Канадын Баррик Гоулд Корпораци үйл ажиллагаагаа зогсооно гэж мэдэгдэв. 2015 оны долдугаар сарын 1-нээс ил уурхайн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 20 хувиас 9 хувь, далд уурхайн АМНАТ-ыг 8 хувиас 6 хувь болгон бууруулж, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 30 хувиар дахин ногдуулж эхэлсэн. Лумвана үйл ажиллагаагаа үргэлжлүүлэв.

2018 оны сүүлээр Засгийн газар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг зэсийн үнээс хамаарч 5,5%-10% хооронд хэлбэлзэхээр дахин нэмэгдүүлсэн. Түүнчлэн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг уурхай ашигтай ажилласан эсэхээс үл хамааран олборлосон металл, ашигт малтмалын үнэлгээн дээр үндэслэн тооцдог хэдий ч татвараас хасч тооцох боломжгүй болсон. Энэ нь үйлдвэрлэлийн тодорхой дамжлагад давхар татвар ногдуулахад хүргэсэн. Үүний зэрэгцээ Засгийн газар уул уурхайн компаниудад төлсөн Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтыг төлөх боломжгүй болсон. Хөрш зэргэлдээ БНАКУ-аас орж ирэх (Замбид хайлуулахаар) зэс-кобальтын баяжмалд 5 хувийн импортын татвар ногдуулж, үнэт металл, эрдэнийн чулуунд 15 хувийн экспортын татвар ногдуулж эхэлсэн.

<sup>26</sup> ZEITI 2020 Тайлан - <https://zambiaeiti.org/wp-content/uploads/2022/01/2020-ZEITI-Report.pdf>

<sup>27</sup> Замби дахь уул уурхайн нөөц ашигласны төлбөрийн горимын өсөлт ба уналт, СМН-ийн мэдээ, <https://www.cmi.no/publications/file/5730-the-rise-and-fall-of-the-mining-royaltyregime-in-pdf>



Замби улс эдгээр янз бүрийн арга хэмжээг дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн уналтаас үүдсэн орлогын алдагдлаа нөхөхийн тулд хэрэгжүүлсэн гэж тоймчид тайлбарлав. Гэвч энэ нь Замби улсын тухайн үеийн засгийн газар нь уул уурхайн эдгээр компаниуд Замби улсыг "хууран мэхэлж байна" гэсэн олон нийтийн төсөөллийн үндсэн дээр гадаадын оператор компаниудыг хүчтэй онилж байсныг харуулж байна.<sup>28</sup>

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн горимд гарсан эдгээр өөрчлөлт нь Кансанши уурхайн 1 тэрбум ам.долларын өргөтгөл болон уурхайн ашиглалтын хугацааг уртасгах төсөл, Любамбе уурхайн 1 тэрбум ам.долларын өргөтгөл, болон NFCA Чамбишигийн зүүн өмнөд хүдрийн биет дэх гүний уурхайн тоног төхөөрөмжийн флотын өргөтгөл зэрэг хэд хэдэн томоохон өргөтгөлийн төслийг түр зогсоосон. Эдгээр гурван оператор компани бүгд "... хөрөнгө оруулалтын боломжит өгөөжийг бүхэлд нь үгүй болгодог нөөц ашигласны төлбөрийг хасагдуулах боломжгүй явдал нь төслийг батлахад гол саад болж байна" гэж тэмдэглэсэн.<sup>29</sup> Энэ үед Кансанши компанийн дийлэнх хувийг эзэмшигч First Quantum 10 жилийн хугацаанд аль хэдийн 3,6 тэрбум ам.долларын татвар төлж, улсын хамгийн том татвар төлөгч болсон байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Одоо үйлчилж буй АМНАТ ба татварын горим

2020 оны 1-р сарын 1-ний байдлаарх уул уурхайн салбарын татварын горимын мэдээлэлийг тусгасан ZEITI-аас гаргасан 2020 оны тайлангийн 42, 43-р хуудсанд дараах мэдээлэл орсон<sup>30</sup>. Үүнд:

---

<sup>28</sup> Замбийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн нэмэгдэл, HIS Markit, <https://ihsmarkit.com/research-analysis/zambian-mineral-royaltiesincrease.html#:~:text=Zambia's%20royalty%20increases%20were%20first,4%25%20to%206%25%20previously.>

<sup>29</sup> No 'green light' for mining investment in the 2021 Budget, laments the Zambia Chamber of Mines, ZCM, <http://mines.org.zm/no-green-light-for-mininginvestment-in-the-2021-budget-zcm/>

<sup>30</sup> ZEITI 2020 Report - <https://zambiaeiti.org/wp-content/uploads/2022/01/2020-ZEITI-Report.pdf>

Table 30: Zambia's current mineral fiscal regime - effective 1 January 2020

<b>Royalty rate</b>	
Base Metals	5% NORM <sup>14</sup>
<b>Copper (*)</b>	<b>5.5% - 10% NORM</b>
Cobalt and Vanadium	8%
<b>Precious Metals</b>	<b>6% NORM</b>
Gemstones	6% GROSS <sup>15</sup>
<b>Energy Minerals</b>	<b>5% GROSS</b>
Industrial Minerals	5% GROSS
<b>Tax deductible</b>	<b>No</b>
<b>Corporate Income Tax</b>	
Tax on income from mineral processing	35%
<b>Company tax rate on income from Mining Operations</b>	<b>30%</b>

## (\*) Copper Royalty Rate parameters

Copper	Base	2020
below US\$4,500	norm value	5.5%
between US\$4,500 and 5,999	norm value	6.5%
between US\$6,000 and 7,499	norm value	7.5%
between US\$7,500 and 8,999	norm value	8.5%
Above US\$9,000	norm value	10%

<sup>14</sup> Norm Value - this is the quantity of the metal sold multiplied by the monthly average cash price per metric tonne of the metal as published by London Metal Exchange (LME) or London Metal Bulletin (LMB) or any exchange approved by Commissioner General where the metal is not published by LME and LMB.

<sup>15</sup> Gross Value - this is the realised price free on board at the point of delivery within Zambia or at point of export from Zambia.

Өөр өөр металл, эрдэс бүтээгдэхүүнд өөр өөр хувь хэмжээгээр АМНАТ ногдуулдаг боловч дотоодын болон гадаадын компанид ижил хувь хэмжээгээр ногдуулдагийг анхаарах нь зүйтэй. Энэ оны (2022) эхний байдлаар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн татварын хөнгөлөлтийг дахин нэвтрүүлсэн.

Анхаарвал зохих хоёр асуудал:

- Зэсийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ нь зэсийн үнийг дагаад нэмэгддэг тул зэсийн үнэ өндөр байх тусам АМНАТ-ын хувь хэмжээ өндөр байна.
- Зэс, бусад үндсэн металл, үнэт металл зэрэг металлын хувьд нөөц ашигласны төлбөрийг зах зээлийн үнэлгээ буюу зарлагдсан жишиг үнэд үндэслэн ногдуулдаг бол үнэт чулуу, эрчим хүч, аж үйлдвэрийн ашигт малтмал гэх мэт бусад бүтээгдэхүүнд Замби улсын хил дээрх FOB нөхцөлтэй үнэд ногдуулдаг. Эдгээр сүүлийн бүтээгдэхүүнүүдийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн жишиг үнэ байдаггүй.

## Хувьчлал

1970, 1990-ээд онуудад өрнөсөн хөрөнгийг улсын мэдэлд шилжүүлэх, хувьчлалын нарийн төвөгтэй үйл явцаас хойш хувийн хэвшил, тэр дундаа гадаадын компаниуд уур уурхайгаас хэт их ашиг

хүртэж, Замбичуудын хүртэх ёстой өгөөжийг бууруулж байна гэж үздэг нийгмийн салбарууд байсаар байна. Зэсийн бүх олборлолтыг төрийн өмчит Замби Consolidated Copper Mines хийж байсан "хуучин сайхан цаг"-ын талаар одоо ч ярьдаг. Тухайн үед Замби улс нь ZCCM-ийг бэлэн мөнгөний үнээ болгон ашиглаж, үйлдвэрлэлийн ашигт ажиллагаанаас илүү ажилчдын тэтгэмж, хангамжийг чухалчилж ажилладаг байсан. Энэ нь үндсэндээ “өлгийнөөс булш хүртэлх халамжийн тогтолцоо” байсан.<sup>31</sup> Зарим талаараа металлын үнэ бага байсантай холбоотойгоор ашиг нь хэтэрхий бага байсан тул шаардлагатай үед шинэчлэл хийж, дахин хөрөнгө оруулалт хийх боломжгүй байв.

Уул уурхайн салбарт хувьчлал хийх зайлшгүй шаардлагатай байсан бөгөөд Дэлхийн банк үүнийг маш амжилттай гэж үзсэн ч Зэсийн бүс болон Замби улсын олон оршин суугчид уурхайн хөрөнгийг хоосолсон, авлигын асуудалтай зарим гэрээг дурдан үүнтэй санал нийлдэггүй.

Сүүлийн жилүүдэд Замби улсын засгийн газар хоёр уул уурхайн компанийг улсад шилжүүлсэн. Үүнд: 2021 оны 1-р сард тэрээр Glencore болон First Quantum-аас Mopani Copper Mine (MCM) компанийг нэг доллар дээр тус компанийн өрийг (1,5 тэрбум ам.доллар) нэмсэн дүнгээр худалдаж авсан.<sup>32</sup> 2019 онд Энэтхэгийн Веданта дийлэнх хувийг нь эзэмшдэг Конкола Коппер Майнз (КСМ)-ийг татан буулгах ажиллагааг эхлүүлсэн. Гэхдээ тухайн үед засгийн газар үүнийг улс руу шилжүүлэх гэхээс илүү татварын маргаан, КСМ-ийн нэг нэгжийн үйлдвэрлэл буурсантай холбон тайлбарлаж байв. КСМ-ийг татан буулгалттай холбоотойгоор Ведантагийн зүгээс гаргасан нэхэмжлэл нь олон улсын арбитрын журмаар одоо болтол хэлэлцэгдэж байна.<sup>33</sup>

### Сүүлийн үед өрнөсөн үйл явдал

2021 оны 8-р сард шинэ засгийн газар сонгогдсоны дараа ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн таагүй горимыг зөөлрүүлэх нөхцөл байдал гарч ирсэн бөгөөд Замби улсын Уул уурхайн танхим (ZCM) энэ нь 2,5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг авчрах боломжтой гэж мэдээлэв. ZCM-ийн ерөнхийлөгч нь “Энэхүү нийтлэг зорилгын төлөө хамтдаа урагшлах нь засгийн газартай урьд өмнө хэзээ ч харж байгаагүй түншлэл болно гэдэгт салбарынхан маш их итгэж найдаж байна” гэж тэмдэглэв.<sup>34</sup>

ZCM дараагийн хэвлэл мэдээллийн нийтлэлд “Сүүлийн зуун жилд хэзээ ч уул уурхайн төслүүдийг бэлтгэх, улмаар хайгуул, бүтээн байгуулалт, ашиглалтын болон төлөвшсөн төслүүдийн хамгийн их ашиг авчрах тэнцвэртэй багцыг бүрдүүлэх, хамгийн чухал нь уул уурхайн төслүүдэд Замбичуудыг оролцуулах ийм боломж бүхий сайн цаг ирж байсангүй.”, “Энэхүү төслүүдийн өргөтгөл, хайгуулд суурилсан өсөлтийг өдөөхийн тулд хөрөнгийн өртгийг боломжийн түвшинд байлгах, дэлхийн зах зээл, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын итгэлийг бий болгох уул уурхайн тогтвортой бодлого, татварын горимыг богино хугацаанд нэвтрүүлэх шаардлагатай.” гэжээ.<sup>35</sup>

2021 оны 11 дүгээр сард Fitch Ratings-ийн хамааралтай компани болох АНУ-д төвтэй Fitch Solutions зөвлөх компани нь татварын бодлогын өөрчлөлтүүд нь одоо байгаа уурхайнуудын хөрөнгө оруулалт болон шинэ төслүүдэд хөрөнгө оруулагчдын сонирхлыг сэргээнэ гэж үзэж байгаа талаар

<sup>31</sup> Repurchasing the Family Silver: Zambia nationalizes its copper mines again, African Studies Centre Leiden, <https://www.ascleiden.nl/content/asclblogs/duncan-money/repurchasing-family-silver-zambia-nationalises-its-copper-mines>

<sup>32</sup> Glencore agrees \$1.5bn sale of Mopani to Zambian Government, Mining Technology, <https://www.mining-technology.com/news/deal-news/glencore-zambiamopani-sale/>

<sup>33</sup> Zambia turns up the nationalist heat on its copper miners, Andy Home, Reuters, <https://www.reuters.com/article/us-zambia-copper-ahome-idUSKCN1SZ1QE>

<sup>34</sup> FQM, Lubambe Mines now pledge to invest over \$2.5bn, Zambian Business Times, <https://zambianbusinesstimes.com/fqm-lubambe-mines-now-pledge-to-invest-over-2-5b/>

<sup>35</sup> ZCM elated by the high profiling of the Mining industry, ZCM, <http://mines.org.zm/zcm-elated-by-the-high-profiling-of-the-mining-industry/>

тэмдэглэжээ. Гэсэн хэдий ч тэрээр "... Замби улсад бодлого зохицуулалтын эрсдэл, цаашид баримтлах бодлогын тодорхой тус байдал өндөр хэвээр байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд хууль эрх зүйн зохицуулалтын олон өөрчлөлт гарсан бөгөөд металлын үнийн өсөлт нь цаашид байгалийн баялгийг өмчирхөх үндсэрхэг үзлийг нэмэгдүүлж болзошгүй юм." гэж анхааруулж байна.<sup>36</sup>

2022 оны төсвийн танилцуулгыг хийхдээ ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг дахин бизнесийн зардал гэж үзэж, албан татвар ногдох орлогоос хасч тооцож эхлэх талаар зарласан. ZCM-ийн ерөнхийлөгч үүнийг хөрөнгө оруулагчдад "ногоон гэрэл" асаах чухал алхам гэж үзэж байгаа ч хангалттай гэж үзэхгүй байна. Татварын үр дүн ашигтай хувь хэмжээг нөхөх харьцангуй давуу тал байхгүй тул сүүлийн арван жилд томоохон хөрөнгө оруулалт хийгдээгүй гэж тэрээр тэмдэглэв. Любамбе, Кансанши уурхайнуудад шинэ хөрөнгө оруулалтыг татах, мөн хөрөнгө оруулагчдын хайгуул хийх сонирхолыг бий болгохын тулд нөөц ашигласны төлбөрийн бүтцийг (зөвхөн хувь хэмжээг нь биш) эргэн харах шаардлагатай гэж үзэж байгаагаа илэрхийлсэн.<sup>37</sup>

## Гол дүгнэлтүүд

- Замби бол Африк тивд төдийгүй дэлхийн хэмжээнд зэсийн үйлдвэрлэлээрээ тэргүүлэгч орон юм.
- First Quantum Minerals (FQM), Barrick Gold зэрэг олон улсын томоохон уул уурхайн компаниуд Замбид ажиллаж байна. FQM нь саяхан Калумбилагийн баруун хойд хэсэгт шинэ уурхай нээсэн.
- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, татварын горимын томоохон өөрчлөлтийг гэнэт, салбарын саналыг харгалзахгүйгээр оруулсан явдал нь үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтад гэнэтийн огцом нөлөө үзүүлсэн.
- Одоогийн мөрдөж буй ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн горимын дагуу өөр өөр металл, ашигт малтмалд өөр өөр хувь хэмжээгээр гадаад, дотоодын компани гэж ялгахгүйгээр нөөц ашигласны төлбөр ногдуулдаг бөгөөд зэсийн хувьд үнэлгээг дагаад өссөн хувт нэмжээгээр төлбөр ногдуулдаг. АМНАТ-ыг албан татвар ногдох орлогоос дахин хасч тооцох болсон. Бизнес ээлтэй шинэ Засгийн газар сонгогдсоноор хөрөнгө оруулалтын орчны талаар олон эерэг мэдээлэл гарсан ч салбарынхан зөвхөн үг сонсох биш бодит өөрчлөлтийг харах хэрэгтэй гэсэн болгоомжлолтой хэвээр байна.
- Уул уурхайн салбарт сөргөөр нөлөөлсөн бодлогын шийдвэрүүд хөрөнгө оруулалтын орчинд шууд огцом нөлөөлсөн бол салбарт эерэг өөрчлөлтийн нөлөөлөл харьцангуй удаан хугацаанд мэдрэгддэг.
- Ялангуяа Хятад улсад төлөх их хэмжээний өртэй Замби улсад Хятадын аж ахуйн нэгжүүд улам олон хөрөнгө оруулалт хийж байгаа нь анхаарал татах асуудал болоод байна.

## 7.4 Авсан сургамж

Урьдчилан таамаглах боломж буюу тодорхой бус байдлын хүчин зүйл нь аливаа улсын ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулалт хийх боломжийг тодорхойлох хамгийн чухал хүчин зүйл

<sup>36</sup> Tax Breaks to Stimulate Mining Sector in Zambia, Fitch Solutions, [https://www.fitchsolutions.com/mining/tax-breaks-stimulate-mining-sector-zambia-05-112021?fsWebArticleValidation=true&mkt\\_tok=NzMyLUNLSC03NjcAAAGCOiBRiGV0h74IM6nDgVCiTMYNooonvUTY-LJlc9QeV76tABKiQQZef\\_kB4GWJZ\\_qgO4snCq9uYMuCwYFAMLggKWA1-8\\_kUreWv0CEuQTdGwf6ERF0Ag](https://www.fitchsolutions.com/mining/tax-breaks-stimulate-mining-sector-zambia-05-112021?fsWebArticleValidation=true&mkt_tok=NzMyLUNLSC03NjcAAAGCOiBRiGV0h74IM6nDgVCiTMYNooonvUTY-LJlc9QeV76tABKiQQZef_kB4GWJZ_qgO4snCq9uYMuCwYFAMLggKWA1-8_kUreWv0CEuQTdGwf6ERF0Ag)

<sup>37</sup> Zambia Chamber of Mines President lays out mining's biggest challenges, 1<sup>st</sup> February, 2022: <https://miningforzambia.com/zambia-chamber-mines-president-lays-minings-biggest-challenges/>

болохыг гурван кейсийн судалгаа тодорхой харуулж байна. Хайгуулын дараа үргэлжлэх ашиглалтын үйл ажиллагааны хугацаа маш урт байдаг. Үүн дээр их хэмжээний мөнгөн хөрөнгийг эрсдэлд оруулах, геологийн болон үйл ажиллагааны хүчин зүйлээс шалтгаалсан техникийн эрсдэл, ашигт малтмалын үнийн өөрчлөлтөөс шалтгаалсан санхүүгийн эрсдэлийг нэмээд үзвэл үндэстэн дамнасан уул уурхайн хөрөнгө оруулагчид төслийн ашиглалтын хугацаанд хуулт эрх зүйн зохицуулалтын болон татварын орчин нь байнга өөрчлөгдөх улсад хөрөнгө оруулалт хийхээс зайлсхийдэг нь ойлгомжтой.

Компаниуд тухайн үеийн болон ирэх он жилүүдэд хүлээгдэж буй параметрууд дээр үндэслэн хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргах боломжтой. Компаниуд төслийг хэрэгжүүлж эхлэхээс өмнө эдийн засгийн тооцоололдоо харьцангуй өндөр татварыг оруулан загварлах боломжтой тул тэд нөөц ашигласны төлбөр болон татварын өндөр хувь хэмжээг тэсвэрлэх боломжтой. Харин төсөл эхэлсэний дараа эдийн засгийн болон татварын тооцооллын загварт өөрчлөлт оруулахад хүндрэлтэй (заримдаа боломжгүй) болдог.

Олон улсын томоохон уул уурхайн компаниуд дээр авч үзсэн гурван орныг оролцуулаад аль ч улс оронд хайгуул хийх, ашигт малтмалын олборлолт хийх боломжтой. Нэг улсад бодлого, институцийн эрсдэл хэт өндөр болчихвол нөгөөд нь хөрөнгө оруулалт хийнэ гэсэн үг юм.

## 8. ГШХО-ЫН ХАРЬЦУУЛАЛТ

Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчныг харьцуулах боломжтой орнуудынхтай харьцуулахдаа уул уурхайн салбарын гадаадын шууд хөрөнгө оруулалтын (ГШХО) статистик мэдээллийг харьцуулж авч үзэх нь зүйтэй. Энэ хэсэгт бид уг судалгааны хүрээнд авч үзсэн дөрвөн улсын хөрөнгө оруулалт, мөн цаг хугацааны чиг хандлагыг харьцуулж үзнэ.

Бид энд хоёр үзүүлэлтийг авч үзсэн. Үүнд:

- *ГШХО-ын нөөц*, тухайн улсад оршин суугч аж ахуйн нэгжүүд дэх гадаадын хөрөнгө оруулагчдын өөрийн хөрөнгийн (болон тэдгээрт олгосон цэвэр зээлийн) үнэ цэнийг хэмждэг.<sup>38</sup>
- *ГШХО-ын урсгал*, тухайн улсад оршин суугч аж ахуйн нэгжүүд дэх гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ажил гүйлгээний үнэ цэнийг хэмждэг.<sup>39</sup>

Дараах Зураг 8.1 нь "уул уурхай, олборлох" салбар дахь 2010 оноос хойш мэдээлэл нь байгаа он хүртэлх хугацааны ГШХО-ын нөөцийг харуулж байна. Баруун Австралийн тоо мэдээг авч чадаагүй тул бид нийт Австралийн тоо мэдээг оруулсан гэдгийг анхаарна уу. Түүнчлэн Замби улсын хувьд зөвхөн 2017 он хүртэлх статистик тоо мэдээг, харин Монгол улсын хувьд 2018 он хүртэлх тоо мэдээг авах боломжтой байсан.

---


<sup>38</sup> FDI Stocks, in: OECD Data,

<https://data.oecd.org/fdi/fdistocks.htm#:~:text=The%20inward%20FDI%20stock%20is, long%20lasting%20links%20between%20economies>.

<sup>39</sup> FDI Flows, in: OECD Data,

<https://data.oecd.org/fdi/fdiflows.htm#:~:text=Inward%20flows%20represent%20transactions%20that, as%20a%20share%20of%20GDP>.


**Зураг 8.1: Уул уурхайн салбарын ГШХО-ын нөөц (Эх сурвалж: Investmentmap.org)**



Австрали болон Чили дэх уул уурхайн салбарын ГШХО-ын нөөц нь Замби, Монголынхоос хол давсан нь тодорхой байна. Түүнчлэн эдгээр жилүүдээс Австрали, Чилийн ГШХО-ын нөөцийн өсөлттэй байсан жилүүдэд Замби болон Монгол дахь ГШХО-ын нөөцийн хэмжээ нь нэлээд тогтвортой байсан нь харьцангуй бага өсөлттэй байсныг харуулж байна.

Зураг 8.2-т авч эдгээр улс орнууд руу орж буй уул уурхайн салбарын ГШХО-ын жилийн урсгалыг харуулав. Монгол, Замбиас гадагш чиглэсэн урсгал байхгүй тул бид энэ график дээр зөвхөн орж ирэх урсгалыг харуулсан болохыг анхаарна уу. Энэ нь Замби болон Монголын компаниуд дэлхийн бусад улс оронд хөрөнгө оруулалт хийсэн талаарх мэдээлэл байхгүй гэсэн үг юм.

**Зураг 8.2: Уул уурхайн салбарын ГШХО-ын дотогшоо чиглэсэн урсгал (Эх сурвалж: Investmentmap.org)**



2015-2018 онуудад хөрөнгө оруулалтын урсгал буурсан нь металл, эрдэс бүтээгдэхүүний үнийн мөчлөгтэй холбоотой байв. Үнийн өсөлт болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргасан хугацааны хоорондох зөрүүгийн улмаас Австрали, Чили рүү орж ирэх ГШХО-ын шинэ урсгал хэдэн жилээр хойшлоход хүрсэн нь 2019 оны үзүүлэлтээс харагдаж байна. 2017 оноос хойш Замби улсын талаарх мэдээлэл байхгүй байгааг анхаарна уу.

#### Хэлэлцүүлэг

Аливаа улс хөрөнгө оруулагчдад ээлтэй шийдвэр гаргаж, хэрэгжүүлж эхлэнгүүт хөрөнгө оруулалтын урсгал хурдан нэмэгдэнэ гэж бодох нь учир дутагдалтай. Үүнийг батлах хоёр үндсэн шалтгаан бий:

- Металл, эрдэс бүтээгдэхүүний зах зээлийн мөчлөг нь ялангуяа ойрын болон дунд хугацаанд зарим улс орны хувьд уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтад бодлогоос илүү их нөлөө үзүүлдэг. Түүнчлэн, уналтын дараа үнэ сэргэх, хөрөнгө оруулалт нэмэгдэх хоёрын хооронд үргэлж хугацааны зөрүү байдаг.
- Хоёрдугаарт, уул уурхайн хөрөнгө оруулалт маш том, урт хугацаатай учраас хөрөнгө оруулагчид шийдвэр гаргахдаа маш болгоомжтой ханддаг. Иймд тэд бодлогын сайн шийдвэр гарсан тухай мэдээг дуулмагц хөдлөхгүй, харин бодлого нь бодитоор хэрэгжиж байгаа эсэхийг мэдэхийн тулд хэсэг хугацаанд "хүлээж, харахыг" илүүд үздэг. Харин эсрэгээс, засгийн газар ямар нэгэн таагүй шийдвэр гаргамагц уул уурхайн компаниудад маш хурдан хариу үйлдэл үзүүлэх хандлагатай байдаг. Уул уурхайн компаниудын хувьд шинэ хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргахаас хөрөнгө оруулалтын шийдвэрийг түдгэлзүүлэх эсвэл цуцлах нь илүү хялбар (мөн бага эрсдэл дагуулдаг) байдаг.

Иймд уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд төрөөс баримтлах бодлогын үр дүнтэй байдлыг тодорхойлох зорилгоор улс орнуудын ГШХО-ын статистик мэдээллийг ашиглахдаа болгоомжтой хандах хэрэгтэй. Харин бусад уул уурхайн давамгайлсан эдийн засагтай улс орнуудын



бодлоготой харьцуулагдах "шилдэг туршлага"-ын бодлогыг баримталж, ийм бодлогын тогтвортой байдлыг урт хугацааны турш хангаж нэмэгдүүлэх тал дээр анхаарах нь зүйтэй.

# 9. АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дээр тусгасан бүхий л судалгаа, шинжилгээний үр дүнг харгалзсаны үндсэн дээр Монгол Улсын Засгийн газарт уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад туслах зорилгоор дараах Мөрийн хөтөлбөрийг санал болгож байна. Энэхүү Мөрийн хөтөлбөрийн эхний хэсэгт шийдвэрлэх асуудлуудыг логик дарааллын дагуу тодорхойлж, ангилсан болно. Дараа нь "Ижил бүлэг"-ийн орнуудын туршлагад үндэслэн Монгол Улсын Засгийн газрын зүгээс авч хэрэгжүүлвэл зохих арга хэмжээг танилцуулах болно.

## 8.1 Зорилго

Энэхүү Мөрийн хөтөлбөр нь Монгол Улсын уул уурхайн хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах үндсэн зорилготой. Энэ зорилго нь нэг талдаа хайгуул, олборлолтын төсөлд гадаадын компаниудын хөрөнгө оруулалтыг татах хүсэл эрмэлзэл, уул уурхайн салбарын ГШХО-ыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагыг нэгэн зэрэг агуулсан болно.

Монгол Улс байгалийн баялаг ихтэй бөгөөд янз бүрийн судалгаагаар (Фрейзер болон УУСОТС хоёулаа) нь Монголын улсын эрдэс баялаг нь бодлого, зохицуулалтын орчин таатай бол уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт хийх боломжтойг илтгэсэн хүчин зүйл болох нь батлагдсан.

## 8.2 Зорилтууд

Иймд Монгол улсын уул уурхайн салбарын ГШХО-ыг нэмэгдүүлэхийн тулд хэд хэдэн тодорхой зорилтуудыг хэрэгжүүлэх шаардлагатай байгаа нь илт байна. Үүнд:

- Хайгуулын тусгай зөвшөөрөл авах хүсэлт, олгосон зөвшөөрлийн тоог нэмэгдүүлэх;
- Дараах зорилтуудыг хэрэгжүүлэх замаар хайгуулын үйл ажиллагаанд зарцуулах зардлыг нэмэгдүүлэх
- Өрөмдлөгийн гүн, дээж авах гэх мэтийн тоог нэмэгдүүлэх;
- Уул уурхайн салбарын хөрөнгө оруулагчид болон бусад оролцогч талуудтай холбоотой шүүхийн маргааны тоог цөөрүүлэх;
- Бусад улс орнуудын гормтой нийцсэн нөөц ашигласны төлбөрийн зохицуулалтыг бүрдүүлэх; түүнчлэн
- Оролцогч байгууллагуудын (Төрийн байгууллагууд, ТББ гэх мэт) институцийн чадавхийг сайжруулах.

## 8.3 УУСОТС, Зөрүүгийн шинжилгээ, СВОТ-ын шилжилгээгээр илэрсэн асуудлууд

УУСОТС Зөрүүгийн шинжилгээ, СВОТ-ын шилжилгээгээр илэрсэн асуудлуудыг гол асуудлын бүлгүүдэд хамааруулан ангилсан болно. Бүлэг асуудлуудыг нэгтгэж асуудал тус бүрт шийдэл болохуйц авч хэрэгжүүлэх арга хэмжээг цогц байдлаар тодорхойлсон болно.

### 8.3.1 Уул уурхайн зохицуулалтын горим

Оролцогч талуудын анхаарлыг татсан шийдвэрлэвэл зохих асуудлуудын ихэнх нь энэ ангилалд багтдаг. Үүнд тусгай зөвшөөрөл, лиценз авахтай холбоотой асуудал, Засгийн газар ойр ойрхон солигдохоос үүдэлтэй байнгын өөрчлөлт, хууль тогтоомжийн хэрэгжүүлэлттэй холбоотой хэт олон тайлбар зэрэг асуудлууд багтана.

Чили улсын уул уурхайн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд нарийн төвөгтэй боловч маш тодорхой гэж үздэг. Энэхүү тодорхой байдал нь уул уурхайн салбарын итгэлийг бий болгосноор тус улс үндсэн хуулиа өөрчлөх хэлэлцүүлэг хийж байгаа энэ үед ч компаниуд эерэг хандлагатай хэвээр байна. Үндсэн хуулийн өөрчлөлтөд тухайлбал хөрөнгө оруулагчдад маш их саад учруулах уул уурхайн компаниудыг (хөрөнгийн нөхөн төлбөрийг ихдүүлэхгүйгээр) улсын мэдэлд авах тухай заалт орж байгаа болно. Гэсэн хэдий ч өнгөрсөн хугацаанд хууль эрх зүйн орчин нь тогтвортой байсан явдал нь компаниудад эерэг үр дүнд хүрэх итгэлийг өгчээ.

Австрали улсад тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчин, аборигенчуудын өвийг хамгаалах талаар хүлээх үүргийг нэмэгдүүлснээс өөр тусгай зөвшөөрөл олгох тогтолцоонд дорвитой өөрлөлт ороогүй. Австралид хайгуулын тусгай зөвшөөрлийг "Түрүүлж ирсэнд түрүүлж үйлчлэх" (FCFS) зарчмын дагуу буюу хууль тогтоожид тодорхой заасан үйл явцын дагуу хүсэлтийг ирүүлсэн дараааллаар нь шийдвэрлэж тусгай зөвшөөрөл олгодог. Энэ нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүссэн эхний өргөдөл гаргагчид зөвшөөрлийг шууд олгоно гэсэн үг биш бөгөөд эхний хүсэлт гаргагчийн хүсэлтийг түрүүлж хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэнэ гэдгийг анхаарна уу. <sup>40</sup>

<b>УУЛ УУРХАЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ГОРИМ – САНАЛ БОЛГОЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ</b>				
№	Асуудал	Ойрын хугацааны(1-2 жил)	Дунд хугацааны (3-5 жил)	Урт хугацааны (5 - аас дээш жил)

<sup>40</sup> Хайгуулын лиценз, хууль тогтоомж, үйл явцын талаарх тайлан – Баруун Австрали ба Квинсланд, Австрали-Монголын уул уурхайн хамтын ажиллагааны хөтөлбөр (АМЕР), 2021.

1	<p>Хайгуулын тусгай зөвшөөрөл авахад хүндрэлтэй байдал, энэ нь зарим талаараа тусгай зөвшөөрлийг авлигад өртөх магадлал өндөртэй тендерийн журмаар олгодогтой холбоотой юм.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Ногоон талбайн хайгуулын тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг түрүүлж ирсэнд түрүүлж үйлчлэх зарчмаар хянан шийдвэрлэх.</li> <li>• Үнэ цэнэ бүхий хөрөнгийн тендерийн үйл явцыг илүү ил тод, тодорхой болгох.</li> <li>• Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгогдсон талбайн цаг үеийн кадастрын зургийг нийтлэх (онлайнаар).</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Компани нь хууль тогтоомжийг дагаж мөрдөж байгаа эсэхийг тогтоохын тулд хайгуулын тусгай зөвшөөрлийн гүйцэтгэлд хяналт тавих</li> <li>• Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайн кадастрын зургийг тогтмол шинэчлэх, Шинээр олгогдсон тусгай зөвшөөрлийн талбайг нэмж, хүчингүй болсон болон хугацаа нь дуусгавар болсон тусгай зөвшөөрлийн талбайг хасах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Компани нь хууль тогтоомжийг дагаж мөрдөж байгаа эсэхийг тогтоохын тулд хайгуулын тусгай зөвшөөрлийн гүйцэтгэлд хяналт тавих</li> <li>• Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайн кадастрын зургийг тогтмол шинэчлэх, Шинээр олгогдсон тусгай зөвшөөрлийн талбайг нэмж, хүчингүй болсон болон хугацаа нь дуусгавар болсон тусгай зөвшөөрлийн талбайг хасах.</li> </ul>
---	---	---	--	--

2	Геологи, хайгуулын мэдээллийн хүртээмж муу	<ul style="list-style-type: none"> <li>•Одоо байгаа геологийн мэдээллийн “MonGeoCat” -үнэ төлбөргүй онлайн мэдээллийн сангийн үргэлжүүлэн хэрэгжүүлэх</li> <li>•Одоо байгаа геологийн мэдээллийн сан дахь мэдээллийг нийтэлж сурталчлах.</li> <li>•Ийм мэдээллийг сонирхогч талуудад үнэ төлбөргүйгээр (эсвэл бага үнээр) өгөх, үүнд олон улсын уул уурхайн хөрөнгө оруулалтын арга хэмжээн дээр байж болно.</li> </ul>	Хугацаа нь дууссан тусгай зөвшөөрлийн хайгуулын мэдээллийг, түүний дотор геологийн зураглал, өрөмдлөг, суваг шуудуу, дээжийн мэдээллийг цуглуулж, нэгтгэн геологийн мэдээллийн санд оруулах.	Үргэлжүүлэн хэрэгжүүлэх.
3	Одоо үргэлжилж буй хайгуулын төслүүд цөөн байгаагаас шалтгаалж төслийн явцын бүртгэл мэдээлэл хангалтгүй байна.	Одоо хэрэгжиж буй хайгуулын төслүүдийг ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгогдсон талбайн кадастрын зураг, байршил, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдээллийн хамт нийтлэх.	Эдгээр нийтлэгдсэн мэдээллийг олон улсын уул уурхайн хөрөнгө оруулалтын хурал семинар дээр болон цахим хуудсанд байршуулж сурталчлах.	Хэрэгжүүлэлт

4	Байгаль орчин, хөдөлмөрийн болон бусад дүрэм журам, зөвшөөрөлтэй зөрчилдсөнөөс үүссэн тодорхой буй байдал.	<ul style="list-style-type: none"> <li>• Хоорондоо зөрчилдөх хууль тогтоомжийг тодорхойлох судалгаа хийх.</li> <li>• Монгол улсын хууль тогтоомжийн хоорондын зөрчлийг хэлэлцэж арилгах.</li> </ul>	Хэрэгжүүлэлт	Хэрэгжүүлэлт
5	Төрийн байгууллагын ажилтнуудын үзэмжээр хууль тогтоомжийг тайлбарлан шийдвэр гаргах	<ul style="list-style-type: none"> <li>• Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийг нягталж хоёрдмол утгатай нөхцөлүүдийг илрүүлэх</li> <li>• Эдгээр нөхцлийг орлуулах нэг мөр тодорхой шийдвэр гаргах үйл явц, тогтолцоог санал болгох.</li> </ul>	Нэг мөр тодорхой шийдвэр гаргах үйл явц, тогтолцоог бүрдүүлэх санал боловсруулж хууль тогтоомжийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулах.	Хэрэгжүүлэлт

### 8.3.2 Хөрөнгө оруулагчийн маргааныг шийдвэрлэх механизм

УУСОТС-ны хүрээнд авч үзсэн 12 бодлого, институцийн хүчин зүйлсээс Монгол улсын хувьд хамгийн муу үнэлгээ авсан хоёр хүчин зүйл нь *Хөрөнгө оруулагчдын маргааныг шийдвэрлэх механизм* ба *Хууль зүйн тогтолцоо* байсан нь Монгол улсад хөрөнгө оруулагчдын хувьд хамгийн чухал асуудал болоод байна. Эхний хүчин зүйлд Оюутолгойн зэсийн төсөлтэй холбоотой Монголын Засгийн газар болон Рио Тинтогийн хооронд удаан хугацаанд үргэлжилсэн маргаан ихээхэн нөлөөлсөн. Гэвч Монгол Улс энэ хүчин зүйлээр ийм доогуур оноо авсан нь зөвхөн Оюу толгой төслийн маргааны

шийдвэрлэлттэй холбоотой юм. Олон хөрөнгө оруулагчид ерөнхийдөө хөрөнгө оруулагчдын маргааныг шийдвэрлэх үр дүнтэй механизм дутмагаас гадна хууль, шүүхийн тогтолцоо нь муу тул бөгөөд хөрөнгө оруулагчдад шахалт үзүүлэхэд урвуулан ашиглах боломж нээлттэй тул асуудалтай гэж үзжээ. Дараахь асуудлуудыг гол бэрхшээл гэж дүгнэж болно. Үүнд:

1. Хөрөнгө оруулагчдын маргааныг шийдвэрлэх үр дүнтэй механизм байхгүй
  - a. 2016 онд байгуулагдсан Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийг хөрөнгө оруулагчдад тулгамдсан асуудлыг засч залруулах тустай механизм байж чадахгүй байна
2. Хууль тогтоомж ба хууль эрх зүйн тогтолцоо
  - a. Ил тод байдал дутмаг
  - b. Хууль тогтоомжиуд хоорндоо зөрчилддөг явдал
  - c. Хууль тогтоомжийн хэрэгжилт дутмаг
  - d. Хууль тогтоомжийн нэг мөр хэрэглээ, тайлбар дутмаг
  - e. Хууль эрх зүйн орчны байнгын өөрчлөлт
3. Шүүх тогтолцооны үйл ажиллагаа үр дүнтэй биш
  - a. Олон улсын хөрөнгө оруулагчдад шахалт үзүүлэхийн тулд шүүх тогтолцоог урвуулан ашиглах
  - b. Бизнесийн удирдлагуудад эрүүгийн хариуцлага хүлээлгэх
  - c. Шүүхийн процесс удаан бөгөөд тодорхой бус
  - d. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн үйл явц үр дүнтэй биш байгаа нь шүүхийн шийдвэр хөрөнгө оруулагчийн талд гарсан хохирлыг барагдуулах боломжгүй болгодог.

УУСОТС болон ярилцдагад оролцогчдын өгсөн дараах зарим саналууд нь энэ салбарт хөрөнгө оруулагчдын бухимдал хэр зэрэг байгааг харуулж байна. Үүнд:

- *“Монгол Улсын шүүхэд маргаан шийдвэрлэх процесс нь илт хангалтгүй тул хүлээн зөвшөөрөх боломжгүй хэдий ч Монгол Улсын Засгийн газар олон улсын маргаан шийдвэрлэх механизмаас бүх түвшинд татгалзлдаг.”*
- *“Засгийн газартай томоохон маргаан, асуудал гаргаагүй удаа цөөхөн байсан - маргаан шийдвэрлэх үр дүнтэй механизм байдаггүй. Монгол улсын хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчидтай хэрхэн харьцаж ирсэн түүх нь үнэхээр ичмээр”.*
- *“Энэ салбар удаан үргэлжилсэн маргаанаар дүүрсэн, өндөр нэр хүндтэй компаниуд Монголын эрдэс баялгийн салбарыг орхин гарсан.”*
- *“Төрийн болон Монгол Улсын хууль эрх зүйн үйл явцын ил тод, тодорхой байдал нь хэр зэрэг дутмаг вэ гэдгийг сүүлийн хорин жилийн хугацаанд хэт улс төржүүлсэн уул уурхайн салбарын удирдлагаас тод харж болно.”*
- *“Хууль эрх зүй, зохицуулалт нь тийм ч муу биш хэдий ч хууль дээдлэх зарчим үйлчилдэггүй. Уул уурхайн салбарыг бүх шатанд мөнгө завших амархан бай гэж харж байна”.*
- *“Хууль тогтоомжийг үзэмжээр хэрэглэдэг явдал нь хамгийн их саад бэрхшээл учруулдаг хүчин зүйл юм. Өөр өөр стандарт нь (нягтлан бодох бүртгэл, татвар, технологи гэх мэт) нь маргаан үүсэхэд хүргэдэг.”*

- “Монгол Улс компанийн удирдлагуудыг шоронд хийхээ болих хэрэгтэй” гэжээ.

Дээр дурдсан саналуудаас харахад Монгол Улс Хууль зүйн тогтолцооны хувьд Австралиас 89, Чили улсаас 67, Замбиас 23 оноогоор хоцорч, хууль зүйн тогтолцооны хувьд хамгийн том зөрүүтэй байгаа нь гайхах зүйл биш юм.

Австрали улс хууль дээдлэх засаглалаараа дэлхийд байнга дээгүүрт жагсдаг үр дүнтэй хууль эрх зүйн тогтолцоотой. Түүнчлэн, хөрөнгө оруулагчдыг хоёр талын хөрөнгө оруулалтын гэрээ, чөлөөт худалдааны хэлэлцээрийн заалтуудаар хамгаалж, хөрөнгө оруулагчдын шударга, тэгш хандах стандартад итгэх итгэлийг баталгаажуулдаг. Жишээлбэл, Австралийн бүх хөрөнгө оруулалтын гэрээнүүдэд (Хятад улстай байгуулсан чөлөөт худалдааны хэлэлцээрээс бусад) зохих нөхөн төлбөргүйгээр өмчийг буцааж авахаас хамгаалсан, хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын ашиг өгөөжийг чөлөөтэй шилжүүлэх боломжийг гэрээлэгч талуудаас шаардсан заалтыг агуулсан байдаг. Хууль, шүүхийн тогтолцоо ил тод, урьдчилан таамаглах боломжтой тодорхой байдаг.

<b>МАРГААН ШИЙДВЭРЛЭЛТ – САНАЛ БОЛГОЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ</b>				
№	Асуудал	Ойрын хугацааны(1-2 жил)	Дунд хугацааны (3-5 жил)	Урт хугацааны (5 - аас дээш жил)
1	Хөрөнгө оруулагчдын маргааныг шийдвэрлэх үр дүнтэй механизм байхгүй а) 2016 онд байгуулагдсан Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийг хөрөнгө оруулагчдад тулгамдсан асуудлыг засч залруулах тустай механизм байж чадахгүй байна	<ul style="list-style-type: none"> <li>• Бусад улс орнуудын маргаан шийдвэрлэх тогтолцоог судалж, Монгол Улсад тохирсон тогтолцоо/процедурыг боловсруулах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулж, үйл ажиллагааг нь Эдийн засгийн хөгжлийн яамны ИнвестМонголиа агентлагтай холбох. (шүүхтэй биш).</li> <li>• Хоёр талын хөрөнгө оруулалтын гэрээ, чөлөөт худалдааны гэрээг шинэчлэн сайжруулж хөрөнгө</li> </ul>	Хэрэгжүүлэлт



			оруулагчдад илүү баталгаа олгох	
2	<p>Хууль тогтоомж ба хууль эрх зүйн тогтолцоо</p> <p>a) Ил тод байдал дутмаг</p> <p>b) Хууль тогтоомжууд хоорндоо зөрчилддөг явдал</p> <p>c) Хууль тогтоомжийн хэрэгжилт дутмаг</p> <p>d) Хууль тогтоомжийн нэг мөр хэрэглээ, тайлбар дутмаг</p> <p>e) Хууль эрх зүйн орчны байнгын өөрчлөлт</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Хууль тогтоомжийг үзэмжээр хэрэглэх, маргаан үүсгэх орон зайг бий болгож буй хоёрдмол утгатай, тодорхой бус зохицуулалтуудыг шийдвэрлэх</li> <li>• Нэг мөр, үр дүнтэй хэрэгжилтийг хангах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Илүү тогтвортой, тодорхой, ил тод хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх</li> <li>• Хөрөнгө оруулалтын хууль тогтоомж, гэрээ хэлэлцээрт хөрөнгө оруулагчийг хамгаалах баталгаа оруулах</li> </ul>	Хэрэгжүүлэлт

3	<p>Шүүх тогтолцооны үйл ажиллагаа үр дүнтэй биш</p> <p>а) Олон улсын хөрөнгө оруулагчдад шахалт үзүүлэхийн тулд шүүх тогтолцоог урвуулан ашиглах</p> <p>б) Бизнесийн удирдлагуудад эрүүгийн хариуцлага хүлээлгэх</p> <p>с) Шүүхийн процесс удаан бөгөөд тодорхой бус</p> <p>д) Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн үйл явц үр дүнтэй бийш байгаа нь шүүхийн шийдвэр хөрөнгө оруулагчийн талд гарсан хохирлыг барагдуулах боломжгүй болгодог.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Гадаадын хөрөнгө оруулагчдад эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ маш болгоомжтой хандах</li> <li>• Хөрөнгө оруулагчидтай үүссэн шийдвэрлээгүй маргааныг шийдвэрлэх</li> <li>• Шүүхийн тогтолцоог хөрөнгө оруулагчдын эрх ашгийн эсрэг урвуулан ашигладаг одоогийн практикийг халах \</li> <li>• Шүүхийн үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Илүү үр дүнтэй шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх механизмыг бий болгох</li> </ul>	Хэрэгжүүлэлт
---	---	--	---	--------------

### 8.3.3 ГШХО-ын институцын тогтолцоо

УУСОТС-ын судалгаагаар илрүүлсэн бас нэг асуудалтай чиглэл буюу хөрөнгө оруулагчдын Монгол улсад хөрөнгө оруулахад саад болдог гэж үзсэн хүчин зүйл нь *Хөрөнгө оруулагчдыг дэмжих үйлчилгээ* юм. Хөрөнгө оруулагчид тэдэнд үзүүлж буй үйлчилгээний түвшинд сэтгэл хангалуун бус байсан бөгөөд нэг цэгийн үйлчилгээний "Дэд бүтцийн чанар"-т сэтгэл дундуур байгаагаар байнга илэрхийлсэн. Түүнчлэн Монгол Улсад гадаадын шууд хөрөнгө оруулалт хариуцсан байгууллагын үйл ажиллагаа тогтворгүй байгааг олон хүн онцолж байв.

Эдүгээ шинээр байгуулагдсан Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх ИнвестМонголиа агентлаг өнгөрсөн хугацаанд олон удаа зохион байгуулалтын өөрчлөлтөд орж, Засгийн газрын гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих чиг үүрэг нь тасалдаж, тохиолдлын чанартай, тууштай бус болсон. Тус байгууллагын институцын чадавхи сул, хөрөнгө оруулагчид зохих түвшний, утга төгөлдөр үйлчилгээ, дэмжлэг туслалцаа авч чадахгүй байна. Түүнчлэн ГШХО-ын хэрэгцээ, ач холбогдлын талаар олон нийтэд мэдээлэл хүргэх нэгдсэн арга барил байдаггүй.

Энэ чиглэлийн асуудлуудыг дараах байдлаар дүгнэж болно. Үүнд:

1. Засгийн газрын ГШХО-ыг дэмжих чиг үүрэгт төвлөрсөн, тасралтгүй арга барил дутмаг
2. ИнвестМонголиа агентлагийн институцын чадавхи сул
3. Гадаадын хөрөнгө оруулагчдад дэмжлэг туслалцаа үзүүлэх үр дүнтэй үйлчилгээ байхгүй
4. ГШХО-ын хэрэгцээний талаар олон нийтийн ойлголт дутмаг

Баруун Австралийн уул уурхайн хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого сайн туршлага болж байна. Invest and Trade WA нь Баруун Австралийг хөрөнгө оруулалт хийх газар болгон сурталчилж, худалдаа, хөрөнгө оруулалттай холбоотой асуудлаар "нэг цонхны үйлчилгээ" үзүүлдэг бөгөөд Баруун Австралийн бизнесүүдэд экспорт хийхэд нь туслалцаа үзүүлдэг. Мужийн засгийн газар нь уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтыг дэмжих, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, Баруун Австралид хайгуулын үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор төрөл бүрийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсээр байна. 2009 оны 4-р сард хэрэгжүүлж эхэлсэн уул уурхайн түрээсийн орлогоос санхүүждэг Хайгуулын хөрөнгө оруулалтын хөтөлбөр (EIS) нь бодлогын хамгийн том санаачилга болсон. 2021 оноос эхлэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай хайгуулыг дэмжих, улмаар ашигт малтмал, эрчим хүчний шинэ эх үүсвэр нээлтийг дэмжих зорилгоор жил бүр 10 сая австрали доллар хуваарилж байсныг 12.5 сая австрали болгон нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнд геофизикийн судалгаа, хэтийн төлөвийн зураглал, стратегийн судалгааны хамтын ажиллагааг дэмжих, аж үйлдвэртэй хамтран санхүүжүүлдэг хайгуулын үйл ажиллагааны хөтөлбөрүүд багтана. ХХОС-ийн эхний 10 жилийн эдийн засгийн нөлөөллийн хөндлөнгийн үнэлгээний тайланд Баруун Австрали нь ХХОС-д оруулсан нэг доллар тутамд нийт 31 австрали долларын өгөөж хүртсэн гэсэн тооцоолол гарчээ.

Чили улсад Засгийн газрын “InvestChile” агентлаг нь Чили улсыг ГШХО хийх газар болгон дэлхийн зах зээлд сурталчлах үүрэгтэй бөгөөд гадаадын хөрөнгө оруулагчдын ашиг сонирхолыг тус улсад байгаа боломжуудтай холбох гүүр болж өгдөг. Уг агентлаг нь ГШХО-ыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг сурталчлах, дэмжих, зохицуулах, хэрэгжүүлэх чиглэлээр олон төрлийн хөтөлбөр санаачлагыг хэрэгжүүлдэг.<sup>41</sup>

<b>ГШХО-ЫН ИНСТИТУЦЫН ТОГТОЛЦОО– САНАЛ БОЛГОЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ</b>				

<sup>41</sup> InvestChile: <https://investchile.gob.cl/aboutus/>

№	Асуудал	Ойрын хугацааны(1-2 жил)	Дунд хугацааны (3-5 жил)	Урт хугацааны (5-аас дээш жил)
1	<p>Засгийн газрын ГШХО-ыг дэмжих чиг үүрэгт төвлөрсөн, тасралтгүй арга барил дутмаг</p> <p>а) ИнвестМонголиа агентлагийн институцын чадавхи сул</p>	<ul style="list-style-type: none"> <li>• ИнвестМонголиа агентлагийн чадавхийг бий болгож, бусад ул орнуудтай шууд өрсөлдөн хөрөнгө оруулалтыг татах чадавхийг бий болгох.</li> <li>• Монгол улсын уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах, хадгалах шинэлэг бодлогын санаачилга, хөтөлбөр, арга хэрэгслийг судалж, нэвтрүүлэх</li> </ul>	<p>Тус агентлагийн дунд болон урт хугацааны тогтвортой үйл ажиллагааг хангах, тэр дундаа МУЗГ-ын бусад агентлагуудтай хамтран ажиллах арга барилыг тодорхойлох</p>	<p>Хэрэгжүүлэлт</p>
2	<p>Гадаадын хөрөнгө оруулагчдад дэмжлэг туслалцаа үзүүлэх үр дүнтэй үйлчилгээ байхгүй</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Хөрөнгө оруулагчдын нэг цэгийн үйлчилгээ болон үйлчилгээг сайжруулах</li> <li>• Хөрөнгө оруулагчдын визний нөхцөлийг сайжруулж,</li> </ul>	<p>Хөрөнгө оруулагчдын нэг цэгийн үйлчилгээний дунд хугацааны болон урт хугацааны тогтвортой ажиллагааг хангах</p>	<p>Хэрэгжүүлэлт</p>

		цахимжуулах ажлыг эрчимжүүлэх		
3	ГШХО-ын хэрэгцээ, ач холбогдлын талаар олон нийтийн ойлголт муу	ГШХО-ын ач холбогдол, бусад баялаг ихтэй орнуудад ГШХО-ын гүйцэтгэх үүргийг олон нийтэд ойлгуулах мэдээлэл харилцааны стратеги боловсруулах.	ГШХО-ын ач холбогдол, үүрэг ролийг олон нийтэд ойлгуулах мэдээлэл харилцааны стратегийг хэрэгжүүлэх.	Хэрэгжүүлэлт.


### 8.3.4 Татварын горим

Монгол улсын уул уурхайн салбарын татварын горим, түүний дотор татвар болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах үнэ зэрэг нь олон улсад өрсөлдөхүйц биш, оновчтой бус байна. Мөн Засгийн газар ойр ойрхон солигддог нь татварын бодлогын тодорхойгүй байдалд хүргэсэн.

Австрали улсад нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох аргачлал нь муж бүрт өөр өөр байдаг. Жишээлбэл, Баруун Австралид уурхайн ашиглалтын үйл явцыг дагаад хувь хэмжээ буурах ялгаварлалтай татварын горимыг нэвтрүүлсэн бол Квинсланд мужид нь бүтээгдэхүүний үнийг дагаад өсөн нэмэгдэх төлбөрийн горимыг нэвтрүүлсэн.

Монгол Улс бараг бүх төрлийн ашигт малтмалын (дотоодын нүүрс, түгээмэл тархацтай ашигт малтмалын борлуулалт зэрэг цөөн тохиолдлоос бусдад) 5 хувиар нөөц ашигласны төлбөр ногдуулдагаараа онцлогтой бөгөөд боловсруулалтын түвшинг дагаад буурах хувь хэмжээгээр өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр ногдуулах схемийг 9.1-т харуулав.

**Зураг 9.1 Монгол улсын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн горим**



Монгол улсын нөөц ашигласны төлбөр ногдуулах өнөөгийн горим нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах олон улсын нийтлэг практикаас давсан. Бусад орнуудад худалдан авагч ашигт малтмалыг хайлуулах, цэвэршүүлэх үйл явцад хортой нөлөө үзүүлдэг дагалдах эрдэс /металл/элементэд торгууль ногдуулах нь хэвийн үзэгдэл юм. Дараа нь хэрэглэж буй гэрээний болон ердийн торгууль дээр үндэслэн бүтээгдэхүүний үнээс зохих суутгал хийхийг улс орнууд хүлээн зөвшөөрдөг. Тийм учраас бүтээгдэхүүний үнээс гэрээнд заасан эсвэл ердийн торгуулийн металлын хасагдуулгыг зөвшөөрч тохируулга хийсэн борлуулалтын үнэд үндэслэн нөөц ашигласны төлбөр тооцдог.

Монгол дахь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн суурь, ногдуулалтыг Баруун Австрали, Квинсландын горимтой харьцуулбал дараахь ялгаа байна.<sup>42</sup>:

<sup>42</sup> Discussion Paper on the Imposition of Mineral Royalties on Minor Elements, Australia Mongolia Extractives program (AMEP), 2021.

- Монгол дахь зэсийн баяжмалд ногдуулж буй нөөц ашигласны төлбөр нь Австралийн дүйцэх төлбөрөөс хамаагүй илүү өндөр байна (өөрөөр хэлбэл Австралид 52,97 ам. доллар, 49,80 ам. Доллар байхад Монгол улсад 209,90 ам. доллар ногдуулж байна).
- Монгол улсын нөөц ашигласны төлбөрийн дийлэнх хувийг зэсийн үнэ харьцангуй өндөр үеийн зэсийн баяжмалд хамаарах үндсэн 5% дээр нэмж ногдуулсан 12%-ийн нөөц ашигласны төлбөр эзэлж байна.
- Монгол дахь цайрын баяжмалд ногдуулж буй нөөц ашигласны төлбөр нь (87.84 ам. доллар) Австралийнхаас бараг хоёр дахин илүү байна (42.56 ам. доллар ба 35.75 ам. доллар). Монголын нөөц ашигласны төлбөрийн 1/3 орчимыг цайрын үнэ харьцангуй өндөр үеийн цайрын баяжмалд хамаарах үндсэн 5% дээр нэмж ногдуулдаг 2.4 хувийн нөөц ашигласны төлбөр бүрдүүлдэг.

Замби улсад Замбийн Орлогын Газар (ZRA) нь ашигт малтмалын үнээс (чанар дээр үндэслэн) хасагдуулга хийхийг зөвшөөрдөг. Жишээлбэл, зэсийн баяжмалд агуулагдах зэсийн үнийг агуулагдах зэсийн хувь болон зэсийн норм үнэд (нийтлэгдсэн жишиг үнэ) үндэслэн тогтоох боловч баяжмалд агуулагдаж буй хортой элементүүд болон тэр ч байтугай чийгийн хасагдуулга хийхийг зөвшөөрдөг. Замбиын орлогын алба нь зэсийн баяжмалд агуулагдаж байгаа ийм хортой элементүүдэд хайлуулах үйлдвэрүүдэд ямар хэмжээний торгууль оногдуулж байгааг хянаж байдаг. 2019 оны эхээр Монгол Улсын Татварын ерөнхий газарт хийсэн сургалтын үеэр үүнтэй төстэй мэдээллийг өгч, ярилцаж байсан. Дараагийн хуудсанд байгаа Хүснэгтэд худалдан авагч (хайлуулах компани)-ийн дүгээс торгууль ногдуулж болох хортой элементүүдийг харуулав. Ийм элементүүд баяжмалд агуулагдаж байгаа тохиолдолд нөөц ашигласны төлбөр ногдуулах ёсгүй, харин холбогдох торгуультай дүйцэхүйц хасагдуулгыг хийх нь илүү үнэдэслэлтэй байх болно гэдгийг хэлэх нь зүйтэй.<sup>43</sup>

---

<sup>43</sup> Toolkit for Addressing Difficulties in Accessing Comparables Data for Transfer Pricing Analyses, including a supplementary report on Addressing the Information Gaps on Prices of Minerals Sold in an Intermediate Form, OECD, (2017), p184. <https://www.oecd.org/ctp/toolkit-on-comparability-and-mineral-pricing.pdf>

## Additional Information: Impurities in Copper Concentrates

The table below outlines the common penalty elements that may be found in copper concentrate contracts. Please note - these tolerances are indicative.

Penalty Element	Reason for Penalty	For each %	Exceeding %
Arsenic	Reduces conductivity of copper, raises recrystallization temperature of copper, causes cracking at the copper grain boundaries. Also a known human carcinogen, requiring environmental mitigation measures. Expensive to dispose of.	0.1	0.2
Antimony	Reduces copper cathode conductivity, annealability (ability of the copper to be strengthened through annealing process), drawability (ability to stretch out copper rods into finer wire). Also a possible human carcinogen.	0.01	0.1
Bismuth	Causes cracking of copper rods, poor drawability even at very low concentrations. As concentrations increase, the copper will work-harden more quickly (broadly, the copper hardens when bent or deformed).	0.01	0.05
Selenium	Makes cathode copper more prone to cracking during wire drawing. Toxic to humans at higher concentrations. Combines with copper during refining, reducing amount of copper recovered.		
Tellurium	Increases the brittleness of copper, causing rod cracking and poor drawability. Combines with copper during electrolytic refining, reducing amount of copper recovered.		
Lead	Toxic to humans, requiring environmental mitigation measures.	1.0	1.0
Nickel	Nickel in anodes decrease the solubility of copper in the electrolyte liquid during the refining stage. It must also be removed from the electrolyte. Nickel is also a human carcinogen, requiring environmental mitigation measures. But the recovered nickel sulphate can be sold.	0.1	0.5
Cobalt	Toxic to humans at higher concentrations. But can be recovered and sold if concentrations are high enough.	0.1	0.5
Chlorine	Causes corrosion in smelter components such as smelter flues if it condenses as hydrochloric acid. Can require environmental mitigation.	0.01	0.05
Fluorine	Can pose significant difficulties for smelters if it mixes with water and forms hydrofluoric acid which corrodes and in high concentrations, causes health problems. Smelters are reluctant to accept concentrates with high fluorine, or charge significant handling penalties.	10 ppm	330 ppm
Cadmium	A toxic heavy metal classed as a carcinogen to humans, requiring mitigation measures.	n.a.	n.a.
Mercury	Highly toxic, raising waste disposal costs and can damage smelter equipment. Can remain in smelter gases, requiring the gas to be cooled below zero degrees Celsius to reduce its concentration. Techniques to remove mercury add to capital and operating costs. Requires disposal.	1 ppm	10 ppm
Zinc	In high enough concentrations, will increase viscosity of the slag during smelting, increasing the loss of copper.	1.0	3.0
Silica, Alumina, Magnesia	In high enough percentages, smelter melting point is increased, requiring higher operating temperatures (therefore more energy) to limit lost copper.	1.0	5.0

Source: C Fountain, *The Whys and Wherefores of Penalty Elements in Copper Concentrates*.  
n.a. – not available. Note: Uranium is also a problem element at high concentrations, making the concentrate harder to sell.



Замбийн засгийн газраас өмнөх жилүүдэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг (бусад улс орнууд шиг) албан татвар ногдох орлогоос хасагдуулахгүй байх шийдвэр гаргаж, нөөц ашигласны төлбөр болон татварын хувь хэмжээг өөрчилсөн нь 2,5 тэрбум ам.долларын (3 уул уурхайн компани) өргөтгөлийн төслийг царцаасан. Шинэ засгийн газар (2021 оны 8-р сард сонгогдсон) хасагдуулгыг зөвшөөрөхгүй байх шийдвэрийг цуцалсан бөгөөд компаниуд өргөтгөлийн төлөвлөгөөгөө дахин үргэлжлүүлж байгаагаа мэдэгдэв. Харин шинэ хайгуул, ашиглалтын хөрөнгө оруулалтын хувьд УУХҮЯ-ны удирдлагууд уул уурхайн салбарын хөрөнгө оруулагчид болгоомжлолтой хэвээр байгаа бөгөөд энэ талаар хэлэхэд эрт байгааг хэлж байна. Тэд удахгүй болох олон улсын хурал дээр эерэг дохиог харна гэж найдаж байна.

<b>ТАТВАРЫН ГОРИМ– САНАЛ БОЛГОЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ</b>				
<b>№</b>	<b>Асуудал</b>	<b>Ойрын хугацааны(1-2 жил)</b>	<b>Дунд хугацааны (3-5 жил)</b>	<b>Урт хугацааны (5-аас дээш жил)</b>
1	Монгол улсын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах суурийг тооцоолоход ашиглаж буй жишиг үнэ нь ДХБ-ын INCOTERMS-ийн нөхцөлтэй нийцэхгүй байна.	Задгай ашигт малтмалын хувьд (нүүрс, жонш гэх мэт) Монголын ашигт малтмалын үйлдвэрлэлийн зах зээлийг судалж, эдгээр чиглэлд тээвэрлэх INCOTERMS-ийн нөхцлийг ашиглах.	Хэрэгжүүлэлт	Хэрэгжүүлэлт

2	Худалдан авагч хорт элементийн “торгууль” тооцдог эрдэс /элементэд нөөц ашигласны төлбөр ногдуулах нь зарагдаагүй бүтээгдэхүүнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулж, улмаар тэдгээр металл/эрдэсийн хувьд давхар торгууль болдог.	<ul style="list-style-type: none"> <li>• Хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрүүдэд түгээмэл хэрэглэдэг торгуулийн металлын мэдээллийн санг бүрдүүлэх.</li> <li>• Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох үнээс эдгээр торгуулийг хасагдуулахыг зөвшөөрөх.</li> </ul>	Хэрэгжүүлэлт	Хэрэгжүүлэлт
3	Олборлогч аль хэдийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлчихсөн бүтээгдэхүүнийг худалдаж авдаг боловсруулах үйлдвэрүүдэд нөөц ашигласны төлбөр ногдуулж байна. Энэ нь гадаадын болон дотоодын компаниудад ногдуулах нөөц ашигласны төлбөр ба/эсвэл борлуулалтын зөрүүгээс үүдэлтэй бололтой.	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн давхар ногдуулалтыг халах	Хэрэгжүүлэлт	Хэрэгжүүлэлт
4	Баяжмалаас зэс гэх мэт металлыг гаргаж авахад гарсан хайлуулах зардал болон цэвэршүүлэх зардалыг (ТС болон РС) төлбөр ногдуулах дүнгээс хасч тооцдоггүй. (Нөөц ашигласны төлбөр ногдуулах металлын эцсийн үнийг гаргаж авахын тулд ТС болон РС хасч тооцдог гэдгийг анхаарна уу.)	Бусад ашигт малтмал олборлогч орнуудад нөхцөл байдал ямар байгааг судалж, Монгол Улс өрсөлдөх чадвартай байхын тулд ийм хасагдуулга хийх шаардлагатай эсэхийг тодорхойлох.	Жишиг үнээс зохих хасагдуулгыг хийх механизмыг бий болгох	Хэрэгжүүлэлт

5	<p>Зарим төрлийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ бусад ашигт малтмалтай харьцуулахад тэгш бус буюу өндөр, жишээлбэл, зэсийн дотоод борлуулалтад хоёр дахин бага хувь хэмжээгээр нөөц ашигласны төлбөр ногдуулдаг.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Ашигт малтмалын бүтээгдэхүүний дотоод болон гадаад борлуулалтын нөөц ашигласны төлбөрийн ялгаварлалтай хувь хэмжээг хасах.</li> <li>• Үндсэн металл, үнэт металл, эрдэнийн чулуу, үйлдвэрийн ашигт малтмал гэх мэт төрөл бүрийн бүтээгдэхүүний нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ бүхий Хүснэгт гаргах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр өсөн нэмэгдэх хувь хэмжээтэй байх, өөрөөр хэлбэл металл/эрдэсийн үнэ тодорхой босго хэмжээнээс давсан тохиолдолд илүү хувь хэмжээгээр ногдуулах эсэхийг тодорхойлох.</li> <li>• Монгол Улс ГШХО-ыг татахад хэр өрсөлдөх чадвартайг тодорхойлохын тулд бусад улс орнуудын нөөц ашигласны төлбөрийн тогтолцоог тогтмол хянаж байх.</li> </ul>	Хэрэгжүүлэлт
---	---	---	--	--------------

### 8.3.5 Макро орчин

Макро орчины төлөв байдлын асуудлууд нь зөвхөн уул уурхайн салбарт төдийгүй ерөнхийдөө маш чухал юм. Макро түвшний асуудал нь өндөр түвшинд эсвэл нарийн тогтсон системд өөрчлөлт хийхийг шаарддаг, харин эдгээрийг өөрчлөхөд хялбар байдаггүй. Засгийн газар өөрчлөлтийг эхлүүлсэн ч үр дүнд хүрэхэд удаан хугацаа шаардагддаг. Гэхдээ уул уурхайн бусад орнуудад жишгээр гадаадын хөрөнгө оруулагчдыг татах алхмуудыг хийж эхлэх нь чухал юм.

Уул уурхайн салбар бол маш урт хугацааны, маш их хөрөнгө шаардсан салбар юм. Ийм учраас аль болох намуудын улс төрийн асуудлаас (болон засгийн өөрчлөлтөөс) ангид байх ёстой.

<b>МАКРО ТҮВШИН – САНАЛ БОЛГОЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ</b>				
№	Асуудал	Ойрын хугацааны(1-2 жил)	Дунд хугацааны (3-5 жил)	Урт хугацааны (5-аас дээш жил)
1	Улс төрийн тогтвортой байдал дутмаг	Уул уурхайн салбарт ГШХО-ын гүйцэтгэх үүрэгтэй холбоотой улс төрийн намуудын нэгдсэн мэдэгдлийн төслийг боловсруулах.	Энэхүү улс төрийн намуудын хамтарсан мэдэгдлийг нийтлэн түгээх, олон улсын уул уурхайн хөрөнгө оруулалтын чуулган дээр түгээх.	Хэрэгжүүлэлт

2	Баялгийг өмчирхөх үндсэрхэг үзэлтэй холбоотой популист мэдэгдлүүд	<ul style="list-style-type: none"> <li>• Баялгийг өмчирхөх үндсэрхэг үзлийг олон талаас тайлбарласан баримт бичгийн төслийг дэлхийн бусад улс орнуудын хөрөнгийн улсад авсан, хувьчилсан жишээтэйгээр боловсруулах.</li> <li>• Уул уурхайн салбар (хувийн)-аас Монгол улсын эдийн засаг, ард иргэд, олон нийт хэрхэн үр өгөөж хүртэх ёстой талаар тодорхой тайлбарласан баримт бичгийн төслийг боловсруулах.</li> </ul>	Баялгийг өмчирхөх үндсэрхэг үзлийг тайлбарласан баримт бичгийг түгээх.	Хэрэгжүүлэлт
3	Төрийн уул уурхайн орлогыг удирдах менежмент сул	Ашигт малмталын орлогыг төр хэрхэн удирдаж, зарцуулах талаар төрөөс баримтлах бодлогыг тайлбарласан баримт бичгийг боловсруулан нийтлэх. (ОҮИТБС-ын Ажлын албаны оролцоог ашиглах.)	Жил бүрийн ОҮИТБС-ын тайланд уул уурхайн орлогын зарцуулалтын мэдээллийг тусгах.	Хэрэгжүүлэлт.

4	Орон нутгийн иргэдтэй харилцах харилцаа асуудалтай.	Уул уурхайн аливаа үйл ажиллагаатай холбоотой янз бүрийн оролцогч талууд болох компани, улсын болон орон нутгийн засаг захиргаа, орон нутгийн иргэдийн хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой тусгасан баримт бичгийн төслийг боловсруулах.	Ийм баримт бичгийг уул уурхайн явагдаж буй бүх газарт түгээж, орон нутгийн засаг захиргааны хурлаар хэлэлцүүлэн орон нутгийн иргэдийн ойлголт, дэмжлэгийг бий болгох. Нөхцөл байдал өөрчлөгдөх хэрээр байнга шинэчилж нэмэлт, өөрчлөлт оруулж байх.	Хэрэгжүүлэлт.
---	---	---	---	---------------

# 10. ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТАЙЛАН

Энэхүү төслийн Ажлын даалгаврын дагуу судалгааны ажлын үр дүн, санал болгож буй авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулах, хэлэлцүүлэх зорилгоор хэлэлцүүлэг семинарыг зохион байгуулав. Тус хэлэлцүүлэг нь 5-р сарын 17-ны өдөр Улаанбаатар хотноо болсон бөгөөд Монгол Улсад зорчиж чадаагүй эсвэл бусад шалтгаанаар биечлэн оролцох боломжгүй хүмүүсийг онлайнгаар оролцуулсан болно.

Төслийн багийн гишүүдээс гадна 68 хүн хэлэлцүүлэгт хамрагдсанаас 16 нь онлайнгаар оролцсон.

Хэлэлцүүлгийг нээж УУХҮЯ-ны дэд сайд О.Батнайрамдал үг хэлж, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны (ЕСБХБ) Монгол дахь суурин төлөөлөгч Ханнес Такакс тус төслийн хүрээнд хийгдсэн ажлын талаар танилцууллаа.

Дараа нь төслийн багийн ахлах Рон Смит “Уул уурхайн салбар ба нийлүүлэлтийн сүлжээний жишгийн судалгааны үр дүн” сэдвээр танилцуулга хийв. Энэхүү танилцуулгад Уул уурхайн салбарын оролцогч талуудын судалгааг (УУСОТС) нэгтгэн дүгнэж, өмнөх Фрейзер институтын судалгаатай харьцуулж, Монголын уул уурхайн хөрөнгө оруулалтын нөхцөл байдлыг Баруун Австрали, Чили, Замби улсынхтай харьцуулан авч үзлээ. СВОТ, Зөрүүгийн шинжилгээг хэлэлцэж, санал болгож буй авч хэрэгжүүлвэл зохих гол арга хэмжээнүүдийг онцлов. Танилцуулгад ашигласан слайдуудыг Хавсралт 5-д оруулсан болно.

Танилцуулгын дараа товч Асуулт, Хариулт явагдсан болно.

Кофены завсарлагааны дараа ноён Д. Мягмарсүрэн панел хэлэлцүүлгийг удирдан явуулсан бөгөөд үүнд дараах хүмүүс оролцов:

О. Батнайрамдал, УУХҮЯ-ны дэд сайд

Х. Амаржаргал, Рио Тинто Монгол компанийн гүйцэтгэх захирал

Жон Лайонс, "Эрдэнэ Ресурс Девелопмент" төслийн дэд ерөнхийлөгч

Д. Ачит-Эрдэнэ, Аспайр Майнинг компанийн захирал, МСС компанийн захирал

Г.Батцэнгэл, “Mongolian Mining Corporation” компанийн гүйцэтгэх захирал

Жулиен Лоуренс, O2 Mining Ltd- ийн захирал, Монгол дахь Австралийн Худалдааны танхимын

Тэргүүн

Хэлэлцүүлэгт оролцсон гишүүд судалгааны талаар саналаа хэлж, модераторын тавьсан асуултад хариулав.

УУХҮЯ-ны дэд сайд 1990-2021 оны хооронд Монгол улсад нийт 37 тэрбум ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт (энэ тоог баталгаажуулах шаардлагатай?) хийгдсэнээс 70 хувь нь эрдэс баялгийн хайгуулын салбарын хөрөнгө оруулалт байсныг тэмдэглэж судалгаанд оролцсон бүх хүмүүст талархал илэрхийлэв. Тэрээр энэхүү судалгаагаар тодорхойлсон Монгол улсын хөрөнгө оруулалтын орчны олон давуу болон сул талуудыг хүлээн зөвшөөрч, тулгамдаж буй асуудлын талаар МУ-ын зүгээс бодлогын хариу арга хэмжээ авах шаардлагатайг мэдэгдэв. Түүнчлэн, Засгийн газар нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийг ул суурьтайгаар шинэчлэн найруулах саналыг Хууль зүйн

яаманд өргөн барьсан талаар онцоллоо. Шинэчилсэн найруулгаар хуулийн 50 хувьд өөрчлөлт орох бололтой.

Тэрээр тус улсад илүү их хайгууль хийх шаардлагатай байгаатай санал нэгдэж, тусгай зөвшөөрөл авах хүсэлт илгээх систем дижитал, онлайн болсныг онцолж, энэ онд олгох тусгай зөвшөөрлийн тоо өнгөрсөн жилийнхээс нэмэгдэнэ гэдгийг тэмдэглэв. 400-аас 500 хүртэлх талбайд хайгууль хийх тусгай зөвшөөрлийг олгох тендер зарлах бөгөөд тендерт оролцогчдын мэдээллийг онлайн порталаар харах боломжтой болох юм байна.

Хэлэлцүүлэгт оролцсон бусад гишүүд Монгол улс шиг эрдэс баялаг ихтэй оронд гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) маш чухал, гэхдээ ийм хөрөнгө нь “хувирамтгай” бөгөөд хөрөнгө оруулалтын нөхцөл хамгийн таатай тэр газар руу урсдаг гэдгийг онцлов.

Төрийн байгууллагууд хоорондоо нэгдмэл байр суурьтай байдаггүй, мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийг тууштай дагаж мөрддөггүй гэдгийг дурдлаа. Татварын хууль тогтоомж хоёрдмол утгатай байдаг тул албан тушаалтнууд хууль тогтоомжийг нэг мөр, тууштай ашигладаггүй гэв. Мөн Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэн найруулах нь чухал ч дэндүү удаашралтай байгаа тул хурдасгах нь зүйтэй гэсэн байр суурийг илэрхийлж байв. МУЗГ-аас хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх шаардлагатай байгааг онцлов.

Хэлэлцүүлгийн гишүүд Монгол улсад боломж байгаа бөгөөд бүх оролцогч талууд нэгдсэн ойлголтод хүрч, эдгээр боломжуудыг дэлхий нийтэд сурталчлах ёстой гэдэгт санал нэгдэв.

Уул уурхай бол өндөр өртөгтэй, эрсдэлтэй, урт хугацаатай бизнес гэдгийг онцоллоо. Тус салбар нь улсын эдийн засгийн томоохон хэсгийг бүрдүүлдэг хэдий ч бид хүлээлтээ бодитой болгох хэрэгтэй. Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт хууль тогтоомжийн улмаас саараад байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулагчид Монгол руу буцаж ирэхэд олон жил шаардлагатай байж мэдэхээр байна.

Нэг онцгой анхаарал татсан асуудал бол зэсийн үнэ 10,000 ам.доллар/тонноос дээш гарах тохиолдолд төлөх АМНАТ-ын хувь хэмжээ хэт өндөр байгаа явдал юм - энэ тохиолдолд 25 хувийн АМНАТ төлөхөөр байгаа энэ нь Монгол улсыг бусад улстай өрсөлдөх чадваргүй болгож байна.

Хайгууль нь салбарын цаашдын хөгжлийн гол түлхүүр бөгөөд Монгол Улсын хувьд ашиглалтын бүх шат дамжлага, цар хүрээг хамарсан төсөл, олон төрлийн боломжийг бий болгох нь чухал юм. Ингэснээр хөрөнгө оруулагчдын томоохон нөөцийг бүрдүүлэх боломжтой болно. Бүх төрлийн хайгуулын компаниуд, уул уурхайн үйлчилгээ үзүүлэх оператор компаниудыг оруулж ирэхийн тулд тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог либералчлах шаардлагатай байна.

Хэлэлцүүлгийн модератор нь авч хэрэгжүүлвэл зохих Арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан зүйлүүд нэлээд ерөнхий шинжтэй байгааг онцолж панелийн гишүүдээс илүү тодорхой санал байгаа эсэхийг асуув. Хэлэлцүүлэгт оролцогчид тодорхой асуудалд анхаарлаа төвлөрүүлэхээс илүүтэй хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахын тулд хамтарсан арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь чухал гэж хариулав.

Хайгуулын тусгай зөвшөөрөл авах, шилжүүлэх, худалдах бүхий л үйл явцыг боловсронгуй болгохын тулд зорилтот арга хэмжээ авч хэрэгжүүлж төрөл бүрийн хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах нь чухал болохыг онцлов. Хөрөнгө оруулагчид дэлхийн хэмжээний томоохон



ордуудыг ашиглахыг хүсдэг ба Монгол Улс ч ийм хөрөнгө оруулагч нарыг татахыг хүсч байна. Үүний тулд жижиг хэмжээний хайгуулын компаниуд ч үүргээ гүйцэтгэж, орд газруудыг илрүүлж, томоохон компаниудад шилжүүлэх нь чухал гэлээ.

Монгол Улс уул уурхайгаас орж ирсэн орлогыг тийм ч сайн удирдаж чадахгүй байгаа тул иргэдийн амьжиргаа дээшилсэнгүй гэж ярьж байлаа.

Хэлэлцүүлгийн панелийн нэг гишүүн тус улсад металлургийн (коксжих) нүүрсний боломж их хэвээр байгааг дурдлаа. Коксжих нүүрсийг гангийн үйлдвэрлэлд голчлон ашигладаг бөгөөд эрчим хүчний нүүрстэй адил уур амьсгалын асуудал төдийлөн саад болохгүй.

Модераторын асуултад дэд сайд хэлэлцүүлэгт оролцогчдын илэрхийлсэн байр суурьтай санал нэг байна гэж хариулав. Засгийн газрын Алсын хараа-2050 бодлогын баримт бичигт урт хугацаанд хэрэгжүүлэх тодорхой зорилтуудыг тусгасан. Салбарын сайд тус бүр салбарынхаа тулгамдсан асуудлуудыг тусгасан тул Ерөнхий сайдын хувьд зорилтуудыг эрэмбэлэх амаргүй шаардлагатай нүүр тулах болно.

Тэрээр, ГШХО-ын асуудлыг хариуцаж зохицуулах байгууллага нь Эдийн засгийн хөгжлийн яам байх ёстой гэдгийг дурдлаа.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ хэт өндөр байгаа тухайд тэрээр үүнд үнэлгээ хийх шаардлагатай байгааг тэмдэглэв.

Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн саналыг УИХ-д өргөн барихаас өмнө салбар, төрийн байгууллагууд, олон нийтээр тус тус хэлэлцүүлж санал авах ёстой. Баялгийг өмчирхөх үндсэрхэг үзлээс зайлсхийхийн тулд хамтран ажиллах, нэгдсэн ойлголтод хүрэх шаардлагатайг онцоллоо.

Түүнчлэн, дэд сайд уг судалгааны тайланг хэвлэн нийтлэхийг хүсч байгаагаа тэмдэглэв.

Төгсгөлд нь ЕСБХБ-ны Ц.Хангай судалгааны ажил болон хэлэлцүүлэгт оролцсон бүх хүмүүст талархал илэрхийлээд ЕСБХБ-ны зүгээс Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахын төлөө ажиллаж байгаа байгууллагуудад үргэлжлүүлэн туслалцаа үзүүлэхэд бэлэн байгааг илэрхийлэв.

# ХАВСРАЛТ 1: ФРЕЙЗЕРИЙН СУДАЛГАА БОЛОН УУСОТС-НЫ АСУУЛТУУД

2017, 2020 оны Фрейзерийн судалгааны асуултууд	2021 оны УУСОТС-ны Фрейзерийн судалгааны асуултуудтай ижил буюу дүйцэхүйц асуултууд
1. Ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулах боломж (шилдэг туршлагын бодлого хэрэгжүүлсэн тохиолдолд)	5a. Ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулах боломж (шилдэг туршлагын зохицуулалтын орчинд)
2. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй дүрэм журмын зохицуулалт, тайлбар, хэрэгжүүлэлттэй холбоотой тодорхой бус байдал	7e. Уул уурхайн салбарын зохицуулалтын горим (зохицуулалт, тайлбар, хэрэгжүүлэлт)
3. Байгаль орчны зохицуулалттай холбоотой тодорхой бус байдал (тогтвортой байдал, тууштай байдал, цаг үеэ олсон байдал, шинжлэх ухаанд үндэслэсэн байдал)	7f. Байгаль орчны зохицуулалтын горим (зохицуулалт, тогтвортой байдал; үйл явцын цаг үеэ олсон байдал, тууштай байдал; тусгай хамгаалалттай газар нутгийн хил хязгаар)
4. Зохицуулалтын давхардал, зөрчил	Х.Г.
5. Хууль эрх зүйн тогтолцоо(шударга, ил тод, авлигагүй, цаг үеэ олсон байдал, үр дүнтэй удирдлага)	7g. Хууль эрх зүйн тогтолцоо(process, transparency, timeliness, fairness, uniform application үйл явц, ил тод байдал, цаг үеэ олсон байдал, шударга байдал, жигд хэрэглээ)
6. Татварын горим(personal, corporate, payroll, other, and compliance complexity хувь хүний, аж ахуйн нэгжийн, цалингийн, бусад болон дагаж мөрдөлтийн нарийн төвөгтэй байдал)	7a. Татварын горим ба практик (хувь хүний / аж ахуйн нэгжийн/цалингийн /хөрөнгийн татварын хувь хэмжээ ба нарийн төвөгтэй байдал)
7. Маргаантай газрын заргатай холбоотой тодорхой бус байдал	7h. Газрын зөвшөөрөл (шийдвэрлэх процесс)
8. Онгон байгаль, цэцэрлэгт хүрээлэн, археологийн дурсгалт газар гэх мэт хамгаалалтад авах газар нутагтай холбоотой тодорхой бус байдал	Х.Г.
9. Зам, эрчим хүч гэх мэт дэд бүтэц.	5c. Дэд бүтэц (ус, эрчим хүч, зам)

10. Нийгэм, эдийн засгийн гэрээ хэлэлцээрүүд, орон нутгийг хөгжүүлэх нөхцөл	7i. Орон нутгийн иргэдтэй харицах харилцаа, үүрэг амлалт (орон нутгийн агуулга, худалдан авалт ба ажлын байр, CSR)
11. Худалдааны саад бэрхшээл(тарифын/тарифын бус саад бэрхшээл; валютын арилжааны хязгаарлалт; ашгийг шилжүүлэх боломж)	7j. Худалдаа (импорт/экспорт, тарифын/тарифын бус саад бэрхшээл; валютын арилжааны хязгаарлалт; ашгийг шилжүүлэх боломж)
12. Улс төрийн тогтвортой байдал	7l. Улс төрийн тогтвортой байдал, аюулгүй байдал (үйл ажиллагааны болон боловсон хүчний)
13. Хөдөлмөрийн зохицуулалт, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дайчин байдал, ажил тасалдал	7k. Хөдөлмөрийн зохицуулалт ба зөвшөөрөл
14. Геологийн мэдээллийн сангийн чанар (чанар/масштабтай зураг, хүртээмж)	5b. Геологийн мэдээллийн хүртээмж, бэлэн байдал
15. Аюулгүй байдлын түвшин (бие авулгүй байдлыг оруулаад)	Х.Г.
16. Ажиллах хүч, ур чадварын олдоц	5d. Мэргэшсэн ажиллах хүчний олдоц
17. Х.Г.	7b. Тусгай зөвшөөрөл, лиценз авах (тендер, нөхцөл, нэг цэгийн үйлчилгээ)
18. Х.Г.	7c. Хөрөнгө оруулагчид дэмжлэг үзүүлэх үйлчилгээ
19. Х.Г.	7d. Хөрөнгө оруулагчийн маргааныг шийдвэрлэх механизм

# ХАВСРАЛТ 2: ФРЕЙЗЕРИЙН СУДАЛГАА (2011-2017) БОЛОН УУСОТС (2021)-НЫ ХҮСНЭГТ ДЭХ ӨГӨГДЛҮҮД

Нүд тус бүр дэх тоо нь тухайн жилийн судалгаагаар өгсөн үнэлгээний шатлалын (1-5) нийт хариултад эзлэх хувийг илэрхийлнэ.

Үнэлгээний шатлалын утга:

- 1- Хайгуулын хөрөнгө оруулалтыг дэмжихүйц
- 2- Хайгуулын хөрөнгө оруулалтыг саатуулах хүчин зүйл биш
- 3- Хайгуулын хөрөнгө оруулалтыг бага зэрэг саатуулж байна
- 4- Хайгуулын хөрөнгө оруулалтыг зогсоох хүчтэй хүчин зүйл
- 5- Энэ хүчин зүйлээс шалтгаалан энэ улсад хайгуулын хөрөнгө оруулалт хийхгүй

\* Нэг буюу түүнээс дээш асуултад зөвхөн 5-9 хариулт ирсэн (2017 оны Фрейзерийн судалгаа)

\*\* 2021 онд хийсэн УУСОТС-ны асуултын хариултауд (зөвхөн тэргүүлэх оролцогч талуудын)

“Мэдэхгүй” гэсэн хариултаудыг хассан

	Шатлал	2011-2012	2012-2013	2013	2014	2015	2016	2017*	2021**
Ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулах боломж, шилдэг туршлагын бодлого хэрэгжүүлсэн тохиолдолд (5a)	1	70	77	46	50	47	55	50	83
	2	24	14	27	25	24	18	30	17
	3	6	6	22	6	18	18	10	0
	4	0	0	3	13	12	0	10	0
	5	0	3	3	6	0	9	0	0
Геологийн мэдээллийн сан(5b)	1	0	6	5	6	0	0	25	18
	2	30	38	22	25	35	36	50	35
	3	55	41	49	38	35	36	13	24
	4	15	9	19	31	29		13	24
	5	0	6	5	0	0	27	0	0
Дэд бүтцийн чанар (5c)	1	0	0	0	0	0	0	9	11
	2	8	5	13	0	6	9	18	22
	3	47	42	45	37	24	27	18	39
	4	39	45	34	47	59	27	55	17
	5	5	8	8	16	12	36	0	11

Ажиллах хүч, ур чадварын боломж (5d)	1	0	0	0	6	0	0	10	24
	2	15	24	14	6	29	18	40	53
	3	59	49	72	69	65	55	20	12
	4	24	24	11	13	6		20	12
	5	3	3	3	6	0	27	10	0
Татварын горим (7a)	1	3	5	0	5	0	0	9	6
	2	27	14	16	5	24	18	27	11
	3	49	54	45	21	35	27	27	44
	4	16	22	26	42	35	9	18	39
	5	5	5	13	26	6	45	18	0
Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй дүрэм журмын зохицуулалт, тайлбар, хэрэгжүүлэлттэй холбоотой тодорхой бус байдал (7e)	1	15	7	0	5	0	0	10	6
	2	32	12	18	11	0	18	0	0
	3	15	33	21	11	22	18	50	39
	4	19	33	45	37	61	45	40	44
	5	19	14	16	37	17	18	0	11
Байгаль орчны зохицуулалтын тодорхой бус байдал (7f)	1	17	5	8	6	0	0	10	6
	2	34	52	32	39	28	27	40	22
	3	32	26	37	17	33	18	20	44
	4	9	10	18	33	33	45	30	17
	5	9	7	5	6	6	9	0	11
Хууль эрх зүйн тогтолцоо(7g)	1	0	0	0	0	0	9	9	6
	2	23	12	8	6	11	18	0	0
	3	28	39	31	18	39	9	36	35
	4	28	34	46	41	28	45	45	53
	5	21	15	15	35	22	18	9	6
Маргаантай газрын нэхэмжлэлтэй холбоотой тодорхой бус байдал (7h)	1	5	0	0	6	0	0	18	7
	2	35	36	44	22	47	27	27	7
	3	30	33	39	22	12	27	18	47
	4	27	14	8	28	35	18	27	40
	5	3	17	8	22	6	27	9	0
Нийгэм, эдийн засгийн хэлэлцээрүүд / Орон нутгийг хөгжүүлэх нөхцөл (7i)	1	3	0	3	0	0	0	20	0
	2	31	34	33	24	25	18	20	25
	3	49	47	36	41	38	36	30	63
	4	17	16	25	24	31	18	20	13
	5	0	3	3	12	6	27	10	0
Худалдааны саад бэрхшээл(7j)	1	0	0	0	0	0	0	10	7
	2	33	26	22	6	35	36	30	40
	3	58	51	47	47	29	27	30	27

	4	6	11	19	24	35	18	10	20
	5	3	11	11	24		18	20	7
Хөдөлмөрийн зохицуулалт (7к)	1	0	3	3	6	0	0	9	0
	2	35	52	49	29	53	64	64	40
	3	48	33	43	53	35	9	18	53
	4	16	9	3	0	12	0	9	7
	5	0	3	3	12	0	27	0	0
Улс төрийн тогтвортой байдал (7л)	1	3	0	3	0	0	0	9	6
	2	17	6	11	12	13	36	0	18
	3	40	44	46	29	25	36	45	24
	4	29	39	24	35	44	0	45	47
	5	11	11	16	24	19	27	0	6

# ХАВСРАЛТ 3: ХАРЬЦУУЛАХ БОЛОМЖТОЙ УЛС ОРНУУДЫН СУДАЛГААНЫ ХАРИУЛТУУД

Тэмдэглэл:

Баруун Австрали, Чили, Замби улсын мэдээллийн эх сурвалж: Фрейзер институтын Уул уурхайн компаниудын судалгаа, 2020 он, Замби улсын хувьд - Нэг буюу түүнээс дээш асуултад 5-аас 9 хүртэл хариу ирсэн

Монгол улсын мэдээллийн эх сурвалж - УУСОТС, 2021

Монгол улсын хувьд - судалгаанд оролцогчдод уурхайчид, хайгуулчид, санхүүгийн хөрөнгө оруулагчид багтсан

Монгол улсын хувьд - "Мэдэхгүй" гэсэн хариултыг хассан. Фрейзерийн Уул уурхайн салбарын судалгаанд ашигласан хүчин зүйлийн дугаар, УУСОТС-ын дүйцэх асуултыг хаалтанд харуулав.

Нийлүүлэлтийн хүчин зүйлийн талаарх хариултууд

Ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулах боломж, шилдэг туршлагын бодлого хэрэгжүүлсэн тохиолдолд (5a)					
	1 Хөрөнгө оруулалтыг дэмжинэ	2 Хөрөнгө оруулалтыг саатуулах хүчин зүйл биш	3 Хөрөнгө оруулалтыг бага зэрэг саатуулах хүчин зүйл	4 Хөрөнгө оруулалтыг хүчтэй саатуулах хүчин зүйл	5 Энэ хүчин зүйлээс шалтгаалан энэ улсад хайгуулын хөрөнгө оруулалт хийхгүй
Монгол	83%	17%	0%	0%	0%
Баруун Австрали	76%	18%	6%	0%	0%
Чили	44%	41%	15%	0%	0%
Замби	50%	17%	17%	17%	0%

Дэд бүтцийн чанар, Геологийн мэдээллийн сан(5b)					
	1 Хөрөнгө оруулалтыг дэмжинэ	2 Хөрөнгө оруулалтыг саатуулах хүчин зүйл биш	3 Хөрөнгө оруулалтыг бага зэрэг саатуулах хүчин зүйл	4 Хөрөнгө оруулалтыг хүчтэй саатуулах хүчин зүйл	5 Энэ хүчин зүйлээс шалтгаалан энэ улсад хайгуулын хөрөнгө

					<b>оруулалт хийхгүй</b>
<b>Монгол</b>	<b>18%</b>	<b>35%</b>	<b>24%</b>	<b>24%</b>	<b>0%</b>
Баруун Австрали	70%	27%	3%	0%	0%
Чили	33%	56%	7%	4%	0%
Замби	17%	33%	33%	17%	0%

**Дэд бүтцийн чанар (5c)**

	<b>1 Хөрөнгө оруулалтыг дэмжинэ</b>	<b>2 Хөрөнгө оруулалтыг саатуулах хүчин зүйл биш</b>	<b>3 Хөрөнгө оруулалтыг бага зэрэг саатуулах хүчин зүйл</b>	<b>4 Хөрөнгө оруулалтыг хүчтэй саатуулах хүчин зүйл</b>	<b>5 Энэ хүчин зүйлээс шалтгаалан энэ улсад хайгуулын хөрөнгө оруулалт хийхгүй</b>
<b>Монгол</b>	<b>11%</b>	<b>22%</b>	<b>39%</b>	<b>17%</b>	<b>11%</b>
Баруун Австрали	31%	50%	19%	0%	0%
Чили	31%	55%	14%	0%	0%
Замби	0%	67%	17%	17%	0%

**Ажиллах хүч, ур чадварын олдоц (5d)**

	<b>1 Хөрөнгө оруулалтыг дэмжинэ</b>	<b>2 Хөрөнгө оруулалтыг саатуулах хүчин зүйл биш</b>	<b>3 Хөрөнгө оруулалтыг бага зэрэг саатуулах хүчин зүйл</b>	<b>4 Хөрөнгө оруулалтыг хүчтэй саатуулах хүчин зүйл</b>	<b>5 Энэ хүчин зүйлээс шалтгаалан энэ улсад хайгуулын хөрөнгө оруулалт хийхгүй</b>
<b>Монгол</b>	<b>24%</b>	<b>53%</b>	<b>12%</b>	<b>12%</b>	<b>0%</b>
Баруун Австрали	55%	30%	12%	3%	0%
Чили	48%	48%	4%	0%	0%
Замби	0%	50%	50%	0%	0%

**Бодлого, институцын хүчин зүйлийн талаарх хариултууд**

**Татварын горим (7a)**



	<b>1 Хөрөнгө оруулалтыг дэмжинэ</b>	<b>2 Хөрөнгө оруулалтыг саатуулах хүчин зүйл биш</b>	<b>3 Хөрөнгө оруулалтыг бага зэрэг саатуулах хүчин зүйл</b>	<b>4 Хөрөнгө оруулалтыг хүчтэй саатуулах хүчин зүйл</b>	<b>5 Энэ хүчин зүйлээс шалтгаалан энэ улсад хайгуулын хөрөнгө оруулалт хийхгүй</b>
<b>Монгол</b>	<b>6%</b>	<b>11%</b>	<b>44%</b>	<b>39%</b>	<b>0%</b>
Баруун Австрали	31%	56%	13%	0%	0%
Чили	10%	55%	31%	3%	0%
Замби	17%	17%	17%	50%	0%

**Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй дүрэм журмын зохицуулалт, тайлбар, хэрэгжүүлэлттэй холбоотой тодорхой бус байдал (7e)**

	<b>1 Хөрөнгө оруулалтыг дэмжинэ</b>	<b>2 Хөрөнгө оруулалтыг саатуулах хүчин зүйл биш</b>	<b>3 Хөрөнгө оруулалтыг бага зэрэг саатуулах хүчин зүйл</b>	<b>4 Хөрөнгө оруулалтыг хүчтэй саатуулах хүчин зүйл</b>	<b>5 Энэ хүчин зүйлээс шалтгаалан энэ улсад хайгуулын хөрөнгө оруулалт хийхгүй</b>
<b>Монгол</b>	<b>6%</b>	<b>0%</b>	<b>39%</b>	<b>44%</b>	<b>11%</b>
Баруун Австрали	72%	19%	8%	0%	0%
Чили	36%	39%	21%	3%	0%
Замби	0%	43%	29%	29%	0%

**Байгаль орчны зохицуулалтын тодорхой бус байдал (7f)**

	<b>1 Хөрөнгө оруулалтыг дэмжинэ</b>	<b>2 Хөрөнгө оруулалтыг саатуулах хүчин зүйл биш</b>	<b>3 Хөрөнгө оруулалтыг бага зэрэг саатуулах хүчин зүйл</b>	<b>4 Хөрөнгө оруулалтыг хүчтэй саатуулах хүчин зүйл</b>	<b>5 Энэ хүчин зүйлээс шалтгаалан энэ улсад хайгуулын хөрөнгө оруулалт хийхгүй</b>
<b>Монгол</b>	<b>6%</b>	<b>22%</b>	<b>44%</b>	<b>17%</b>	<b>11%</b>
Баруун Австрали	38%	46%	11%	5%	0%
Чили	9%	55%	33%	3%	0%
Замби	14%	43%	14%	29%	0%

**Хууль эрх зүйн тогтолцоо(7g)**

	<b>1</b> Хөрөнгө оруулалтыг дэмжинэ	<b>2</b> Хөрөнгө оруулалтыг саатуулах хүчин зүйл биш	<b>3</b> Хөрөнгө оруулалтыг бага зэрэг саатуулах хүчин зүйл	<b>4</b> Хөрөнгө оруулалтыг хүчтэй саатуулах хүчин зүйл	<b>5</b> Энэ хүчин зүйлээс шалтгаалан энэ улсад хайгуулын хөрөнгө оруулалт хийхгүй
<b>Монгол</b>	<b>6%</b>	<b>0%</b>	<b>35%</b>	<b>53%</b>	<b>6%</b>
Баруун Австрали	56%	39%	6%	0%	0%
Чили	18%	55%	27%	0%	0%
Замби	0%	29%	57%	14%	0%

<b>Маргаантай газрын зөвшөөрөлтэй холбоотой тодорхой бус байдал (7h)</b>					
	<b>1</b> Хөрөнгө оруулалтыг дэмжинэ	<b>2</b> Хөрөнгө оруулалтыг саатуулах хүчин зүйл биш investment	<b>3</b> Хөрөнгө оруулалтыг бага зэрэг саатуулах хүчин зүйл investment	<b>4</b> Хөрөнгө оруулалтыг хүчтэй саатуулах хүчин зүйл investment	<b>5</b> Энэ хүчин зүйлээс шалтгаалан энэ улсад хайгуулын хөрөнгө оруулалт хийхгүй investment due to this factor
<b>Монгол</b>	<b>7%</b>	<b>7%</b>	<b>47%</b>	<b>40%</b>	<b>0%</b>
Баруун Австрали	15%	52%	24%	9%	0%
Чили	14%	59%	24%	3%	0%
Замби	17%	50%	17%	0%	17%

<b>Нийгэм эдийн засгийн хэлэлцээр/Орон нутгийг хөгжлүүлэх нөхцөл (7i)</b>					
	<b>1</b> Хөрөнгө оруулалтыг дэмжинэ	<b>2</b> Хөрөнгө оруулалтыг саатуулах хүчин зүйл биш	<b>3</b> Хөрөнгө оруулалтыг бага зэрэг саатуулах хүчин зүйл	<b>4</b> Хөрөнгө оруулалтыг хүчтэй саатуулах хүчин зүйл	<b>5</b> Энэ хүчин зүйлээс шалтгаалан энэ улсад хайгуулын хөрөнгө оруулалт хийхгүй
<b>Монгол</b>	<b>0%</b>	<b>25%</b>	<b>63%</b>	<b>13%</b>	<b>0%</b>
Баруун Австрали	21%	58%	18%	3%	0%
Чили	12%	54%	23%	12%	0%

Замби	17%	33%	0%	50%	0%
-------	-----	-----	----	-----	----

### Худалдааны саад бэрхшээл(7j)

	1 Хөрөнгө оруулалтыг дэмжинэ	2 Хөрөнгө оруулалтыг саатуулах хүчин зүйл биш	3 Хөрөнгө оруулалтыг бага зэрэг саатуулах хүчин зүйл	4 Хөрөнгө оруулалтыг хүчтэй саатуулах хүчин зүйл	5 Энэ хүчин зүйлээс шалтгаалан энэ улсад хайгуулын хөрөнгө оруулалт хийхгүй
Монгол	7%	40%	27%	20%	7%
Баруун Австрали	42%	48%	9%	0%	0%
Чили	15%	62%	23%	0%	0%
Замби	0%	33%	33%	33%	0%

### Хөдөлмөрийн зохицуулалт (7k)

	1 Хөрөнгө оруулалтыг дэмжинэ	2 Хөрөнгө оруулалтыг саатуулах хүчин зүйл биш	3 Хөрөнгө оруулалтыг бага зэрэг саатуулах хүчин зүйл	4 Хөрөнгө оруулалтыг хүчтэй саатуулах хүчин зүйл	5 Энэ хүчин зүйлээс шалтгаалан энэ улсад хайгуулын хөрөнгө оруулалт хийхгүй
Монгол	0%	40%	53%	7%	0%
Баруун Австрали	36%	48%	9%	6%	0%
Чили	8%	48%	36%	8%	0%
Замби	17%	33%	50%	0%	0%

### Улс төрийн тогтвортой байдал (7l)

	1 Хөрөнгө оруулалтыг дэмжинэ	2 Хөрөнгө оруулалтыг саатуулах хүчин зүйл биш	3 Хөрөнгө оруулалтыг бага зэрэг саатуулах хүчин зүйл	4 Хөрөнгө оруулалтыг хүчтэй саатуулах хүчин зүйл	5 Энэ хүчин зүйлээс шалтгаалан энэ улсад хайгуулын хөрөнгө оруулалт хийхгүй
Монгол	6%	18%	24%	47%	6%
Баруун Австрали	58%	39%	3%	0%	0%
Чили	15%	44%	33%	4%	4%

Замби	0%	50%	17%	0%	33%
-------	----	-----	-----	----	-----

## ХАВСРАЛТ 4: УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН (УУСОТС)

### Оршил

Энэхүү хавсралтад өмнө нь явцын тайланд тусгасан Уул уурхайн салбарын оролцогч талуудын судалгааны үр дүнг тайлбарласан болно. Энэхүү эцсийн тайланг уншигчдад бүрэн мэдээлэл өгөх үүднээс судалгааны үр дүнг энд давтан оруулав.

Энэхүү оролцогч талуудын дунд явуулсан судалгааны мэдээлэл нь цөөн тооны асуултын хариулт, хязгаарлагдмал түүврээс авсан зөвхөн нэг улсад нэг л цаг хугацаанд хамаарах тул үр дүнгийн ач холбогдол, учир шалтгааны хамаарлыг хэмжих боломжгүй юм. Мөн энэ нь Фрейзерийн судалгааны дүн шинжилгээ, тайлангийн үндэс болох гурван индексийн хоёрыг уг мэдээллээр тодорхойлох боломжгүй гэсэн үг юм. Гэхдээ эдгээр мэдээлэл нь Ажлын даалгаврын шаардлагын дагуу "хөрөнгө оруулалтын орчны асуудлуудын урт жагсаалт"-д дүн шинжилгээ хийж, тодорхойлоход хангалттай юм.

Түүврийн бүтэц болон судалгааны оролцогчдын бүрэлдэхүүнийг өмнөх явцын тайланд нэгтгэн харуулсан болно. Үүнд дараах гол дүгнэлтүүдийг тусгасан:

- Оролцогч талуудын жагсаалтад 118 компани, байгууллагыг төлөөлсөн 137 хувь хүн орсон; тэргүүлэх ач холбогдол бүхий оролцогч талууд хувь хүмүүсийн 69%, компани/байгууллагын 67%-ийг эзэлнэ;
- Тэргүүлэх ач холбогдол бүхий оролцогч талуудад уул уурхайн хайгууль, ашиглалтын компаниуд болон санхүүгийн хөрөнгө оруулагчид орно. Бусад оролцогч талууд нь хөрөнгө оруулалтын зөвлөхүүд, салбарын холбоод, Монгол Улсын Засгийн газрын яам/зохицуулагч агентлагууд, хөгжлийн агентлаг, ОУСБ-ууд, гадаадын элчин сайдын яам, худалдааны газрууд, уул уурхайн үйлчилгээний компаниудаас бүрдсэн.
- Нийт 113 оролцогч талыг тодорхойлж судалгааны асуумжийг илгээснээс, 7-д нь хаягийн асуудлаас шалтгаалж хүрээгүй, 32 оролцогч тал (хүрэх боломжтой оролцогч талуудын 30%) хариу ирүүлсэн; 28-д нь дүн шинжилгээ хийсэн.
- Дүн шинжилгээ хийсэн асуулгын 64 хувь, ярилцлагын 83 хувийг тэргүүлэх ач холбогдол бүхий оролцогч талуудаас авсан;
- Ирүүлсэн 32 санал асуулгын хариултыг 2020 онд Фрейзерийн судалгаагаар Монгол Улсын хувьд ирүүлсэн "5-аас бага" хариулттай харьцуулж болно (энэ нь Монгол улсын хувьд судалгааны үр дүнг гаргахад хангалтгүй мэдээлэл байсан). Нийт ирүүлсэн 32 хариултын 28-д нь дүн шинжилгээ хийх боломжтой байв.

Тайлангийн энэ хэсэгт санал асуулгын олон сонголттой, нээлттэй асуултуудад өгсөн хариултуудад хийсэн дүн шинжилгээ, үр дүнгийн хураангуйг тусгасан бөгөөд ярилцлагаар ирүүлсэн зарим саналуудыг оруулав.

Санал асуулгын олон сонголттой хоёр асуулт (асуулт 5, 7) нь Монголын уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт хийх шийдвэрт нийлүүлэлтийн дөрвөн хүчин зүйл, бодлого, институцийн арван хоёр хүчин зүйл хэрхэн нөлөөлж байгааг үнэлэхийг санал асуулгад оролцогчдоос хүссэн асуулт байсан.

Үнэлгээ нь “Уул уурхайн хөрөнгө оруулалтыг дэмжинэ” гэсэн 1 онооноос, “Энэ хүчин зүйлийн улмаас хөрөнгө оруулалт хийхгүй” гэсэн 5 оноо хүртэлх 5 онооны шатлалтай.


#### Нийлүүлэлтийн хүчин зүйлс

Санал асуулгын 5-р асуулт нь нийлүүлэлтийн хүчин зүйлтэй холбоотой бөгөөд дараах дөрвөн чиглэлийг хамарсан:

- 5a. Ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулах боломж
- 5b. Геологийн мэдээллийн хүртээмж
- 5c. Дэд бүтцийн хүртээмж
- 5d. Мэргэшсэн ажиллах хүчний олдоц

Эдгээр дөрвөн асуултын хариултыг Зураг 1, Хүснэгт 3-т нэгтгэн үзүүлэв.

**Зураг 1: Нийлүүлэлтийн хүчин зүйлстэй холбоотой хариултууд  
(бүх хариултад эзлэх %)**



Санал асуулгад оролцогчид бүгд Монгол Улсын *Ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулах боломжийн* талаар эерэг хандлагатай байна: Судалгаанд оролцогчдын 79% нь нийлүүлэлтийн хүчин зүйлс нь хайгуулын хөрөнгө оруулалтыг дэмждэг, 21% нь хөрөнгө оруулалтад саад болохгүй гэж хариулжээ. Энэхүү үр дүнг асуулгад оролцогчид болон ярилцлагад хамрагдсан оролцогч талуудын саналууд дэмжиж байна. Тэдгээрээс дурдвал:

- “Монгол Улсын ашигт малтмалын ордууд нь ашигт малтмалын хамгийн том хэрэглэгчийн дэргэд байгаа нь Монгол улсад хөрөнгө оруулах хамгийн том хүчин зүйл юм.”
- “Монгол Улсын ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулах боломж, геологийн потенциал нь асар их гэдгийг бүгд сайн мэддэг.”
- “Монгол Улс дэлхийн хэмжээний эрлэсийн потенциалтай.”

Бусад оролцогч талуудын хувь (70%)-тай харьцуулахад тэргүүлэх ач холбогдол бүхий оролцогч талуудын илүү их хувь (83%) нь Монгол улсын эрдэсийн потенциал нь уул уурхайн салбарт хөрөнгө оруулахыг дэмждэг гэж үзэж байна (Хүснэгт 3-ыг үзнэ үү).

Геологийн мэдээллийн олдоц, хүртээмжтэй байдлын тухай хариултууд нь 1/Уул уурхайн хөрөнгө оруулалтыг дэмжинэ болон 4/Уул уурхайн хөрөнгө оруулалтыг хүчтэй саатуулж байна гэсэн дөрвөн оноонд хуваагдсан. Ерөнхийдөө хайгуулын ажил хязгаарлагдмал байгаагаас шалтгаалж геологийн мэдээлэл хангалтгүй байх шиг байна. Геологийн үндсэн мэдээлэл байгаа хэдий ч иж бүрэн, нарийвчилсан мэдээллийн олдоц муу, найдвартай биш, газарзүйн байршлын мэдээлэл дутмаг байна. Мөн судалгаанд оролцогчид геологийн мэдээллийн сангаас мэдээлэл авахад хүндрэлтэй, бүх мэдээллийг нэг дор агуулсан байдаггүй гэж хариулсан. Геологийн мэдээллийн талаарх энэ асуултад тэргүүлэх болон бусад оролцогч талууд ижил төстэй хариулт өгсөн.

Сайн чанарын геологийн үндсэн мэдээллийн олдоц тааруу байдгийг тэмдэглэснээс гадна мэдээллийн чанар, хүртээмжтэй байдлын талаархи санал бодлыг тусгажээ. Үүнд:

- “АМГТГ-аас [Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар] геологийн мэдээлэл авахад амаргүй хэдий ч авах боломжтой.”
- “Эрдэс баялаг ихтэй бусад орнуудад байдаг шиг геологийн мэдээлэллийн нэгдсэн мэдээллийн сан байхгүй. Хайгууль хийх хүсэлтэй компаниуд өөрсдөө судалгаа хийж олон төрлийн материалыг олж илрүүлж нэгтгэх шаардлагатай болдог”
- “Хайгуулын үйл ажиллагаа жигдрээгүйгээс геологийн мэдээлэл хангалтгүй байна.”

**Хүснэгт 3: Оролцогч талуудын бүлгүүдээс ирүүлсэн нийлүүлэлтийн хүчин зүйлсийн талаарх хариултууд (нийт хариултад эзлэх %)**

Supply Factors		Scores		
		Total	Priority Stakeholders	Others
5a. Mineral potential	1	79%	83%	70%
	2	21%	17%	30%
	3	0%	0%	0%
	4	0%	0%	0%
	5	0%	0%	0%
	6	0%	0%	0%
5b. Availability and ease of access to geological information	1	18%	17%	20%
	2	36%	33%	40%
	3	21%	22%	20%
	4	18%	22%	10%
	5	0%	0%	0%
	6	7%	6%	10%
5c. Availability of infrastructure	1	14%	11%	20%
	2	18%	22%	10%
	3	32%	39%	20%
	4	29%	17%	50%
	5	7%	11%	0%
	6	0%	0%	0%
5d. Availability of skilled labour	1	18%	22%	10%
	2	46%	50%	40%
	3	21%	11%	40%
	4	11%	11%	10%
	5	0%	0%	0%
	6	4%	6%	0%

Тайлбар: 50 ба түүнээс дээш хувьтай үр дүнг тодруулсан болно

Гурав дахь нийлүүлэлтийн хүчин зүйл болох *Дэд бүтцийн хүртээмжийн* талаарх хариулт хамгийн эерэг бус байна. Энэ нь судалгаанд оролцогчдын талаас бага (32%) хувь нь 1/Уул уурхайн хөрөнгө оруулалтыг дэмждэг эсвэл 2/Уул уурхайн хөрөнгө оруулалтыг саатуулах хүчин зүйл биш; 61% нь дэд бүтцийн хүртээмж нь уул уурхайн хөрөнгө оруулалтыг бага зэрэг эсвэл хүчтэй саатуулах хүчин зүйл гэж үзсэн ганц үзүүлэлт байна. Сүүлийн жилүүдэд гарсан ахицыг тэмдэглэсэн боловч (жишээлбэл, "Дэд бүтцийг тасралтгүй сайжруулж байгаа") дараах бусад саналуудыг ирүүлжээ. Үүнд:

- *"Ихэнх бүс нутагт дэд бүтэц нь хайгуул хийхэд саад болох гол хүчин зүйл биш."*
- *"Дэд бүтэц бусад хөгжиж буй орнуудынхтай харьцуулахад ижил түвшинд байгаа, сайжирч байна."*
- *"Монгол Улсын уул уурхайн салбар ус, эрчим хүчний хангамжтай холбоотой асуудлуудтай тулгарсаар байна."*
- *"Логистик, дэд бүтэц сул байгаа нь үйл ажиллагаа, борлуулалтад тодорхой саад бэрхшээлийг үүсгэдэг."*

*Дэд бүтцийн хүртээмжийн* талаарх тэргүүлэх болон бусад оролцогч талуудын ирүүлсэн хариултууд харилцан адилгүй байна.; Тэргүүлэх оролцогч талуудын ердөө 17% нь, харин бусад оролцогч талуудын 50% нь үүнийг 4/Уул уурхайн хөрөнгө оруулалтыг хүчтэй саатуулах хүчин зүйл гэж үзсэн байна.

*Мэргэшсэн ажиллах хүчний олдоц нь нийлүүлэлтийн дөрвөн хүчин зүйлийн дотроос ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулах боломжийн дараа орох хамгийн өндөр үзүүлэлт юм. Судалгаанд оролцогчдын бараг гуравны хоёр нь 1/Уул уурхайн хөрөнгө оруулалтыг дэмждэг эсвэл 2/Уул уурхайн хөрөнгө оруулалтыг саатуулах хүчин зүйл биш гэж үнэлсэн бол Тэргүүлэх оролцогч талуудын 72% нь, бусад оролцогч талуудын тал нь 1 эсвэл 2 оноог сонгосон байна.*

Ярилцлагын үед өгсөн болон асуулгад бичсэн сэтгэгдлүүд нь Монгол Улсад мэргэжлийн ажиллах хүчний чанар ерөнхийдөө өндөр байгааг онцолж байна. Гэвч ажиллах хүчний нийлүүлэлтийн талаар янз бүрийн саналууд гарч байна. Зарим хүмүүс ажиллах хүчний хүртээмжийг асуудал биш гэж үзэж байгаа бол алслагдсан газар ажиллах хүчнийг ажиллуулах дүрэмтэй холбоотойгоор ажиллах хүчний нийлүүлэлт, зардал төвөгтэй байж болзошгүй гэж зарим судалгаанд оролцогчид үзжээ.

### *Бодлого ба институцийн хүчин зүйлүүд*

Санал асуулгын 7-р асуултад бодлого, институцын хүчин зүйлсийг тусгасан болно. Уг үзүүлэлтэдл хамаарах арван хоёр хүчин зүйл бий. Үүнд:

- 7a. Татварын горим (хувь хүний/аж ахуйн нэгжийн/цалингийн/хөрөнгийн татварын хувь хэмжээ, хайгууль, ашиглалт, үйлдвэрлэгчид нарийн төвөгтэй байдал)
- 7b. Тусгай зөвшөөрөл авах (тендер, нөхцөл, нэг цэгийн үйлчилгээ)
- 7c. Хөрөнгө оруулагчдыг дэмжих үйлчилгээ
- 7d. Хөрөнгө оруулагчдын маргааныг шийдвэрлэх механизм
- 7e. Уул уурхайн зохицуулалтын горим (удирдлага, тайлбар, хэрэгжүүлэлт)
- 7f. Байгаль орчны зохицуулалтын горим (зохицуулалтын тогтвортой байдал; үйл явцын цаг үеэ олсон байдал, тууштай байдал; тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн тодорхой байдал)
- 7g. Хууль эрх зүйн тогтолцоо (үйл явц, ил тод байдал, цаг үеэ олсон байдал, шударга байдал, нэг мөр хэрэгжилт)
- 7h. Газрын маргааны зарга (шийдвэрлэх үйл явц)
- 7i. Олон нийттэй харилцах харилцаа ба үүрэг амлалт (орон нутгийн, худалдан авалт, ажил олголт; Нийгмийн хариуцлага)
- 7j. Худалдаа (импорт/экспортын болон тариф/тарифын бус саад бэрхшээл; валютын хязгаарлалт; ашгийг буцаан шилжүүлэх боломж)
- 7k. Хөдөлмөрийн журам, зөвшөөрөл
- 7l. Улс төрийн тогтвортой байдал, аюулгүй байдал (үйл ажиллагаа, албан тушаалтны).

Эдгээр арван хоёр асуултын хариултыг Зураг 2 болон Хүснэгт 4-т нэгтгэн үзүүлэв. Үр дүнгээс харахад ихэнх хариултууд хөрөнгө оруулалтыг саатуулах байдлыг 3/Уул уурхайн хөрөнгө оруулалтыг бага зэрэг саатуулдаг, 4/Уул уурхайн хөрөнгө оруулалтыг хүчтэй саатуулах хүчин зүйл гэж үнэлсэн байна. Үнэн хэрэгтээ 12 хүчин зүйлийн ердөө зургаад нь нийт судалгаанд оролцогчдын 20 гаруй хувь нь 1/Уул уурхайн хөрөнгө оруулалтыг дэмждэг, эсвэл 2/Уул уурхайн хөрөнгө оруулалтыг саатуулах хүчин зүйл биш гэж хариулжээ. Эдгээр зургаа нь: *Хөрөнгө оруулагчдын маргааныг шийдвэрлэх механизм* (оролцогчдын 4% нь 1 эсвэл 2 гэсэн оноог сонгосон), *Тусгай зөвшөөрөл, лиценз авах* (11%), *Хууль эрх зүйн тогтолцоо* (11%), *Газрын зарга* (11%), *Хөрөнгө оруулагчдыг дэмжих үйлчилгээ* (14%) болон *Уул уурхайн зохицуулалтын горим* (15%) гэсэн үзүүлэлтүүд юм.


Хамгийн сайн үнэлгээ авсан бодлого, институцийн хүчин зүйлүүд нь Худалдаа (оролцогчдын 40 хувь нь 1 эсвэл 2 оноогоор үнэлсэн, Байгаль орчны зохицуулалтын горим (33%), Хөдөлмөрийн зохицуулалт, зөвшөөрөл (32%) тус тус байна.



Бодлого, институцийн хүчин зүйл туу гэсэн дараах дөрвөн сэтгэгдлийг ирүүлжээ. Үүнд:

*Хөрөнгө оруулагчдын маргааныг шийдвэрлэх механизм (санал асуулгад оролцогчдын зөвхөн 4% нь 1 эсвэл 2 гэсэн үнэлгээ өгсөн) оролцогч талуудын аль аль бүлгээс тааруу үнэлгээ авсан. Оюу толгойн зэсийн төслийн талаар Монголын Засгийн газар, Рио Тинто компани хоёрын хооронд өрнөж байгаа маргааны талаар бичсэн сэтгэгдэл, ярилцлагад олонтаа дурдсан. (Хөрөнгө оруулагчид энэ маргаанд аль нэг талыг баримтлахгүй байгаа ч удаан үргэлжилсэн, шийдэгдээгүй маргаан нь дэлхий даяарх хөрөнгө оруулагчдын ойлголтод муугаар нөлөөлдөг гэдэгтэй санал нийлж байна.)*

**Зураг 2: Бодлого, институцийн хүчин зүйлсийн талаар өгсөн хариултууд (бүх санал асуулгад оролцогчдын %)**



**Хүснэгт 4: Оролцогч талуудын бодлого, институцийн хүчин зүйлсийн өгсөн хариултууд (бүх хариултын %)**

Policy and Institutional Factors	Scores			
	1	2	3	4
7a. Taxation regime and practices	7%	6%	10%	0%
	18%	11%	30%	0%
	39%	44%	30%	0%
	36%	39%	30%	0%
	0%	0%	0%	0%
	0%	0%	0%	0%
7b. Obtaining permits and licences	4%	6%	0%	0%
	7%	0%	20%	0%
	32%	33%	30%	0%
	43%	39%	50%	0%
	7%	11%	0%	0%
	7%	11%	0%	0%
7c. Investor support services	0%	0%	0%	0%
	14%	11%	20%	0%
	32%	33%	30%	0%
	36%	33%	40%	0%
	7%	6%	10%	0%
	11%	17%	0%	0%
7d. Investor dispute resolution mechanisms	4%	6%	0%	0%
	0%	0%	0%	0%
	25%	22%	30%	0%
	57%	61%	50%	0%
	11%	6%	20%	0%
	4%	6%	0%	0%
7e. Mining regulatory regime	4%	6%	0%	0%
	11%	0%	30%	0%
	32%	39%	20%	0%
	46%	44%	50%	0%
	7%	11%	0%	0%
	0%	0%	0%	0%
7f. Environmental regulatory regime	4%	6%	0%	0%
	29%	22%	40%	0%
	36%	44%	20%	0%
	21%	17%	30%	0%
	11%	11%	10%	0%
	0%	0%	0%	0%

Policy and Institutional Factors	Scores			
	1	2	3	4
7g. Legal system	4%	6%	0%	0%
	7%	0%	20%	0%
	29%	33%	20%	0%
	54%	50%	60%	0%
	4%	6%	0%	0%
	4%	6%	0%	0%
7h. Land claims	4%	6%	0%	0%
	7%	6%	10%	0%
	36%	44%	30%	0%
	39%	38%	50%	0%
	0%	0%	0%	0%
	0%	6%	10%	0%
7i. Community interaction and commitments	0%	0%	0%	0%
	21%	22%	20%	0%
	43%	56%	20%	0%
	18%	11%	30%	0%
	11%	0%	30%	0%
	7%	11%	0%	0%
7j. Trade	11%	6%	20%	0%
	29%	33%	20%	0%
	29%	22%	40%	0%
	18%	17%	20%	0%
	4%	6%	0%	0%
	11%	17%	0%	0%
7k. Labour regulations and permits	7%	0%	20%	0%
	25%	33%	10%	0%
	50%	44%	60%	0%
	4%	6%	0%	0%
	4%	0%	10%	0%
	11%	17%	0%	0%
7l. Political stability and security	4%	6%	10%	0%
	7%	14%	17%	10%
	18%	22%	10%	0%
	50%	44%	60%	0%
	7%	6%	10%	0%
	4%	6%	0%	0%

Тайлбар: 50% ба түүнээс дээш хувьтай үр дүнг тодруулсан болно

Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн үйл ажиллагаа нь 2016 онд анх байгуулагдсан цагаасаа хойш сул байгааг ч онцолсон. Энэхүү хамгийн муу үнэлгээтэй бодлого, институцийн хүчин зүйлийн талаар дараах гурван нийтлэг саналыг тусгасан байна. Үүнд:

- “Монгол Улсын шүүхэд маргаан шийдвэрлэх процесс нь илт хангалтгүй тул хүлээн зөвшөөрөх боломжгүй хэдий ч Монгол Улсын Засгийн газар олон улсын маргаан шийдвэрлэх механизмаас бүх түвшинд татгалздаг.”
- “Засгийн газартай томоохон маргаан, асуудал гаргаагүй удаа цөөхөн байсан - маргаан шийдвэрлэх үр дүнтэй механизм байдаггүй. Монгол улсын хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчидтай хэрхэн харьцаж ирсэн түүх нь үнэхээр ичмээр”.
- “Энэ салбар удаан үргэлжилсэн маргаанаар дүүрсэн, өндөр нэр хүндтэй компаниуд Монголын эрдэс баялгийн салбарыг орхин гарсан.”

Хууль эрх зүйн тогтолцоо (судалгаанд оролцогчдын зөвхөн 11% нь 1 эсвэл 2 гэсэн үнэлгээг өгсөн) нь зарим талаараа Хөрөнгө оруулагчдын маргааныг шийдвэрлэх механизмтай давхцдаг хүчин зүйл бөгөөд тэргүүлэх болон бусад оролцогч талуудын аль аль нь тааруу оноо өгсөн. Хууль эрх зүйн тогтолцооны үйл явц, ил тод байдал, цаг үеэ олсон байдал, шударга байдал, нэг мөр хэрэглээ зэрэг нь сул байгаа нь уул уурхайн хөрөнгө оруулалтанд саад учруулах хүчин зүйл болж байна гэж үзжээ. Хууль эрх зүйн орчин ойр ойрхон өөрчлөгддөг гэж санал сэтгэгдэл бичих хэсэгт дурджээ. Түүнчлэн:

- “Төрийн болон Монгол Улсын хууль эрх зүйн үйл явцын ил тод, тодорхой байдал нь хэр зэрэг дутмаг вэ гэдгийг сүүлийн хорин жилийн хугацаанд хэт улс төржүүлсэн уул уурхайн салбарын удирдлагаас тод харж болно.”
- “Хууль эрх зүй, зохицуулалт нь тийм ч муу биш хэдий ч хууль дээдлэх зарчим үйлчилдэггүй. Уул уурхайн салбарыг бүх шатанд мөнгө завших амархан бай гэж харж байна”.
- “Хууль тогтоомжийг үзэмжээр хэрэглэдэг явдал нь хамгийн их саад бэрхшээл учруулдаг хүчин зүйл юм. Өөр өөр стандарт нь (нягтлан бодох бүртгэл, татвар, технологи гэх мэт) нь маргаан үүсэхэд хүргэдэг.”

*Тусгай зөвшөөрөл, лиценз авахтай холбоотой хүчин зүйл нь (нийт санал асуулгад оролцогчдын зөвхөн 11% нь 1 эсвэл 2 гэсэн үнэлгээ өгсөн) бодлого, институцийн хамгийн муу үнэлгээ авсан бас нэг хүчин зүйл юм. Гэхдээ, бусад оролцогч талуудтай харьцуулахад тэргүүлэх оролцогч талууд илүү өндөр оноо өгсөн нь уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг зарим этгээд энэ чиглэлээр тодорхой хэмжээний дэмжлэг авч чадна гэдгийг харуулж байна.*

Ярилцлага болон санал сэтгэгдлийн хэсэгт Тусгай зөвшөөрөл, лиценз авахтай холбоотой олон анхаарал татсан санал, сэтгэгдлүүд тусгагдсан. Тэдгээр нь ихэвчлэн тусгай зөвшөөрөл олгох үйл явц, эрх шилжүүлснээс олсон орлогын албан татвартай холбоотой болон хайгуулын тусгай зөвшөөрөл олгохгүй байгаа эсвэл удаашралтай байгаа явдал нь салбарын хөгжилд хэрхэн сөргөөр нөлөөлж байгааг онцолжээ. Шүүмжлэлтэй хандсан сэтгэгдлүүдээс дурдвал:

- *“Тусгай зөвшөөрөл олгох үр дүнтэй тогтолцоо байхгүй байсаар арав гаруй жилийн нүүр үзлээ (үүний улмаасхайгуул хийх газар бараг байхгүй болсон).”*
- *“Шинээр уул уурхайн хайгууль, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэхийг зорьж буй компаниудын хувьд дүүргийн хэмжээний газар эзэмшихэд маш хэцүү, ашиглалтын үе шат руу шилжих бүртгэлийн үйл явц нь хурдан биш (эсвэл Засгийн газраас хялбаршуулах арга хэмжээ аваагүй байна).”*
- *“Хэрэв шинэ төслийн тусгай зөвшөөрөл олгох үйл явц хэрхэн явагддагийг мэдсэн бол Монголд хөрөнгө оруулалт хийхгүй байсан. Монголд маш цөөхөн хүн, ялангуяа чинээлэг, нөлөө бүхий монголчууд дагаж мөрддөг гайхалтай дүрэм журамтай.”*
- *“Тусгай зөвшөөрөл олгох үйл явц нь гадаадын хөрөнгө оруулагчдыг удаашруулж, хувийн ашиг хонжоо олохыг оролдсон механизм юм.”*

*Уул уурхайн зохицуулалтын горимыг (нийт санал асуулгад оролцогчдын зөвхөн 15% нь 1 эсвэл 2 оноогоор үнэлсэн) судалгаанд оролцогчдын бараг тал хувь нь (46%) 4/уул уурхайн хөрөнгө оруулалтыг саатуулах хүчин зүйл гэж үнэлсэн байна. Энэхүү санал асуулгын үнэлгээг олон тооны санал сэтгэгдэл, ярилцлагын үеэр өгсөн мэдээлэл дэмжсэн. Эдгээр санал сэтгэгдлээс харахад нэг мөр бус хэрэглээ, туйлбаргүй байдал, давхар стандарт зэрэг нь уул уурхайн хууль тогтоомжийн хэрэглээ, нэр хүндийг алдагдуулж байна. Үүнд:*

- *“Гол асуудал хуульд биш юм. Хууль ба хууль хэрэгжүүлэх журам хоорондын зөрчилдөөн нь гол саад болдог.”*
- *“Туйлбаргүй зарга нэхэмжлэх, шийдвэр, дүгнэлтийг буцаадаг явдал бас асуудал юм.”*
- *“Монгол Улс геологийн арвин нөөц бололцоотой хэдий ч ил тод бус байдал, дүрмийн байнгын өөрчлөлт, удирдлагын илт давхар стандарт, сүүлийн арав гаруй жилийн хугацаанд бий болсон тогтолцооны авлига зэрэг нь хөрөнгө оруулагчдыг саатуулж байна.”*

### *Дундаж онооны нийлбэр*


Өмнөх хоёр дэд хэсэгт нийлүүлэлтийн хүчин зүйлс болон бодлого, институцийн хүчин зүйлсийн нийт хариултад дүн шинжилгээ хийж онооны шатлал бүрт ирүүлсэн хариултын эзлэх хувийг задаргаагаар тодорхойлсон болно. Энэ дэд хэсэгт 16 хүчин зүйлийн нийлбэр дундаж оноонд дүн шинжилгээ хийлээ. Үүнд оролцогч талуудын бүлгүүдийн дундаж онооны задаргаа, харьцуулалтыг багтаасан болно. Түүнчлэн тэргүүлэх оролцогч талуудын бүлэг доторх оролцогч талуудын дэд бүлгүүдийн хариултаудыг хооронд нь харьцууллаа. Дундаж оноог тооцохдоо 6 дах оноог ("Хариулж чадахгүй эсвэл мэдэхгүй байна") хассан. Иймээс хамгийн бага оноо нь 1 ("Хөрөнгө оруулалтыг дэмжинэ"),

хамгийн өндөр оноо нь 5 (“Энэ хүчин зүйлээс шалтгаалж уул уурхайн хөрөнгө оруулалт хийхгүй”) гэсэн хариулт байна.

Нийлүүлэлтийн хүчин зүйл болон бодлого, институцийн хүчин зүйлсийн нийт дундаж үнэлгээний хураангуйг Зураг 3-т үзүүлэв.

Бүх зүйлсийн дундаж оноог шинжилж үзэхэд нийт хариултаудын задаргаатай ижил төстэй хандлага ажиглагдаж байна. Жишээлбэл, нийлүүлэлтийн дөрвөн хүчин зүйлээс ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулах боломжийг уул уурхайн хөрөнгө оруулалтыг хамгийн их дэмждэг хүчин зүйл гэж үзсэн; бол Бодлого, институцийн хүчин зүйлсээс, Хөрөнгө оруулагчдын маргааныг шийдвэрлэх механизм, Хууль эрх зүйн тогтолцоо, Тусгай зөвшөөрөл, лиценз олгох зэрэг хүчин зүйлс нь Монголд уул уурхайн хөрөнгө оруулалтыг саатуулж буй хүчтэй саад тотгор гэж судалгаанд оролцогчид үзэж байна.

**Зураг 3: Нэгдсэн дундаж үнэлгээ (16 хүчин зүйл, Нийлүүлэлтийн хүчин зүйлсийг улаан өнгөөр, Бодлого, институцийн хүчин зүйлсийг цэнхэр өнгөөр тэмдэглэв), нийт судалгаанд оролцогчдын.**



Судалгаанд оролцогчдын өгсөн дараах оноонуудын дундаж үзүүлэлтийг гаргасан болно. Үүнд:

1. Хөрөнгө оруулалтыг дэмждэг
2. Хөрөнгө оруулалтад саад хүчин зүйл биш
3. Хөрөнгө оруулалтыг бага зэрэг саатуулдаг
4. Хөрөнгө оруулалтыг хүчтэй саатуулдаг
5. Энэ хүчин зүйлээс болж хөрөнгө оруулалт хийхгүй


Нийлүүлэлтийн хүчин зүйл болон бодлого, институцын нийт дундажыг Хүснэгт 5, 6-д үзүүлэв. Таамаглаж буйчлан нийт оноонууд нь дээрх хувийн тархалтыг тусгасан байна.

**Хүснэгт 5: Нийлүүлэлтийн хүчин зүйлсийн нийт дундаж оноо**


All respondents	Average score
5b. Availability and ease of access to geological information	2.96
5d. Availability of skilled labour	2.42
5c. Availability of infrastructure	2.26
5a. Mineral potential	1.21

All respondents	Average score
7d. Investor dispute resolution mechanisms	3.74
7g. Legal system	3.48
7b. Obtaining permits and licences	3.46
7e. Mining regulatory regime	3.43
7c. Investor support services	3.40
7l. Political stability and security	3.37
7h. Land claims	3.29
7i. Community interaction and commitments	3.19
7f. Environmental regulatory regime	3.07
7a. Taxation regime and practices	3.04
7j. Trade	2.72
7k. Labour regulations and permits	2.68


Нийлүүлэлтийн хүчин зүйлсийн дундаж оноог оролцогч талуудын бүлгээр харьцуулсаныг Зураг 4-т, Тэргүүлэх бүлэгт хамаарах оролцогч талуудын дэд бүлгүүдээр харьцуулсаныг Зураг 5-д үзүүлэв. Оролцогч талуудын хоёр бүлгийн бодлого, институцийн хүчин зүйлсийн дундаж оноог хооронд нь харьцуулахад (Тэргүүлэх оролцогч талуудын бүлэг болон бусад бүлэг) (Зураг 6) бодлогын хөрөнгө оруулагчдын маргааныг шийдвэрлэх механизм, Олон нийтийн харилцаа, үүрэг амлалт, Улс төрийн тогтвортой байдал, аюулгүй байдал зэрэг гурван хүчин зүйлийн хувьд бусад оролцогч талуудын бүлгийн судалгаанд оролцогчид тэргүүлэх оролцогч талуудаас хамаагүй өндөр оноо өгсөн болохыг харуулж байна. Үүнийг зарим талаараа Оюутолгойн маргаан зэрэг хөрөнгө оруулагчдын маргааныг хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацах явдал, баялгийг өмчирхөх үндсэрхэг үзэл, Засгийн газар, бодлогын стратеги байнга солигдох зэрэгтэй холбоотойгоор бий болсон бусад оролцогч талуудын төсөөлөлтэй холбон тайлбарлаж болно. Чухамдаа зарим нэг тэргүүлэх оролцогч талууд орон нутгийн иргэлийн харилцаа заримдаа саал учруулж тапаар дорьдсан ч ихэнх нь орон нутгийн түвшин,



**Зураг 5: Нийлүүлэлтийн хүчин зүйлийн дундаж оноо, Оролцогч талуудын дэд-бүлгээр**




**Зураг 6: Бодлого, институцын хүчин зүйлийн дундаж оноо, Оролцогч талуудын бүлгээр**



Хэрэв өмнө нь дүн шинжилгээ хийхдээ оролцогч талуудын бүлгүүдийн нийт оноо, задаргааг голчлон авч үздэг байсан бол 7-р зурагт хайгууль, ашиглалтын компаниуд болон санхүүгийн хөрөнгө оруулагчдын санал мэдэгдэхүйц ялгаатай эсэхийг илрүүлэхийн тулд тэргүүлэх оролцогч талуудын

бүлэг доторх оролцогч талуудын дэд бүлгүүдээр онооны задаргааг гаргасан болно. Ингэхдээ бид зөвхөн бодлого, институцийн хүчин зүйлсийг л авч үзсэн.

**Зураг 7: Тэргүүлэх оролцогч талуудын Бодлого, институцийн хүчин зүйлийн дундаж оноо, Оролцогч талуудын дэд бүлгүүдээр**



Хайгуулын компанийн төлөөлөгчид *Татварын горим ба практик, Тусгай зөвшөөрөл, лиценз авах, Хөрөнгө оруулагчдын маргааныг шийдвэрлэх механизм* зэрэг бодлогын гурван хүчин зүйлд хамгийн өндөр оноо өгсөн нь эдгээр нь уул уурхайн хөрөнгө оруулалтыг саатуулах хүчтэй хүчин зүйл болохыг харуулж байна. Ярилцлагын үеэр олон хайгуулын компаниуд лиценз шилжүүлсэний татвар нь (нэг бүлгийн компаниудын охин компаниудын хооронд лиценз шилжүүлсэн ч ногдуулдаг) томоохон саад учруулдаг гэж дурьдсан. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ялангуяа зэс, нүүрсний төлбөрийг өрсөлдөхүйц биш гэж олон судалгаанд оролцогчид хүлээн зөвшөөрдөг ч уул уурхайн компаниудын дэд бүлэгт ихэвчлэн алтны компаниуд багтдаг бөгөөд энэ нь хайгуулчидтай харьцуулахад харьцангуй энэ хүчин зүйлд бага оноо авахад нөлөөлсөн байж магадгүй юм. Хайгуулын компаниудын онцлогоос шалтгаалж тэдний хувьд тусгай зөвшөөрөл, лиценз авах нь уул уурхайн компани, санхүүгийн хөрөнгө оруулагчидтай харьцуулахад илүү чухал бололтой.

Уул уурхайн компаниуд *Уул уурхайн зохицуулалтын горим, Хөрөнгө оруулагчдыг дэмжих үйлчилгээ, Хууль эрх зүйн тогтолцоо, Олон нийтийн харилцаа, үүрэг амлалт* зэрэг хүчин зүйлст бусад хоёр дэд бүлгээс илүү өндөр оноо өгсөн байна. Эдгээр нь уул уурхайн компаниудын үйл ажиллагаанд эдгээр хүчин зүйлс хэр ач холбогдолтой болохыг тусгаж, баталж байна.

Санхүүгийн хөрөнгө оруулагчид *Худалдаа, хөдөлмөрийн зохицуулалт, зөвшөөрөлийг бусад оролцогч талуудын дэд бүлгээс илүү хөрөнгө оруулалтыг саатуулахуйц хүчин зүйл* гэж үзсэн. *Худалдааны* хүчин зүйлд валютын арилжаа, ашгийг шилжүүлэхтэй холбоотой хязгаарлалт багтсан нь зөрүү үүсэхэд нөлөөлсөн байх төлөвтэй.

